ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2020 ОНЫ 6-Р САР

Лиахона

1829 оны илчлэлтийн үйл явдлууд

12-р хуудас

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд маань баптисм хүртэхэд бэлэн болов уу? 18-р хуудас

Хоолны харшил: Сүмийг илүү аюулгүй газар болгох нь, 22-р хуудас

Хөгжлийн бэрхшээлээр нь бус, чадвараар нь тодорхойл, 28-р хуудас

СҮМ
ЭНД
БИЙ

АНУ-ын Пеннсил
Оакланд хотхон

ьванийн

Санваарыг сэргээсэн газарт байдаг энэ байшин Хармони дахь Иосеф, Эмма хоёрын сэргээн засварласан байшин бөгөөд одоо Оакланд хотхон гэж нэрлэгддэг.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЛЭСЛИ НИЛССОН

10 — Скрантон Пеннсильвани гадсан дахь Сасквиеханна салбарыг оролцуулсан нийт тойрог, салбар

160 — Санваарыг сэргээсэн газраас Палмирагийн Нью-Йорк ариун сүм хүртэлх км

15 — Сургаал ба Гэрээнд гардаг, Пеннсильванийн Хармонид хүлээн авсан илчлэлт

70 — Иосеф, Эмма хоёрын гэрт орчуулагдсан Мормоны Номын хувь ойролцоогоор

1804 Эмма Хэйл (хожим нь Иосеф Смиттэй гэрлэсэн) Хармонид төрсөн.

1829 Иохан Баптист Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Аароны санваар хүртээв. Хожим нь Петр, Иаков, Иохан гурав тэдэнд Мелкизедик санваар хүртээсэн.

1960 Санваарын сэргээлтийг дурсан хүндэтгэсэн хөшөө энэ газарт баригдсан.

2015 Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон Санваар сэргээгдсэн газрыг онцгойлон адисалсан.

Сүмийн түүхэн газруудын талаар **history.ChurchofJesusChrist.org** хаягаар орж илүү ихийг мэдэж авна уу.

Ариун ёслолын цуглаанаар дамжуулан тохинуулах
8

Сэргээлт дэх санваарын чухал үүрэг
Ахлагч Гари И.Стивэнсон
12

Сүм дээр хоолны харшлыг зохицуулах нь
Лиса Анн Томсон
22

Тусгай хэрэгцээ ба онцгой сургамж
Ахлагч Паул Б.Пиепэр, Мэлисса Т.Пиепэр
28

Баптисм хүртэх шийдвэр

Сүүлийн үед нөхөр бид хоёр долоон настай хүүгээ баптисм хүртэхэд бэлэн эсэхийг шийдвэрлэхээр хичээж байв. Хүү маань аутисмтай тул бид түүнийг энэ шийдвэртээ хариуцлага хүлээнэ гэдгээ хангалттай ойлгож байгаа эсэхийг сайн мэдэхгүй байв. Та 18-р хуудаснаас бидний зөв шийдвэр гаргах гэж хичээх үедээ авч үзсэн олон зүйлийн талаар олж унших болно.

Би Сүмийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцсан мэргэжилтний хувьд хөгжлийн бэрхшээлтэй, олон гайхалтай хүмүүс сүм дээр өөрсдийн оролцоог мэдрэхийг хүсдэгийг мэднэ. Бид янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй ах, эгч нар болон тэдний гэр бүлд хандан, бид танд хайртай, та бидэнд хэрэгтэй, бид танд илүү сайн тохинуулж сурахыг хүсэж байна гэж хэлдэг.

Энэ дугаарын хэд хэдэн нийтлэл хөгжлийн бэрхшээлийн талаар болон бид тойрог, орон нутагтаа хэрхэн тэдний оролцоог нэмэгдүүлэх талаар мэддэг болоход маань тусална. Тухайлбал:

- 28-р хуудас: Далын ахлагч Паул Б.Пиепэр, түүний эхнэр Мэлисса хоёр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бөгөөд эцэг эхчүүдэд найдвар, урам зориг өгдөг.
- 21-р хуудас: Миний нийтлэлийн сүүл хэсгээс та хөгжлийн бэрхшээлтэй гишүүдийг Сүмийн хичээл, дуудлагад хэрхэн илүү сайн дасан зохицуулах талаарх санаануудыг олж аваарай.
- Н16 хуудас: Эцэг эхчүүд *Найз* сэтгүүлийн энэ түүхийг ашиглан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй найз болох үлгэр жишээг олж харахад хүүхдүүддээ тусалж болно.

Та энэ дугаарыг уншиж байхдаа “Бодгалийн үнэ цэнэ Бурханы мэлмийд агуу” (Сургаал ба Гэрээ 18:10) гэдгийг санаарай. Ирж мөн Есүстэй адил болохыг хүссэн хэн боловч энэ боломжийг хүртэж болохын тулд бид хайраар дүүрэн, бүгдийг оролцуулсан гэр орон, Сүмийн орчныг бий болгон тусалж чадна.

Хүндэтгэсэн,

Кэти Эдна Стийд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Санваар, гэр бүлийн хэлтэс

Гарчиг

5 Аароны санваарын сэргээлт

6 Итгэлийн хөрөг
Лини Уйлау
Лини их уурладаг байв. Гэвч Есүс Христийн сайн мэдээ түүнд уур уцаараа амар амгалангаар солиход тусалсан.

8 Тохинуулын зарчмууд
Ариун ёслолын цуглаанаар дамжуулан тохинуулах
Ариун ёслолын цуглаан бидэнд бусадтай холбогдож, тэдэнд тохинуулах боломж олгодог.

12 Сэргээлт дэх санваарын чухал үүрэг
Ахлагч Гари И.Стивэнсон
Санваар дэлхийд эргэн ирсний ачаар Сэргээлт үргэлжлэх боломжтой болсон.

18 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд маань баптисм хүртэхэд бэлэн болов уу?
Кэти Эдна Стийд
Хүү маань найман нас хүрэх гэж байв. Гэвч бид түүнийг баптисм хүртэхэд бэлэн эсэхийг хэрхэн мэдэх билээ?

22 Сүм дээр хоолны харшлыг зохицуулах нь
Лиса Анн Томсон
Бид заримдаа хоол хүнсээр дамжуулан хайраа харуулдаг. Хоол хүнсний ноцтой харшилтай тохиолдолд хоол хүнс *байхгүй байх нь* бас хайрын илрэл болж болно.

28 Тусгай хэрэгцээ ба онцгой сургамж
Ахлагч Паул Б.Пиепэр, Мэлисса Т.Пиепэр
Бидний охин тусгай хэрэгцээтэй нэгэн байв. Бид төсөөлж байснаасаа хавьгүй их зүйлийг түүнээс сурсан юм.

32 Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
Нэгэн багш бошиглогчийн дуу хоолойг санаанд оромгүй газарт олж сонсов; нэг залуу ажил, сайн мэдээ хоёрын аль нэгийг сонгов; нэгэн хос төрөөгүй хүүхдийнхээ аюулгүй байдлын төлөө залбирчээ; нэг эрэгтэйн зүрх сэтгэл ариун сүмд очсоноор нээлттэй болсон байна.

36 Бидний гэр орон, гэр бүл
Хайрын бэлэг
Фэйт С.Вотсон
Нөхрийн маань бяцхан охиндоо өгсөн санваарын эрхэм адислалаас би Тэнгэрлэг Эцэгийн хайрыг бидэнд зориулсан бэлэг гэж үзэх болсон юм.

38 Ирээд, Намайг дага: Мормоны Ном
Долоо хоног тутмын эдгээр нийтлэл энэ сард Мормоны Номоос судлах үйл явцыг тань дэмжих болно.

Богино өгүүллүүд

Ирээд, Намайг дага дэмжлэг

Хавтсан дээр
Миний нөхөд үйлчлэгч та нарт,
Линда Кэрли Кристэнсэн,
Майкл Малм

Хэсгүүд

Залуучуудад зориулав
42
Болзооны амьдралаа зохицуулах нь аймшигтай байж болно, гэхдээ тийм байх шаардлагагүй. **Мөнхийн хании олох явцдаа стрес-сээс ангид байсан** залуучуудын түүхээс унши-на уу.

Өсвөр үеийнхэнд зориулав
50
Залуу эмэгтэйчүүдийн байгууллагын түүхийн талаар мэдэж ав.

Хүүхдүүдэд зориулав
Найз
Абишийн талаар **мэдэж авч,** герман **найзуудтай танилцаарай.**

6-Р САРД ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД



Түүнд санваарын адислал хэрэгтэй байв. Би үүнийг хийж чадах болов уу?
О'Дэйл Жоннсон

Нэг залуу санваарын адислал өгөх айдсаа хэрхэн даван туулснаа хуваалцсан юм.

Охиныхоо хөгжлийн бэрхшээлээс үүдэн миний ач ивээлийн талаар сурсан зүйл
Жэффри С.Макклэллан

Нэгэн эцэг Есүс Христийн ач ивээл нөхцөл байдалд нь хэрхэн итгэл найдвар өгсөн талаар ойлголт өгсөн.

Хоёр дахь сэтгэгдэл болон Сүнсний удирдамжид найдах нь
Мари Нетцлер

Австралийн нэг насанд хүрэгч хэн нэгэнд хоёр дахь боломжийг олгосон нь амьдрал нь бүх зүйлийг өөрчилсөн талаар хуваалцав.

Ганц бие байх нь Бурханы надад зориулсан *бүрэн* төлөвлөгөөнд найдахыг сануулдаг
Кристина Коттерэлл

Нэгэн ганц бие залуу аливаа зүйл санаснаар болохгүй байгаа үед хэрхэн шинэ итгэл найдвар олж авснаа хуваалцсан.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон liahona.ChurchofJesusChrist.org вэбсайтаас дараах зүйлсийг дагаж чадна. Үүнд:

- Энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийн түүх, санал хүсэлтийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад бэлэг болгон захиалж өг.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар суралцах үйл явцаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, видео бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл хэвлэ.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал хүсэлтээ liahona@ChurchofJesusChrist.org хаягаар илгээнэ үү.

Өөрийн түүхийг liahona.ChurchofJesusChrist.org вэбсайт руу эсвэл доорх хаягаар шуудангаар илгээнэ үү.
Liahona, flr. 23
50 E. North Temple Street
Salt Lake City, UT, 84150-0023, USA

2020 ОНЫ 6-Р САРЫН ДУГААР
БОТЬ, 21, №3
Лиахона 16721 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рассэлл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Гонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Рэнди Д.Фанк

Зөвлөхүүд: Бэкки Кравэн, Шэрон Эубанк, Кристина Б.Франко, Уолтэр Ф.Гонзалэз, Ларри С.Кэйчэр, Жан Э.Ньюмэн, Адриан Очао, Майкл Т.Ринвүүд, Верн П.Стэнфилл

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Камилла Кастрион

Редакцийн баг: Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Гаррэтт Х.Гарфф, Жон Райн Жэнсэн, Аарон Жонстон, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мөрдок, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороү, Ричард М.Ромни, Минди Сэлү, Лори Фүллэр Соса, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд: Жинэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндий Бэнтли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Алэни Рэжэр, Марк В.Робисон, К.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэтт Нэбэкэр Аун

Хэвлэлийн менежер: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэн Адэйр, Жюли Бөрдэтт, Жосэ Чэвиз, Томас Ж.Кронин, Брайн В.Гайги, Жинни Ж.Нилсон, Мэррисса М.Смит

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Баркэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.ChurchofJesusChrist.org руу; шуудангаар *Liahona,* Fl. 23,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0023, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ChurchofJesusChrist.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португал, румын, свахили, самоа, себү, словени, солонгос, сингал, тагалог, тай, тамил, тахити, телуг, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2020 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцээндээ *Лиахона* гаас материал хувилан авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн cor-intellectualproperty@ChurchofJesusChrist.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: June 2020 Vol. 21, No. 3. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.50 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.ChurchofJesusChrist.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.



Ааароны санваарын сэргээлт

1829 оны 5-р сарын 15-нд Иохан Баптист Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Аароны санваар хүртээсэн. Энэ чухал өдрийн талаарх тэдний дурсамжуудыг багтаасан дараах эшлэлүүд ямар гайхалтай үйл явдал байсныг харуулдаг.

"Энэ удаа бидэн дээр айлчлан ирж, бидэнд энэхүү санваарыг хүртээсэн мөнөөх тэнгэр элч, **Шинэ Гэрээн дээрх Иохан Баптист гэж нэрлэгддэг тэрхүү Иохан хэмээх нэрээ** хэлж, мөн Мелкезидек санваарын түлхүүрүүдийг атгадаг Петр, Иаков, Иохан нарын удирдлаган доор ажиллаж байгаагаа хэлэв.

Иосеф Смит, Иосеф Смит—Түүх 1:72 дээрх Иосеф Смит; тодотгол нэмэгдсэн



1836 онд Көртландын ариун сүмд санваарын түлхүүрүүд сэргээгдэх үед Оливер Каудери Иосеф Смиттэй хамт байсан.

"Мөнх оршихуйн гүнээс **Аврагчийн дуу хоолой бидэнд амар амгаланг ярьж байхад, хөшиг хуваагдан мөн алдар суугаар хувцасласан Бурханы тэнгэр элч доош бууж ирэн,** хүсэмжлэн байсан мэдэгдлийг болон наманчлалын Сайн мэдээний түлхүүрүүдийг хүргэн ирэв. Ямар гайхамшиг! Ямар гайхалтай вэ!"

Оливер Каудери, Иосеф Смит—Түүх 1:71, тайлбар; тодотгол нэмэгдсэн

Есүс Христэд баптисм хүртээж буй Иохан Баптистыг харуулсан Библийн видео дүрслэл



Иосеф Смит, Оливер Каудери хоёрын 1829 оны 5-р сарын 15-нд баптисм хүртсэн Пеннсильванийн Хармонийн ойролцоох Сасквиеханна гол

Санваарын сэргээлт ба санваарын чухал үүргийн талаар ихийг мэдэж авахын тулд 12-р хуудсан дээрх Сэргээлт дэх санваарын чухал үүрэг сэдэвтэй ахлагч Гари И.Стивэнсоны нийтлэлийг үзнэ үү.

МИНИЙ НӨХӨД ҮЙЛЧЛЭГЧ ТА НАРТ, ЛИНДА КӨРЛИ КРИСТЭНСЭН, МАЙКЛ МАЛМ
САСКВИЕХАННА ГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГ, БРАД ВОКЭР СТИВЭНС

Лини Уйлау

Самоагийн Савай

Лини уур уцаар, тэвчээргүй байдалтай-гаа тэмцдэг байв. Лини нөхөртэйгөө Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнт-нүүдийн Сүмд нэгдсэн ба сайн мэдээний дагуу амьдарснаар эдгээр мэдрэмж нь алга болсныг мэджээ.

ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН

Би сайн мэдээг судалж эхлэн, Сүмийн сургаалаар дамжуулан Есүс хүүхдүүдийг хэрхэн хайрладаг байсныг мэдэж авсан. Тэр тэдэнд ямагт сайхан ханддаг байсан.

Би Есүстэй адил байхыг хичээж эхэлсэн. Би одоо гэр бүлийнхээ бүх гишүүнийг илүү их хайрлахыг хичээдэг болсон. Би тэдэнтэй хамт байж, хэрэгцээг нь олж мэдэхэд илүү их цаг зарцуулдаг болсон. Бид орой болгон гэр бүлээрээ судраас уншиж, хамтдаа залбирдаг.

Миний зүрх сэтгэл одоо их зөөлөрсөн. Бид Есүс Христийн сургаалуудыг дагаснаар би гэр орондоо илүү их хайр, амар тайван, аз жаргалыг мэдэрдэг болсон. Сайн мэдээ хэрхэн илүү сайн эхнэр, ээж, эмээ болох талаар сурахад маань тусалж байгаад би талархдаг.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД
Линигийн итгэлийн түүхийн талаар илүү дэлгэрэнгүй мэдэж авч мөн өөр зурагнууд харахыг хүсвэл энэ нийтлэлийн цахим буюу Gospel Library дээрх хувилбарыг **ChurchofJesusChrist.org/go/6206** дээрээс үзнэ үү.

Ахлагч Нийл Л.Андэрсэн Их Эзэнийг хайрлах хайр маань биднийг илүү сайн болоход хэрхэн өдөөдөг талаар юу гэж заасныг **ChurchofJesus Christ.org/go/6207** дээрээс уншина уу.

Тохинууллын зарчмууд

АРИУН ЁСЛОЛЫН ЦУГЛААНААР ДАМЖУУЛАН ТОХИНУУЛАХ

Ариун ёслолын цуглаан нь бусадтай холбогдож, бусдад тохинуулах боломж олгодог.

Ариун ёслолын цуглаан нь сүнслэг тэжээл авч, Аврагчийг болон Түүний Цагаатгалыг хувьдаа эргэцүүлэн бодох цаг мөч юм. Бид долоо хоног бүр ариун ёслолоос хүртсэнээр хамтдаа сэнхэрдэг (Сургаал ба Гэрээ 84:110-ыг үзнэ үү). Харин манай тойрог, салбаруудын зарим хүн маш хүнд дарамттай ирдэг эсвэл бүр ирдэггүй.

Бид энэ ариун нандин цагийг хэрхэн бусдад тохинуулж, тэдний амьдралыг өөрчлөхөд ашиглаж болох талаарх хэдэн боломжийг энд дурдав.

АРИУН ЁСЛОЛЫН ЦУГЛААНЫГ ИЛҮҮ УТГА УЧИРТАЙ БОЛГОХОД НЬ ТОХИНУУЛДАГ ХҮМҮҮСТЭЭ ТУСАЛ

Хэрхэн тохинуулахаа мэдэж авах эхний алхам бол хувь хүн, гэр бүлүүд ба тэдний хэрэгцээг таньж мэдэх явдал юм. Та тэдний талаар илүү ихийг мэдэж авснаар ариун ёслолд оролцохдоо илүү сайн шүтэн биширдэг болоход нь тэдэнд тусалж чадах арга замууд гарч ирж болно.



ЗУРГИЙГ ЭДВАРД МАКГОВАН

Хөлд орж буй ихрүүдийн залуу эх Миндигийн хувьд, тохинуулагч эгчийнх нь энгийн хүчин чармайлт долоо хоног тутам ариун ёслолын цуглаанд оролцох байдлыг нь ихээхэн өөрчилсөн байна.

"Нөхрийнхөө ажлын хуваариас болоод би долоо хоног бүр ихэр охидоо ганцаараа сүм рүү авч очдог" гэж Минди тайлбарлав. "Хөлд орж байгаа, хоёр хөдөлгөөнтэй хүүхэдтэй ариун ёслолын цуглааныг дуусгана гэдэг үнэхээр халширмаар байдаг ч тохинуулагч эгч маань надад туслах үүргийг өөртөө хүлээсэн юм.



Тэр долоо хоног бүр бидэнтэй сууж, охидоо харж хандахад минь тусалдаг. Тэр зүгээр л миний хажууд суухад надад тустай байдаг бөгөөд хүүхдүүдийг уурлаж, үймүүлэх мөчид санаа зовних маань гайгүй болдог. Түүний үйлдэл амьдралын минь энэ үед надад хэчнээн их нөлөөлснийг тэр мэдэж авна гэж би бодохгүй байна. Тэр залуухан, сэтгэл түгшсэн эх хүний хэрэгцээг надаас олж харсан ба сүмийг бүх хүнд амар тайван, аз жаргалтай газар болгоход тусалдаг."

Тусгай хэрэгцээтэй хүмүүст туслах санаанууд

- Гишүүдийн хэрэгцээний талаар ахлагчдын чуулгын болон Халамжийн нийгэмлэгийн удирдагчидтай зөвлөлд.
- Удирдагчид гишүүдийн хэрэгцээг хангахад туслах ариун ёслолын цуглааны үгсийг төлөвлөнө. Тохинуулдаг хүмүүст тань ямар нэг тодорхой захиасыг олж сонсох нь тус болохоор байвал энэ санаагаа удирдагчдадаа хэл.
- Хэрэв та хэн нэгнийг ариун ёслолын адислалуудыг хүлээн авахад саад бэрхшээлтэй байдаг юм уу хоол хүнсний харшилтайг мэддэг бол тэднээс тодруулж мөн тэдний шүтлэг бишрэлийг нэмэгдүүлэхийн тулд ямар зохицуулалт хийж болох талаар асуу. Энэ мэдээллээ удирдагчдаа хэлнэ үү.[1]
- Таны тохинуулдаг эсвэл таньдаг хүн тань түр болон байнга гэрээсээ гарч чадахгүй байгаа бол тэдний гэрт ариун ёслолыг хүргэж өгч болох талаар бишопоосоо асуу. Та ариун ёслолын цуглааны үеэр тэмдэглэл хөтөлж, үүнийгээ тэдэнтэй утсаар, э-мэйлээр юм уу биечлэн хуваалцаж болно.
- Хэрэв таны тохинуулдаг хүн бага насны хүүхэдтэй бол та ариун ёслолын цуглааны үеэр тэдэнд туслахыг санал болгож болно.
- Хэрэв таны тохинуулдаг хүн ариун ёслолын цуглаандаа байнга ирдэггүй бол та ойлгохыг хичээж, тусалж болох арга замуудыг бодож үзээрэй. Хэрэв тэдэнд унаа хэрэгтэй бол та тэднийг авч явж болно. Хэрэв тэднийг гэр бүл нь дэмждэггүй бол та тэднийг дэргэдээ суухад урьж болно. Та тэдэнд ариун ёслолын цуглаан дээр дотно байхыг болон хэрэгцээгээ мэдрэхэд нь туслахыг хүсвэл тусгай урилгууд хийж болно.

ЭНГИЙН ҮЙЛДЭЛ ТОМ НӨЛӨӨ ҮЗҮҮЛДГИЙГ САНААРАЙ

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Жийн Б.Бингам эгч тохинууллын талаар "Заримдаа бид хөршдөө үйлчлэхийн тулд ямар нэг агуу бөгөөд баатарлаг үйлс бүтээх ёстой гэж боддог. Гэвч үйлчлэлийн энгийн үйлдлүүд нь бусдад болон өөрсдөд маань хүчирхэг нөлөө үзүүлж чадна"[2] хэмээн заасан юм.

Бельгийн жижиг тойрогт Эвита Сүмийн цуглаан дээр испани хэлтэй зочдод болон гишүүдэд олонтоо орчуулга хийж өгдөг байв. Нэг удаа Эвита Сүмийн талаар суралцаж байсан Доминиканы Бүгд Найрамдах улсын иргэнтэй танилцав. Тэр англи хэл бага зэрэг мэддэг ч төрөлх хэл нь испани хэл байв. Эвита түүнд ариун ёслолын цуглаан дээр аяархан орчуулж өгсөн тул илүү тухтай санагджээ.

"Заримдаа орчуулга хийх нь Хүндэтгэлийн өдрийг минь зав чөлөөгүй болгодог. Гэхдээ хүмүүсээс хэлмэрч хэрэгтэй эсэхийг асуух сүнслэг өдөөлтийг дагах нь Сүнсийг мэдэрч, цуглаанаа сайхан өнгөрүүлэхэд нь тэдэнд туслах боломжтой байгаагаа мэдэх нь надад маш их баяр баясгалан, халуун дулаан мэдрэмжийг өгдөг" гэжээ.



Энгийн үйлдлүүдээр дамжуулан туслах санаанууд

- Ариун ёслолын цуглаан дээр хэнд илүү үйлчлэл хэрэгтэй байгаа талаар удирдагчидтайгаа ярилц. Эсвэл хэрэв та үйлчлэл хэрэгтэй хэн нэгнийг мэдэж байвал удирдагчид тань тэдний талаар мэдэж байгаа эсэхийг нягтал.
- Цуглаан эхлэхийг хүлээн чимээгүй суу. Энэ нь ариун газарт хүндэтгэлтэй байснаар ирж болох амар амгалан хэрэгтэй байгаа "бидний эргэн тойрны эмтэрсэн зүрх, уй гашууд автсан сүнснүүдэд"[3] туслах болно.
- Мацгийн ням гарагт тайвшрал хэрэгтэй байгаа, өөрийн тохинуулдаг хэн нэгний төлөө мацаг барьж, залбирахыг бодоорой.
- Ариун ёслолын үеэр тэдний хажууд эсвэл ойр сууснаар тус болж чадах хэн нэгэн байгаа эсэхийг мөн танд тусалж болох өөр арга байгаа эсэхийг мэдэхийг хүсэн залбир.

Ариун ёслолын цуглаанд оролцож буй хүн бүр халуун дулаан мэдрэмж мэдэрч, сүнслэг тэжээл авах нь чухал юм.

АРИУН ЁСЛОЛЫН ЦУГЛААН БОЛ БҮГДИЙГ УРЬЖ БОЛОХ ГАЗАР ЮМ

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972) "Ариун ёслолын цуглаан бол сүмийн бүх уулзалтуудаас хамгийн нандин, хамгийн ариун нь"[4] хэмээн заасан. Иймээс ариун ёслолын цуглаанд оролцож байгаа бүх хүн, ялангуяа шинэ гишүүд юм уу хэсэг хугацаанд сүмдээ ирээгүй хүмүүс халуун дотно хийгээд, сүнслэг тэжээл мэдэрдэг байх нь чухал байдаг.

Австралийн Шинэ Өмнөд Вэльсийн Мерания тойрог дээрээ Сүмийн тухай сурч байсан нэгэн эмэгтэйтэй нөхөрлөсөн байна. "Тэр одоо миний дотны найзуудын нэг болсон" гэж Мерания хэлэв. "Би долоо хоног бүр түүнтэй ариун ёслолын цуглаанд суух дуртай бөгөөд түүний хэр байгааг, түүнд туслах зүйл байгаа эсэхийг үргэлж асуудаг." Хэсэг хугацааны дараа Мерианагийн найз баптисм хүртсэн юм. Тойргийн гишүүдийн хүчин чармайлт болон ариун ёслолын цуглаан дээрх халуун дулаан уур амьсгал түүний шийдвэрт томоохон үүрэг гүйцэтгэсэн байна.

Эргэж ирж буй эсвэл шинэ гишүүдэд тохинуулах санаанууд

- Та ариун ёслолын цуглаан дээр үг хэлэх гэж байгаа бол найз нөхөд, гэр бүлийнхэн, бусад хүнийг ирж, таны захиасыг сонсоход урьж болно.
- Та ганцаардсан юм уу тусламж хэрэгтэй байж болох хүмүүсийг эрж олоод, урьж болно. Тэдний дэргэд сууж болох эсэхийг асуу. Эсвэл тэднийг дэргэдээ суухад урь.
- Цуглаан дуусах үеэр та тохинуулдаг хүмүүсээ болон бусдыг Сүмийн удахгүй болох үйл ажиллагаанд болон ариун сүм явах юм уу нийгмийн үйл ажиллагаанд урьж болно.
- Хэрэв таны тохинуулдаг хүн ариун ёслолын цуглаандаа ирдэг боловч ойрд ирээгүй бол та тэднээс заагдсан зүйлсээс асуух зүйл байгаа эсэхийг лавлаж болно. Хэрэв тэдэнд ойлгоогүй ямар нэгэн үг хэллэг, түүх юм уу сургаалын хэсэг байгаа бол танд хэззэ ч хандаж болно гэдгийг тэдэнд хэлээрэй. Шаардлагатай бол хариултыг хамтдаа хайж болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй гэр бүлүүдэд туслах 4 арга зам" (зөвхөн цахимаар), *Лиахона, 2018 оны 6-р сар,* эсвэл энэ дугаарын 22-р хуудасны "Сүм дээр хоол хүнсний харшлаа зохицуулах нь" нийтлэлийг уншихыг бодоорой.
2. Жийн Б.Бингам, "Аврагчийн адил тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 130.
3. Жэффри Р.Холланд, "Бурханы хургыг болгоогтун," *2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган*.
4. Joseph Fielding Smith, in Conference Report, Oct. 1929, 60–61.

Ахлагч Гари И. Стивэнсон
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын

СЭРГЭЭЛТ ДЭХ *санваарын чухал үүрэг*

Санваар дэлхийд эргэн ирээгүй байсан бол Сэргээлт тохиох боломжгүй байх байсан.

1829 оны 4-р сар гэхэд, Иосеф Смит бараг арваад жил бурханлаг айлчлалууд хүлээн аваад байсан юм. Эцэг, Хүү хоёр 1820 онд, түүнийг 14 настай байхад гэрийнх нь ойролцоох ойн төгөлд үзэгдсэн (Иосеф Смит—Түүх 1:5–17-г үзнэ үү).[1] Тэнгэр элч Моронайн анхны айлчлал 1823 онд тохиосон ба түүнээс хойш Иосеф Смит Мормоны Ном болсон, ялтаснууд дээр сийлсэн эртний цэдгийг 1827 онд хүлээн автлаа жил бүр заалгаж, заавар авч байв (Иосеф Смит—Түүх 1:30–54-ийг үзнэ үү).

Гэвч Иосеф ялтаснуудыг олж авснаас хойш 18 сарын турш нутгийн иргэдийн дарамт шахалт болон бичээчдээ сольсон, гар бичмэлийн нэг хэсгийг алдсан зэргээс болж цэдгийг орчуулахад бэрхшээлтэй тулгарч байжээ. Энэ нь Иосефын хувьд бухимдмаар, хэцүү үе байв. (Иосеф Смит—Түүх 1:58–62; Сургаал ба Гэрээ 3-ыг үзнэ үү.)

Гэвч 1829 оны 4-р сард Оливер Каудери хэмээх сургуулийн багш ирж, Иосефын бүрэн цагийн бичээч болсноор бүх зүйл өөрчлөгдөв. Ингэснээр Мормоны Номыг маш хурдан орчуулах болсон юм.

1828 оны намар, Пеннсильванийн Хармони дахь фермээ ажиллуулж, гэр бүлээ тэжээхийн тулд ихэнх цаг заваа зориулсны дараа Иосеф 1829 онд Мормоны Номыг орчуулахад бүрэн анхаарлаа хандуулжээ. Иосефын эхнэр Эмма, түүний дүү Самуел хоёр богинохон хугацаанд бичээчээр үйлчилж байв. Энэ үед Оливер Каудери Нью-Йорк дахь Иосефын эцэг эхийн гэрт амьдарч байсан.

Ялтаснуудын тухай болон орчуулгынх нь талаар олж сонссон нь Оливерын сонирхлыг татаж, эдгээр зүйлийг Бурханаас эсэхийг мэдэхийг хүсэж байв. "Тэр нэг орой унтахаар хэвтсэнийхээ дараа эдгээр зүйлийн үнэн эсэхийг мэдэхээр Их Эзэнийг дуудсан ба Их Эзэн түүнд эдгээрийн үнэнийг илчилсэн юм"[2] хэмээн Иосеф тэмдэглэн бичжээ.

ДЭВСГЭР ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ

Оливер тэр даруй Иосефтой уулзахаар Хармони руу 225 км аялсан байна. Оливер Иосефын залбирлын хариу болжээ. Тэд 4-р сард уулзсанаас хоёр өдрийн дараа Мормоны Номын орчуулга эрчимтэй эхлэн, ойролцоогоор ажлын 60–65 өдрийн дотор гайхалтайгаар дуусах дөхсөн байв. 6-р сарын 30 гэхэд орчуулгыг бүхэлд нь дуусгажээ.

Бошиглогч Иосеф эртний цэдгийг орчуулж, нийтлэх тэнгэр элчээс өгсөн бурханлаг үүргээ гүйцэтгэснээр бүх ажлаа дуусах дөхөж байна гэж бодсон байж магадгүй. Бошиглогч тэр үед дуусаж байгаа биш, харин Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн үндсэн үүрэг дөнгөж эхлэж байсныг мэдээгүй байх.

Мормоны Номын орчуулгын гайхамшгаас гадна тэнгэр элчүүд удалгүй үзэгдэж, Иосеф, Оливер хоёрт санваарын эрх мэдэл олгосон юм.

Түүхэн дэх цөөхөн хэдэн үйл явдал 1829 оны хавар болсон үйл явдалтай харьцуулахуйц байдаг. Оливер Сэргээлтийн энэхүү гайхамшигтай хэсгийг “хэзээ ч мартагдахааргүй өдрүүд” (Иосеф Смит—Түүх 1:71, тэмдэглэл) хэмээн тодорхойлсон байдаг. Мормоны Номыг орчуулсан гайхамшгаас гадна тэнгэр элчүүд удалгүй үзэгдэж, Иосеф, Оливер хоёрт санваарын эрх мэдэл олгосон юм. Энэ орчуулга хийгдсэн болон сэргээлт илчлэгдсэн үе Иосефын үзэл бодлыг дахин чиглүүлж, өргөжүүлж, нэг жилийн дараа Сүмийг албан ёсоор зохион байгуулахад хөтөлсөн.

Ааронын санваарын сэргээлт

Иосеф, Оливер хоёр Мормоны Номыг орчуулж байхдаа баптисм болоод эрх мэдэлтэй холбоотой тоймгүй олон эшлэлтэй таарч байв. Иосефт өмнө нь “Их Эзэн ариун санваарыг зарим хүмүүст өгнө”[3] хэмээн хэлж байсан. 1829 оны 5-р сарын 15-нд Иосеф, Оливер хоёр “Их Эзэнээс залбирлаар, өөрийнхөө талаар Түүний хүслийг асуухаар”[4] агч модны ойн цоорхойд очив.

Тэднийг залбирах үед Аврагчийн дуу хоолой тэдэнд амар амгаланг ярьж байхад “хөшиг хуваагдан мөн алдар суугаар хувцасласан Бурханы тэнгэр элч доош бууж ирэн, хүсэмжлэн байсан мэдэгдлийг болон наманчлалын Сайн мэдээний түлхүүрүүдийг хүргэн ирэв” (Иосеф Смит—Түүх 1:71, зүүлт тайлбар). Тэнгэр элч өөрийгөө Иохан гэдгийг, тухайлбал “Шинэ Гэрээний Иохан Баптист хэмээн нэрлэгддэг Иохан гэдэг нэрээ хэлж, Петр, Иаков Иохан нарын удирдлага дор ажиллаж байгаагаа хэлэв” (Иосеф Смит—Түүх 1:72).

Амилсан Иохан өвдөг сөгдөн суусан Иосеф, Оливер хоёрын толгой дээр гараа тавьж, “тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүдийг атгах” Ааронын санваарыг тэдэнд хүртээв; (Иосеф Смит—Түүх 1:69-ийг мөн Сургаал ба Гэрээ 13:1-ийг үзнэ үү). Тэдэнд санваарын нэмэлт эрх мэдлийг “цаг болохоор өгөх болно” хэмээн амласан. Иосеф “Сүмийн анхны ахлагч, харин тэрээр (Оливер Каудери) хоёр дахь нь” хэмээн нэрлэгдэв (Иосеф Смит—Түүх 1:72). Тэдэнд мөн бие биедээ баптисм хүртээхийг, Иосеф эхлээд Оливерт, дараа нь Оливер Иосефт баптисм хүртээхийг даалгасан байв.

Тэр хоёр тэр өдөртөө баптисм хүртэхээр Сасквиеханна голын эрэг дээр очиж “ус руу орсон юм.” Тэд “аль хэдийн мэдэгдсэн мөрдлөг хавчлагын сүнсний улмаас санваар хүлээж авсан хийгээд [тэд] баптисм хүртсэн нөхцөл байдлаа тэр үед нууц байлгахаас аргагүйд хүрсэн юм” (Иосеф Смит—Түүх 1:74). Энэ гол хаврын үерийн үеэр худалдаа, тээвэр хийх хөлөг онгоцны байнгын урсгал бүхий гол зам болдог байв. Иосеф, Оливер хоёр үдэш болтол хүлээж эсвэл үерлэсэн голын давуу талыг ашиглан, нам дор газарт илүү тайван газар олж чадсан байж магадгүй.[5]

МЕЛКИЗЕДЕК САНВААРЫН СЭРГЭЭЛТ, ВЭЛТЭР РЭЙН

ИОСЕФ СМИТ ОЛИВЕР КАУДЕРИД БАПТИСМ ХҮРТЭЭСЭН НЬ, ДЭЛ ПАРСОН

Бие биедээ баптисм хүртээсний дараа Иосеф Оливерыг Аароны санваарт томилов. Дараа нь тэнгэр элчийн тэдэнд зарлигласнаар, Оливер Иосефыг томилжээ. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит тэдэнд баптисмынхаа дараа Иохан Баптистын гар доороос хүлээн авсан анхны томилгоогоо "эдгээр адислалыг зохих ёсоор нь дахин лацдахын тулд *дахин баталгаажуулах* шаардлагатай байсан"[6] хэмээн заасан.

Мелкизедек санваарын сэргээлт

Мелкизедек санваарыг сэргээхийн тулд Петр, Иаков, Иохан нарын Иосеф, Оливер хоёрт өгсөн үзэгдлийн тухай бидэнд арай бага мэдээлэл байдаг. Дурсамж бүхий түүхэн тайлбарууд уг үйл явдлыг 1829 оны хавар, магадгүй 5-р сарын сүүл юм уу 6-р сарын үед эсвэл дараагийн хэдэн сарын дотор болсон гэж үздэг.[7] Иосеф, Оливер хоёр Петр, Иаков, Иохан нарын ирсэн он сар өдрийг, Иохан баптист болон Аароны санваарын сэргээлтийг тэмдэглэсэн шигээ тэмдэглээгүй байна. Тэд санваарын мөн чанарыг эсвэл үүний хуваарилалтыг бүрэн дүүрэн ойлгоогүй байсан байж болох юм. Иосефын санваарыг ойлгох ойлголт бага багаар өсөн нэмэгдсэн.

1830–1835 он хүртэл санваарын албуудыг тодруулж, чуулга, зөвлөл, ерөнхийлөгчийн зөвлөл, бишопын зөвлөлүүдийг байгуулав. *Мелкизедек санваар* нэр томьёог ч гэсэн 1835 он хүртэл "Дээд санваар" эсвэл "илүү дээд санваар" (Сургаал ба Гэрээ 107:9; 84:19) (Сургаал ба Гэрээ 107:2–4-ийг үзнэ үү) гэсэн нэр томьёогоор ашигладаггүй байв.

Иосеф байршлын талаар бүдүүн тойм мэдээлэл өгсөн байдаг. 1842 онд тэр "хаант улсын түлхүүрүүдийг эзэмшигчид хэмээн Хармонийн мөн Колесвиллын хоорондох аглаг буйдад Сасквиеханна гол дээр өөрсдийгөө тунхаглагч Петр, Иаков, Иохан нарын дуу хоолойг" (Сургаал ба Гэрээ 128:20) сонссоноо дурсжээ.

Энэ нь Мелкизедек санваарын сэргээлт нь Пенсильвани мужийн Хармони дахь Смитийн байшин болон Жозеф Найтын гэр бүл амьдардаг Нью-Йоркийн Колесвилл хот хоёрын хоорондох 45 км зайтай газрын хаа нэгтээ болсныг харуулж байна. Найтын гэр бүл бол Сүмийн эртний гишүүд бөгөөд Иосеф Смитийн үнэнч найзууд байв. Тэд Мормоны Номын орчуулгын үеэр цаас, бусад эд зүйлээр хангаж, хожим нь Сүмийн Колесвилл салбарын гол хэсгийг бүрдүүлсэн.

Иосеф, Оливер хоёр Петр, Иаков, Иохан нараас Мелкизедек санваар хүлээн авснаас гадна Их Эзэний "төлөөлөгчид мөн тусгай гэрчүүд байхаар" (Сургаал ба Гэрээ 27:12) томилогдож, цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийг эхлүүлэхэд шаардлагатай түлхүүрүүдийг хүлээн авчээ. Тэд одоо санваарын бүх ёслолыг, түүний дотор Ариун Сүнсний бэлгийг өгөх эрх мэдэлтэй болсон байв.

Тэд бас 1830 оны 4-р сард Сүмийг зохион байгуулахад шаардлагатай "сүмийн сүнсний бүх адислалуудын түлхүүрүүдийг" (Сургаал ба Гэрээ 107:18) болон бүх зүйлийг зохих ёсоор нь сэргээх илчлэлт хүлээн авсан. Сүнслэг адислалууд нь санваарын эрх мэдлээр гүйцэтгэгддэг гайхамшиг, эдгэрэл, ёслолуудаар дамжин илэрдэг билээ. 1836 онд өөр тэнгэр элчүүд Израилын цугларалт болон ариун сүмийн ажилтай холбоотой санваарын түлхүүрүүдийг өгсөн байна (Сургаал ба Гэрээ 110-ыг үзнэ үү).

Санваарын сэргээлт нь энэхүү эрин үеийн анхны бошиглогч болох Иосеф Смитийн бурханлаг дуудлагын гол үүрэг байв.

Санваарын сэргээлтийн үр нөлөө

Ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) Аврагчийн сэргээгдсэн сүмийн хамгийн онцлог шинж бол "шууд илчлэлтээр ирэх бурханлаг эрх мэдэл юм"[8] хэмээн заасан. Санваар дэлхийд эргэн ирээгүй байсан бол Сэргээлт тохиох боломжгүй байв. Санваар нь ёслол гүйцэтгэх эрх мэдлийг олгож, дэлхий дээр Их Эзэний Сүмийг удирдах тогтолцоог бүрдүүлж өгдөг.

Иосеф 1830 оны 4-р сарын 6-нд Сүмийг албан ёсоор зохион байгуулав. Дараагийн хэдэн жилд Тэргүүн Зөвлөл ба Арван хоёр Төлөөлөгчийн чуулга зохион байгуулагдав. Сүмийн ерөнхийлөгчийн удирдлаган доор

Бид бүгдээрээ орчин үеийн бошиглогчдод илчлэгдсэн зүйлсийг урам зоригтой хүлээн авч, мөн амьдралдаа хэрэгжүүлснээр сайн мэдээний үргэлжлэн явагдаж буй Сэргээлтэд оролцох боломжтой байх болтугай.

сайн мэдээг "дэлхийн бүх хязгааруудад урагш түгээхээр" (Сургаал ба Гэрээ 65:2) санваарын түлхүүрүүдийг дэлхий даяарх орон нутгийн удирдагчдад өгдөг юм.

Санваарын сэргээлт нь энэхүү эрин үеийн анхны бошиглогч болох Иосеф Смитийн бурханлаг дуудлагын гол үүрэг байв. Сургаал ба Гэрээний оршил хэсэгт Их Эзэн үүнийг ийн тайлбарласан. "Иймийн тул, Их Эзэн бибээр дэлхийн оршин суугчид дээр ирэх тэрхүү сүйрлийг мэдэх учраас, өөрийн үйлчлэгч Бага Иосеф Смитийг дуудан, тэнгэрээс түүнд ярьж, мөн түүнд зарлигуудыг өгсөн ажгуу" (Сургаал ба Гэрээ 1:17).

1829 оны 5-р сард Иохан Баптисттай уулзахаас өмнө Иосеф Мормоны Номын орчуулгадаа анхаарлаа хандуулж байв. Аароны болон Мелкиседек санваарыг сэргээсний дараа тэрээр өөрийнх нь дуудлага илүү их зүйл багтаасан болохыг ойлгосон. Тэнгэрээс эрх мэдэл хүлээн авсан нь Иосефыг "үзмэрч, орчуулагч, бошиглогч, Есүс Христийн төлөөлөгч" (Сургаал ба Гэрээ 21:1) хэмээх үүргээ хүлээн авахад бэлтгэсэн байв.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс (1932–2017) санваар байгаагүй бол бидний амьдрал ямар байх байсныг ийнхүү дүрсэлжээ. "Хэрэв санваарын хүч дэлхий дээр байхгүй байсан бол дайсан хязгааргүй тэнүүчлэн, хаанчлах эрх чөлөөтэй байх байсан. Мөн биднийг удирдан, чиглүүлж мөн сэнхрүүлэх Ариун Сүнсний бэлэг байхгүй байх байсан. Их Эзэний нэрээр ярих бошиглогчид болон ариун нандин, мөнхийн гэрээнүүдийг байгуулах ариун сүмүүд ч байхгүй байх байсан төдийгүй адислах, баптисм хүртээх, эдгээх, тайтгаруулах эрх мэдэл байхгүй байх байсан. Санваарын хүчгүйгээр 'бүх дэлхий бүрмөсөн устгагдах болно' (Сургаал ба Гэрээ 2:1–3-ыг үзнэ үү). Ямар ч найдвар, гэрэл гэгээгүй зөвхөн харанхуй байх байсан."[9]

Санваарын ёслолуудыг хүлээн авах нь "үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах" (Мосе 1:39) Их Эзэний ажлын гол хэсэг юм. Баптисм, гишүүний баталгаа, ариун сүмийн хишиг хүртэх, энэ амьдралд болон үүрд мөнхөд лацдан холбогдох нь бидний авралд амин чухал билээ. Хөшигний хоёр талд буй хүмүүсийн төлөө ариун сүмүүдэд гэр бүлүүдийг холбох, лацдан холбох боломж нь зөвхөн Сүмийн ерөнхийлөгчийн зааврын дагуу санваарын эрх мэдэл, түлхүүрээр л боломжтой юм.

Үргэлжлэн явагдаж буй Сэргээлт

Санваарын эрх мэдэл нь Сүмийн үргэлжлэн явагдаж буй Сэргээлтэд оролцоход тань хэрхэн урам зориг өгөх вэ? Ирээдүйд юу болохыг бид мэдэхгүй байж болох ч Сэргээлт үргэлжлэн явагдах нь тодорхой. Их Эзэн бүх сургаал, ёслолыг илчлээгүй, өөрөөр хэлбэл Иосефт Ариун ойн цоорхойд, Куморад Моронайгаар дамжуулан эсвэл Сүмийг зохион байгуулах хурлууд дээр бүх зааврыг өгөөгүй. Сэргээлт нэг үйл явдлаар тохиогоогүй. Харин Их Эзэн өнөө үед Өөрийн зорилго, цаг хугацааны дагуу Өөрийнхөө бошиглогчдод илчилсээр байгаа тэрхүү арга замаараа Иосефт "шат шатаар" (2 Нифай 28:30) илчилсэн.

Иосеф Смитийн үеэс хойш тасраагүй бошиглогчдын цуваа Их Эзэний өмнөөс ярьж, Түүний хүслийг мэдүүлсээр байна. Бошиглогчид илүү өргөн хүрээгээр харж, тухайн үеийн саад бэрхшээлүүдийн талаар тодорхой заавар хүлээн авдаг. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон бид бүгд "сэргээлтийн үйл явцын гэрчүүд юм. Хэрэв та Сүмийг бүрэн сэргээгдсэн гэж үзэж байвал дөнгөж эхлэлийг нь л харж байна. Өөр олон зүйл тохиох болно"[10] хэмээн тунхагласан.

Сэргээлт ба та

Бид бүгдээрээ орчин үеийн бошиглогчдод илчлэгдсэн зүйлсийг урам зоригтойгоор хүлээн авч, амьдралдаа хэрэгжүүлснээр сайн мэдээний үргэлжлэн явагдаж буй Сэргээлтэд оролцох боломжтой байх болтугай. Үүний жишээнд ах, эгч нартаа тохинуулахын илүү дээд, илүү ариун хуулийг дагаж мөрдөх явдал орно.[11] Сургаалыг судлах, итгэлээ бэхжүүлэх, зарлигуудыг сахих, хувь хүний болон гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн гэр бүлийн үдэш хийх зэрэг хувийн шүтлэг бишрэлийг хөхиүлэн дэмжих, гэр оронд төвлөрсөн, Сүмээс дэмжсэн төлөвлөгөөгөөр дамжуулан хүн бүр сайн мэдээний баяр баясгаланг олж авах болтугай.[12]

Бид хөшигний хоёр талд Израилын цугларалтыг яаравчлуулснаар Аврагчийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэж чадна.[13] Бид Хүндэтгэлийн өдрийг ням гаргийн шүтлэг бишрэлийн үеэр болон гэртээ аль алинд нь баясгалантай болгохын тулд илүү сайнаараа хичээж чадна.[14] Өдөр бүр хувийн илчлэлт авахад шаардлагатай сүнслэг ажлыг хийснээр бид Ариун Сүнстэй илүү ойр дотно болно.[15]

Тэнгэр нээлттэй хэвээр байгаа бөгөөд Их Эзэн биднийг удахгүй болох сэтгэл хөдөлгөсөн өдрүүдэд бэлтгэх үед илүү их зүйл ирэх болно гэдгийг би гэрчилж байна. Санваарын сэргээлт нь Бурханы хүүхдүүдэд авралын ёслолуудыг гүйцэтгэж, хүлээн авах боломжийг олгоод зогсохгүй, орчин үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдэд Их Эзэний хаант улсыг удирдах эрх мэдлийг олгодог.

Их Эзэний санваарыг хүртэх боломж нээгдсэнээр өдөр бүр Сүмд болон Сүмийн гишүүдэд тоо томшгүй олон адислал ирдэг. Бид Иохан Баптист, Петр, Иаков, Иохан нарыг ирсэнд болон бидний Их Эзэн Аврагч Есүс Христийн ирэлтэд бэлтгэх энэ сүүлийн эрин үед Аароны болон Мелкиседек санваар эргэн ирсэнд өдөр бүр талархдаг байх болтугай. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Joseph Smith, History, 1838–1856, vol. A-1, created June 11, 1839–Aug. 24, 1843, 15, Church History Library.
2. Joseph Smith, in *History of the Church,* 1:35.
3. Oliver Cowdery, letter to W. W. Phelps, in *Latter Day Saints' Messenger and Advocate,* Oct. 1835, 199.
4. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007). Удаан хугацааны турш тогтсон уламжлал ёсоор тэднийг Сасквиеханна голын эрэг дээр байсан гэж үздэг боловч өнөөгийн түүхүүдээс үзэхэд тэднийг үл хөдлөх хөрөнгийнхөө хойд талд буюу агч модны төгөлд байсан гэж үздэг (see Mark Lyman Staker, "Where Was the Aaronic Priesthood Restored? Identifying the Location of John the Baptist's Appearance, May 15, 1829," *Mormon Historical Studies* 12, no. 2 [Fall 2011]: 142–159).
5. Mark L. Staker, "Where Was the Aaronic Priesthood Restored?" 153-ыг үзнэ үү.
6. Joseph Fielding Smith, *Doctrines of Salvation,* comp. Bruce R. McConkie (1955), 1:197.
7. Larry C. Porter, "Dating the Restoration of the Melchizedek Priesthood," *Ensign,* June 1979, 5–9; Larry C. Porter, "The Restoration of the Aaronic and Melchizedek Priesthoods," *Ensign,* Dec. 1996, 42–44-ийг үзнэ үү.
8. David O. McKay, "The Mission of the Church and Its Members," *Improvement Era,* Nov. 1956, 781.
9. Робэрт Д.Хэйлс, "Санваарын адислалууд," *Ensign,* 1995 оны 11-р сар, 32.
10. "Latter-day Saint Prophet, Wife and Apostle Share Insights of Global Ministry," newsroom.ChurchofJesusChrist.org.
11. Рассэлл М.Нэлсон, "Бурханы хүч, эрх мэдлээр тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,*, 87; Рассэлл М.Нэлсон, "Тохинуулах нь,"*2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 125; Хэнри Б.Айринг, "Сүнсээр өдөөгдсөн тохинуулал," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 79; Жийн Б.Бингам, "Аврагчийн адил тохинуулах нь," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 130.
12. Рассэлл М.Нэлсон, "Нээлтийн үг," *2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 3; Квинтин Л.Күк "Тэнгэрлэг Эцэгт болон Их Эзэн Есүс Христэд гүн гүнзгий, бат бөх хөрвөгдөх нь," *2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 5.
13. Рассэлл М.Нэлсон, "Израилын найдвар" (worldwide youth devotional, Jun. 3, 2018), HopeofIsrael.ChurchofJesusChrist.org; Рассэлл М.Нэлсон, "Израилыг цуглуулах ажил дахь эгч нарын оролцоо," *2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 141.
14. Рассэлл М.Нэлсон, "Хүндэтгэлийн өдөр нь баясгалант өдөр билээ," *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 122.
15. Рассэлл М.Нэлсон, "Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт," *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 115–120-ийг үзнэ үү.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд маань баптисм хүртэхэд бэлэн болов уу?

Хүүгийн маань найман насны төрсөн өдөр дөхөж байлаа. Гэвч бид түүнийг баптисм хүртэхэд бэлэн эсэхийг хэрхэн мэдэх билээ?

Кэти Эдна Стийд

Манай хүү Дэвид жил хүрэхгүй хугацааны дараа найм хүрэх гэж байлаа. Нөхөр бид хоёр хүүгээ баптисмын ариун нандин гэрээнд бэлдэхийг хүсэж байв. Энэ бүхэн Мормоны Номоос унших, баптисмын гэрээнүүдийг судлах, баптисмын ярилцлагын асуултуудаа давтах зэрэг зүйлсийг багтааж байв. Бид Дэвидийн эгчтэй энэ бүхнийг хийж байсан ч Дэвид аутисмтай болохоор түүнд баптисм хүртээх эсэхийг шийдэх нь бидэнд амаргүй ажил байсан юм.

Тийм ээ, бид түүнд бэлтгэхэд нь яаж туслахаа мэдэж байсан ба энэ бүх бэлтгэлээс илүү дараах асуултуудад анхаарч байв. *Дэвид* баптисм хүртэх ёстой юу? Тэр бэлэн үү? Түүнд баптисм хүртээх хэрэгтэй юу? Тэр ямар амлалт өгөх гэж байгаагаа ойлгосон болов уу? Бид зөв зүйл хийж байгаагаа хэрхэн мэдэх вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй олон эцэг эхтэй адил эдгээр асуулт биднийг сургаалын ойлголт, хувийн илчлэлтийг эрэлхийлэх аян зам руу хөтөлсөн.

Хариуцлага хүлээх нас ба хариуцлага

Сургаал ба Гэрээ 68:27 дээр “Мөн тэдний хүүхдүүд нүглүүдийнхээ ангижралын тулд найман настайдаа баптисм хүртэж, мөн гар тавилтыг хүлээн авах ёстой” гэж гардаг.

Хэрэв бид зөвхөн энэ судэрт найдвал найман настай хүн баптисм хүртэхэд бэлэн гэж дүгнэхээр байв. Гэвч судар дээр бас ингэж гардаг.

“Бага насны хүүхдүүд . . . миний Төрсөн Ганцаар дамжин гэтэлгэгддэг;"

“Иймийн тул, тэд нүгэл үйлдэж эс чадна . . . тэд миний өмнө хариуцлага хүлээж эхлэх хүртэл” (Сургаал ба Гэрээ 29:46–47; Моронай 8:7–22-ыг үзнэ үү).

Дэвидийн хариуцлага хүлээж чадах эсэхийг нөхөр бид хоёр яаж ойлгох вэ? Бид үргэлжлүүлэн судалсаар байлаа.

Хүний хариуцлага нь түүний хүслээс болон ойлголтын түвшингээс хамаардаг болохыг бид Сүмийн бодлогоос мэдэж авсан. Хэрэв Дэвид баптисм хүртэх зөв зохистой, хүсэлтэй байж, хариуцлага хүлээж чадна гэдгээ харуулах юм бол бид түүнийг баптисм хүртэхэд татгалзаж болохгүй.

Хэрэв Дэвидийн хөгжлийн бэрхшээл оюуны чадамжийг нь бяцхан хүүхдийн адил хязгаарлах юм бол тэр хариуцлага хүлээж чадахгүй бөгөөд авралын ёслолууд хэрэггүй гэдгийг бид бас ойлгосон (*Гарын авлага 1: Гадасны ерөнхийлөгч ба бишоп* [2010], 16.1.8; Сүмийн бодлого журмын талаар асуух зүйлтэй гишүүд бишоптойгоо зөвлөлдөж болно).

Дэвидийн оюун ухаан хэвийн байсан ч би түүнийг зохих хариуцлагын түвшинд хүрсэн эсэхэд эргэлзсээр байв. Би амар амгаланг авчрах удирдамжийн төлөө залбирч судлан, найдвар тавьсаар байлаа.

Хөгжлийн бэрхшээл ба гэм зэмгүй байдал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй зарим эцэг эх мөнх бус амьдралдаа хариуцлага хүлээлгүйгээр нас барах хүмүүс гэм буруугүй хэвээр үлддэг гэдгийг уншсанаар агуу тайтгарал авдгийг би мэддэг байв. “Бүх бага насны хүүхдүүд. . . . Христээр амьд юм. Учир нь гэтэлгэлийн хүч хуульгүй тэд бүгдэд ирдэг; . . . мөн тийм нэгэнд баптисм ямар ч тусгүй юм” (Моронай 8:22).

Мөн нас барж, хариуцлага хүлээгээгүй хүүхдүүдийн нөхцөл байдлыг бошиглогч Иосеф Смит “Мөн тэрчлэн хариуцлагын насанд хүрэхээсээ

ГЭРЭЛ ЗУРГИЙГ РАНДИ КОЛИЭ

өмнө нас барсан бүх хүүхдүүд тэнгэрийн селестиел хаант улсад аврагддагийг бибээр болгоов" (Сургаал ба Гэрээ 137:10) гэж тайлбарласан.

Энэ хүмүүсийн хувьд баптисм одоогийн амьдралд шаардлагагүйг би мэднэ. Бурхан Дэвидийн хувьд хамгийн сайн зүйлийг олж мэдэхэд бидэнд тусална гэдгийг би мэдэж байсан.

Тэнгэрлэг удирдамж эрэлхийлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс маш олон төрлийн чадвартай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүний оюуны түвшин найман настай хүүхдийнхээс дээгүүр байдаг ба хэрэв хариуцлага хүлээх чадвартай бол баптисм хүртэж, гишүүнээр батлуулж болно (*Гарын авлага 1*-ийн 16.3.5-ыг үзнэ үү). Бусад хүн хариуцлага хүлээхгүй. Нөхөр бид хоёр хүүтэйгээ, Бурхантай мөн Дэвидийн баптисм хүртэхэд бэлэн болсон эсэх сүнслэг шийдвэрт маань туслах "Израилын шүүгч" болон зогсох бишоптойгоо зөвлөлдөх хэрэгтэй байгааг би ойлгов (Сургаал ба Гэрээ 107:76-г үзнэ үү).

Алмагийн үгс надад туйлын амар амгаланг авчирсан билээ. "Мөн эдүгээ, та нар Бурханы хороонд орж, мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, тэр өөрийн Сүнсийг та нар дээр илүү элбэгээр юүлж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?" (Мозая 18:8, 10).

Бүх бэлтгэл ажлын дараа, гэртээ болон Хүүхдийн хэсгийн бүх хичээлийн дараа би түүний баптисмын ярилцлага дээр түүнд тавих асуултуудыг Дэвидээс асууж эхэлсэн юм.

Заримдаа тэрээр ойлгож байгаа юм шиг хариулж байсан ч заримдаа юу гэж хариулахаа мэддэггүй байв. Бид зөв зүйл хийж байгаа эсэхэд би эргэлзэж байв.

Эцэст нь "Чи яагаад Дэвидийн бодлыг асууж болохгүй гэж?" хэмээн Сүнс зүрх сэтгэлд минь шивнэлээ.

Би Дэвид дээр очоод, "Дэвид, чи баптисм хүртмээр байна уу?" гэж асуув.

Тэр над руу хараад "Тийм!" гэв.

Намайг түүнээс яагаад баптисм хүртэхийг хүсэж байгааг асуухад тэр "Есүстэй адил болохын тулд" гэлээ.

Би амар амгаланг мөн удирдамж ирснийг мэдэрсэн. Хэдийгээр Дэвид бүх асуултыг бүрэн ойлгоогүй ч баптисм хүртэж, гишүүнээр батлуулахад бэлэн байсныг би тэгэхэд мэдсэн юм. Тэр мэдэх ёстой зүйлээ мэдэж байсан ба хамгийн чухал нь тэр баптисм хүртэх замаар Бурханы хаант улсад орох хүсэлтэй байсан.

Дэвидийн баптисм хүртэж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнээр батлуулсан тэр өдөр хайр, нөхөрлөл, амар амгалангаар дүүрэн байсан. Өрөө гэр бүлийнхэн, тойргийн гишүүд, сургуулийн найзууд, тэр бүү хэл Дэвидийн сургуулийн багш нараар дүүрсэн байв. Дэвидийн Есүсийг дагахыг мөн баптисм хүртэхийг сонгож, тэр өдөр үзүүлсэн үлгэр жишээ нь олон хүнд сайнаар нөлөөлсөн үлгэр дуурайл болсон юм. Бид өөрийн хүү Дэвидээр дамжуулан Бурхан хэрхэн ажилладгийг сурах боломжтой байсан тул гэр бүл маань илүү хүчирхэгжсэн (Иохан 9:3-ыг үзнэ үү). ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

БИД ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ГИШҮҮДЭД ХЭРХЭН ТУСАЛЖ ЧАДАХ ВЭ?

Удирдагчид бусад хүнд хэрэгтэй гэдгийг нь ойлгоход туслахын тулд Аврагчийн үлгэр жишээг хайраар дагавал хөгжлийн бэрхшээлтэй гишүүд болон тэдний гэр бүл Түүний хайрыг мэдэрч, Христийн сүм дотор чухал байр суурь эзэлдгээ ойлгох болно (1 Коринт 12:12, 18-ыг үзнэ үү). Удирдаж мөн үйлчлэхдээ дараах зүйлсэд анхаар.

1. **Асуулт тавихаас бүү эмээ.** Заримдаа бид ялгаатай байдлыг дурдахаас эмээдэг ч таныг хүндэтгэлтэйгээр асуусан үед хүмүүс нөхцөл байдлыг нь ойлгох гэж хичээж байгаад тань талархах болно. "Би Сүм дээрх туршлагаа сайжруулахад тань хэрхэн туслах вэ?" гэх зэргээр хайрлах арга замаар асуу. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүд болон тэдний гэр бүлийнхэн өөрсдийн хөгжлийн бэрхшээлийн талаар хамгийн сайн мэддэг бөгөөд шаардлагатай тусламжийг танд хэлж өгч чадна.

2. **Ойлгоход нь бусдад тусал.** Хөгжлийн бэрхшээлийн талаар гишүүдтэй зөвлөлдсөний дараа бусдад юу гэж хэлбэл тэдэнд зүгээр байх талаар тэдэнтэй зөвлөлд. Дараа нь боломжтой бол тойргийн удирдагчид болон бусад гишүүнд тухайн хүний хөгжлийн бэрхшээл болон хэрэгцээнүүдийг ойлгоход нь тусал. Энэ нь агуу нинжин сэтгэл, ойлголтыг болон ямар дэмжлэгээр хангах тухай сүнслэг өдөөлтийг хөхиүлэн дэмжинэ.

3. **Боломжуудаар ханга.** Та бусдын асуултад хариулах нэмэлт цаг гаргах, хадмал бичигтэй видео бичлэг ашиглах, хараany эсвэл сонсголын бэрхшээлтэй хүмүүсийг илүү сайн харах эсвэл сонсож чадах газар суулгах, одоогийнхоо хичээлд олон янзын хэвлэл мэдээлэл ашиглах зэргээр хүн бүрд суралцах, оролцоог дэмжих олон энгийн өөрчлөлт байдаг. Та хийж чадах тодорхой зохицуулалтынхаа талаар тойргийн юм уу гадасны хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан мэргэжилтэнтэй зөвлөлдөж болно.

4. **Үйлчлэл хийх боломжуудыг бүрдүүл.** Хувь хүнтэй болон тэдний асран хамгаалагчидтай уулзаж, тэдний ур чадвар, авьяас чадвар юу болохыг олж мэдэх хэрэгтэй. Дараа нь тэдэнд үйлчлэх утга учиртай арга замуудыг залбирч олж мэд. Хүн бүрд ажилд хувь нэмрээ оруулж чадахаар ямар нэгэн зүйл байгаа.

5. **Хайраар хүрч үйлчил.** Ахлагч Жэффри Р.Холландын үгсийг нээлттэй хүлээн авч тусгахыг хичээ. "Сүмийн гишүүдийн хувьд бид бүгдээрээ энэ аялалд нэгдсэн. . . . Таны нөхцөл байдлаас үл хамааран бид таныг урьж байна" ("What I Wish Every New Member Knew—and Every Longtime Member Remembered," *Liahona,* Oct. 2006, 10). Бие биедээ хайраар тохинуулж, нөхөрлөдөг хүмүүс бол Сүмийн бүх эх сурвалж дотроос хамгийн агуу нь байх болно.

Сүм дээр ХООЛНЫ ХАРШЛЫГ зохицуулах нь

Лиса Анн Томсон

2017 оны 1-р сарын нэгэн жихүүн орой болсон өсвөр үеийнхний үйл ажиллагаа Сорэнсоны гэр бүлийг мөнхөд өөрчилсөн юм. Тэрри, Жэнилин хоёрын хүү Таннер 14 настай байв. Хамтарсан үйл ажиллагаа өндөрлөх дөхөж байлаа. Нэг удирдагчийг амттаны сүүлчийн хэсгийг санал болгоход, газрын самрын харшилтай Таннер жигнэмэг шүүрч аваад, хазаж орхижээ. Тэр самрын тостой жигнэмгийг идэж болохгүй байв.

"Тэр ихэнхдээ их болгоомжтой байдаг байсан" гэж Тэрри хэлсэн юм.

Таннерыг цуглааны байраас ердөө нэг гудамжны цаана байдаг гэрт нь хүргэжээ. Гэвч тэр удалгүй ухаан алдаж, амьсгалахаа болив. Эмнэлгийн ажилтнууд болон түргэн тусламжийн баг түүний төлөө чадлаараа хичээж ажилласан юм. Харамсалтай нь гаргасан хүчин чармайлт талаар болов.

Таннер тэр шөнөдөө хоолны харшлаар нас барсан юм.

Дэлхий нийтийн асуудал

Дэлхий даяар хүүхдүүдийн тав орчим хувь нь хоол хүнсний харшилтай байна.[1] Нэгдсэн Улсад насанд хүрэгчдийн дөрөв орчим хувь, хүүхдүүдийн найм хүртэлх хувь нь харшилтай[2] бөгөөд энэ нь Европын болон Азийн зарим оронд бүртгэгдсэнтэй ижил түвшинд байна.[3] Энэ нь 200-аад насанд хүрэгчтэй тойрогт 8 орчим хүн, харин 50 хүүхэдтэй Хүүхдийн хэсэгт 4 орчим хүүхэд гэсэн үг юм.

170 гаруй хүнс харшил үүсгэгч хүнсний бүтээгдэхүүн байж болохоор бүртгэгдсэн ч Нэгдсэн Улсад хүнсний бүтээгдхүүний харшлын дийлэнх хувийг сүү, өндөг, газрын самар, модны самар, үр тариа,

ГАВЛЫН ЗУРГИЙГ РАЙН ХЭНДЭР



шар буурцаг, загас болон хавч хэлбэрийн хясаа[4] гэсэн "8 Т" бүтээгдэхүүн ээлж байна. Бүс нутгийн хувьд Энэтхэгт вандуй, Өмнөд Солонгос болон Японд сагаг буюу гурвалжин будаа, Хойд Тайландад шоргоолжны өндөг гэх мэт бусад хоол хүнс харшил үүсгэгчийн жагсаалтад дээгүүр байр эзэлдэг. Үнээний сүү болон өндөг дэлхийд хамгийн түгээмэл харшил үүсгэгч хүнсний бүтээгдхүүнүүдийн дунд тогтмол орж байдаг.[5]

Бие махбодын дархлааны системийн аюул гэж үздэг бодисыг хэрэглэвэл харшлын урвал үүсдэг. Эдгээр урвалаас хамгийн хурц хэлбэр нь үхэлд хүргэж болзошгүй маш хурдан явагддаг, системийн хариу урвал буюу анафилаксын шок юм.[6] Ам чимчигнэх, загатнах, уруул, нүүр, хэл эсвэл биеийн бусад хэсэг хавагнаж, дотор муухайрч, бөөлжих, амьсгалын зам боогдож бачуурах, зүрхний цохилт ихсэх, толгой эргэх, цочролд орох гэх мэт шинж тэмдгүүд илэрнэ.[7]

"Сүм дээр хэн нэгэн цус харван, зүрхний шигдээст өртөж байгаатай адил, энэ нь бүр үүнээс ч илүү ноцтойд тооцогдоно" хэмээн Сүмийн гишүүн, харшлын эмч Ионатан Оолсон онцлон тэмдэглэсэн юм. "Харшлын хариу урвал явагдаж байгаа хүн зүрхний шигдээс өвчтэй хүнээс хурдан нас барж болно."

Зарим эмчилгээ найдвар төрүүлж байгаа ч хүнсний харшлыг эдгээх эмчилгээ нэвтрээгүй байна. "Харшлаас зайлсхийж, анафилаксын шокийг таньж, эмчлэх нь" анхаарал халамж үзүүлэх арга хэлбэр гэж Оолсон эмч хэлсэн.

Хоол хүнс бол хайр

Хоол хүнс бол цугларалтын гол хэсэг юм. Энэ нь соёл, уламжлал, амралтыг төлөөлнө. Хоол хүнс нь бие махбодоо тэтгэхэд ашиглагддаг болович бидний сүнсийг тэжээх, хайр, анхаарал халамж үзүүлэх, хүмүүсийг цуглуулан холбож өгөхөд ашиглагддаг.

"Харшлын хариу урвал явагдаж байгаа хүн зүрхний шигдээс өвчтэй хүнээс хурдан нас барж болно."

Ялангуяа энэ нь сүм дээр үнэн байдаг. Хичээлд хамрагдахыг дэмжих эсвэл хичээлийг илүү хүчирхэгжүүлэх зорилгоор амттан өгдөг. Тойргийн потлак, хоолны тэмцээн болон бусад үйл ажиллагаа нь гэгээнтнүүдэд цугларч, нийгэмших шалтгаан болж болно. Бид шинэхэн ээжүүдэд болон оршуулгын ажилд зориулан хоол хийж, чин сэтгэлээсээ үйлчилдэг. Бид таныг бодож санаж явдгаа харуулан, хаалган дээр амттан үлдээдэг.

Аврагч хүртэл Өөрийнх нь зааж байгааг сонсохоор цугласан 5000 хүнийг хооллож байсан.[8]

Эдгээр жишээ хүнсний харшил яагаад зохицуулахад хэцүү, ялангуяа сүм дээр зарим хүний хувьд ойлгоход хэцүү байдаг гэдгийг харуулахад тусална. Хоол хүнс хайрын илэрхийлэл болох нь олонтоо. Гэхдээ тойргийн гишүүд хүнсний харшлыг тохинуулах боломж гэж үздэг бол *хоол авчрахгүй байх нь* хайрын илэрхийлэл болж чадна.

Ариун ёслолыг ариун нандин бөгөөд аюулгүй болгох

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд “Их Эзэний зоогон дээрх ариун ёслол [бол] бидний долоо хоног тутмын шүтлэг бишрэлийн ариун нандин, хүлээн зөвшөөрөгдсөн гол хэсэг юм. . . .

. . . Их Эзэний томилсон энэ цаг бол долоо хоногийн маань хамгийн ариун нандин цаг юм”[9] хэмээн хэлсэн.

Гэсэн хэдий ч, саяхан хоол хүнсний харшил, халдварын эсрэг явагдсан Сүмийн сургалтын талаар хэвлэгдэн гарсан удирдамжид “Хүнсний харшил, хоолонд үзүүлэх хариу үйлдэл нь хүний сэтгэл санааны байдалд нөлөөлж, сүмийн цуглаан, үйл ажиллагаанд оролцох чадварт чухал нөлөө үзүүлдэг”[10] гэжээ.

Сүмийн хүнсний харшлын удирдамж нь ариун ёслолын талхыг аюулгүй өгөх заавар, ариун ёслолын ширээн дээр бусадтай холилдуулахаас хэрхэн зайлсхийх зааврыг агуулдаг. (Дэлгэрэнгүй мэдээллийг disability.ChurchofJesusChrist.org хаягаар орж авч болно.) Эдгээр удирдамжийг дагах нь ихэнх гишүүнд ариун ёслолыг аюулгүй байлгахад тусалдаг.

Харшилтай гишүүд ариун ёслолын талхаа аюулгүй сонгох талаар удирдагчтайгаа ярилцаж болно.

Харшилтай гишүүд ариун ёслолд тохирсон өөрчлөлтүүдийн талаар бишоптойгоо ярилцаж болно. Гишүүд харшил үүсгэгчгүй талхыг битүүмжилсэн гялгар уутанд хийж өгч болно.

Үүнээс гадна, хүнсний харшилтай гэр бүлүүдэд хүмүүс ариун ёслолын цуглаан дээр хоолны төрлийн зүйл юм уу хөнгөн зууш авчрах төдийд л асуудал үүсэж болно. Зарим харшлын урвал зөвхөн хүнсний харшил үүсгэгчээр амьсгалах юм уу үүнд хүрэхэд сэдэрдэг тул хүнсний харшилтай гэр бүлүүд ариун ёслолын цуглааны өрөөнд хоол хүнс байгаа үед суудлаа солих юм уу үүдний хэсэг рүү гардаг.

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч Рассэлл М.Баллард 2015 оны 4-р сарын сургалт уулзалт дээр дараах зүйлийг зөвлөсөн. “Бидний үндсэн зорилго бол хүн бүр Хүндэтгэлийн өдрийг сахих замаар Тэнгэрлэг Эцэгт болон Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг бэхжүүлэх, сүнслэг мэдрэмжийг мэдрэх явдал юм. Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайрт Хүү, Их Эзэн Есүс Христэд зориулагдсан ариун ёслолын цуглааны

төлөө долоо хоногийн 168 цагаас ердөө ганцхан цагийг үнэ цэнтэй цагт зориулж, гар утас, iPad, тоглоом, хоол хүнсээ хойш тавьж болно гэдэгт бид итгэдэг"[11] гэжээ.

Янз бүрийн шалтгаанаар хүн бүр сүм дээр байхдаа хоол хүнснээс татгалзаж чаддаггүй. Гэвч богиносгосон цагийн хуваарийг, магадгүй бид ерөнхийлөгч Баллардын санал болгосон зүйлийг авч үзээд, ариун ёслолын цуглааны үед идэх зүйл танд хэрэгтэй эсэхийг үнэлж цэгнэж болох юм.

Нэг нэгнийхээ ачааг хөнгөлөх

Хүнсний бүтээгдэхүүний харшлын бие махбодод үзүүлэх нөлөө ноцтой байж болдгийн адил сүнслэг нөлөө нь сайн, муу адил гүн нөлөө үзүүлж байдаг.

Францэскагийн охин сүүний хурц хэлбэрийн харшилтай. Түүний охиныг Хүүхдийн хэсэгт байх үеэр багш нарын нэг нь төрсөн өдөрт зориулж гараар хийсэн аяган бялуу авчрах дуртай байв. Төрсөн өдөр тэмдэглэх үед идэхэд аюулгүй аяган бялуу авчирч байхыг Францэска санал болгов. Багш түүний саналыг хүлээж авалгүй, зургаан настай охиныг төрсөн өдрийн амттан хуваах үеэр коридорт суулгахаар явуулдаг байжээ.

"Энэ нь олон талаар гомдоодог байсан" гэж Францэска дурсан ярив. "Бусад хүүхдэд 'Есүс шиг байж' мөн бүгдийг оролцуулахаар санаа тавихыг заахын оронд тэрээр тэдэнд гадуурхахыг заасан."

Хоол хүнсний харшилтай гэр бүлүүдтэй ярилцах үед оролцуулах, гадуурхахын аль аль нь нийтлэг сэдэв байдаг. Газрын болон модны самрын харшилтай Синтиагийн 9 настай хүү өдрийн аялалд оролцохоор төлөвлөж байлаа. Гэвч аялалд явах өглөө нэг удирдагч нь утасдаж, хүүгийнх нь харшлыг зохицуулж чадахгүй учраас түүнийг ирэхгүй байхыг хүссэн байв.

"Би түүнтэй ярьж дуусаад, дахиад л гадуурхагдсан бяцхан хүүгийнхээ төлөө гашуудаж, сэтгэлийнхээ гүнд уйлсан" гэж Синтиа хэлэв.

Сүмийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хариуцсан мэргэжилтэн менежер Кати Эдна Стийд "Аврагч 99-өө орхиод нэгийнх нь араас явах байсан. Бид нэгийг нь харж, нэгийг мэддэг байх үлгэр жишээг санадаг байх ёстой" гэжээ.

Бид тэдэнд тусалж чадна

Хүнсний харшилтай гишүүд болон тэдний тойргийн гэр бүлүүд хайраа үзүүлэх, сүмийн оролцоог аюулгүй, хүртээмжтэй болгохын тулд маш их зүйл хийж чадна.

Хоол хүнснээс харшилдаг гэр бүлүүд юу хийж чадах вэ?

Үйл ажиллагаа юм уу хичээл бэлтгэж байгаа үед асуух асуултууд

1. Хичээл эсвэл үйл ажиллагаандаа хоол оруулах нь миний өгөх захиаст дэмжлэг үзүүлж байна уу эсвэл ангийн гишүүдийг захиасаас маань сатааруулж болзошгүй байна уу? Хичээлээс эсвэл үйл ажиллагаанаасаа хоолоо хасаж болох уу?
2. Хэрэв хоол хүнс миний үйл ажиллагааны чухал хэсэг юм бол хүнсний харшилтай хүмүүст би хэрхэн тохинуулах вэ? Бүх хүнд аюулгүй мөртлөө зорилгод маань нийцэх ямар ямар хоолны сонголт байдаг вэ? Би хувь хүн, эцэг эхчүүдээс аюулгүй хүнсээр хангахыг эсвэл аюулгүй сонголтуудыг олоход туслахыг хүсэж болох уу?
3. Хэрэв хүн болгонд тохирсон зүйлийг өгөх арга байхгүй бол харшилтай хүмүүст өөр сонголт гаргаж өгч болох уу? Би харшилтай хүмүүстэй шууд холбоо барьж, тэдэнд тааламжтай байх төлөвлөгөө гаргаж болох уу?

Харшилтай гэр бүлүүд өөрсдийн хэрэгцээг удирдагч, багш нарт тайлбарлахаас гадна удирдагч, багш нараа солигдоход дахин тэдэнтэй холбогдож болно. Тэд аюулгүй хоол хүнс нийлүүлэх, цэс, үйл ажиллагаа төлөвлөхөд туслах боломжтой. Тэд энгийн, амь аврах сургалт болон яаралтай тусламжийн төлөвлөгөө гаргаж болно. Тэд гишүүдийг айж эсвэл санаа зовниж буйгаа илэрхийлэх үед ойлгон хүлээн авч, тэвчээртэй байхад сургаж, аюулгүй, хүртээмжтэй хувилбарыг олохын тулд хамтран ажиллаж болно. Тэд тойргийнхоо хийж, дэмжиж болох боломжийн нөхцөлүүдийг хүсэх хэрэгтэй.

Тойргийн гишүүд юу хийж болох вэ?

Тойргийн гишүүд хувь хүний нөхцөл байдлыг ойлгохыг хичээж болно. Тойргийн гишүүд хүүхдийг хооллох талаар эцэг эхийнх нь өгсөн зааврыг дагаж мөрдөх хэрэгтэй. Хэрэв үйл ажиллагаа юм уу хичээл дээр хоол байх шаардлагатай бол багш удирдагчид хоол хүнс аюулгүй эсэхийг хувь хүн болон эцэг эхчүүдээс асууж болно. Шаардлагатай бол тойргийн гишүүд хувь хүмүүс, эцэг эхчүүдийг оролцуулж, асуудлыг шийдвэрлэхэд урьж болно.

Сюзанна хэд хэдэн хүнсний бүтээгдэхүүнд харшилтай. Тойргийнх нь санваартнууд ариун ёслолыг бэлтгэхдээ түүнд тусгайлан хандаагт сэтгэл нь хөдөлдөг. “Миний ариун ёслолоос хүртэх үйл явцыг аюулгүй болгодог залуу хөвгүүдийг бодоход би үнэхээр даруусдаг” гэж тэр хэлэв.

Нэгэн ням гарагт түүнд ариун ёслол түгээгээгүй байв. Ариун ёслол бэлтгэж байсан санваартнууд ширээн дээрх түүний талх бусад талхан дунд холилдсон байсныг анзаарчээ.

“Тэд ариун ёслолын цуглааны дараа намайг олоод, юу болсныг тайлбарлаж, ариун ёслолыг надад зориулж ангид түгээх тусгай зөвшөөрлийг бишопоос авснаа хэлсэн” гэж Сюзанна хэлэв. Жижиг өрөөнд ороод тэднийг надад зориулан ариун ёслолыг адисалж, түгээх үед би уйлсан. Би Аврагчийн хайрыг маш хүчтэй мэдэрсэн ба энэ асуудлаасаа болоод хэчнээн их зовж байгааг маань мэддэгийг би мэдэж авсан юм.

“Хүнд харшилтай хүмүүст сүм дээр аюулгүй орчныг бүрдүүлэхэд бэлэн байгаа нь бие биенийхээ ачааг үүрэлцэхэд бэлэн байгааг харуулдаг” гэж Сюзанна хэлсэн билээ.

“Аврагч 99-өө орхиод, нэгийнх нь араас явах байсан. Нэгийг харж, нэгийг нь санаж байгаарай.”

Францэскагийн охин одоо Залуу эмэгтэйчүүдэд явж байгаа. Түүний Залуу эмэгтэйчүүдийн ерөнхийлөгч энэ гэр бүлийн ачааг үүрэлцэхэд туслахаар сүнслэгээр өдөөгдсөн юм. “Тэднийг аюулгүй байдал, шүтлэг бишрэл хоёрын аль нэгийг сонгохоос өөр аргагүйд хүргэхгүйн тулд бид үүнийг хийх ёстой гэж би бодсон. Бид энэ нөхцөл байдалд хэрхэн хандах ёстой талаар залбирч, энэ гэр бүлийг хүлээн авч, тэднийг бүрэн дүүрэн хамруулах ёстойгоо баттай мэдэж авсан“ гэж тэр хэллээ.

Гэр бүл, багш нар, удирдагчид хамтдаа ажиллаж, сүмийг хүн бүрд сурч, өсөж хөгжихөд аюулгүй газар болгох боломжтой.

Өсвөр үеийнхний удирдагчид Францэскагийн охинд аюулгүй оролцох боломжтой, хоногоор явах өсвөр үеийнхний чуулганыг төлөвлөх уриалгыг хүлээн авсан юм. Францэска хоол хүнсний цэс гаргаж, дэлгүүр лүү явахад нь тусалжээ. Залуу эрэгтэйчүүд шанаган тогоон дээр хоол хийхээсээ өмнө дараалттай усаар угааж өгч байсан.

“Энэ нь гайхалтай санагдсан. Тэднийг сайхан сэтгэл гаргаж, намайг оролцуулж байгаад нь би уйлж, Бурханы хайрыг мэдэрсэн. Миний охин ч мөн адил” гэж Францэска хэлэв.

Бурханы ажлууд илчлэгдэв

Таннерын гэр бүл хүүгээ алдсанаас хойш том, жижиг олон гайхамшгийг мэдэрч байгаа. Тэд хүнсний харшлын талаарх мэдлэгийг түгээх нь эдгээрийн нэг гэж үзэх болсон юм.

“Харшилтай хүүхдүүд хариуцлагагүй эсвэл тоомжиргүй ханддаг гэсэн үг биш юм. Тэд чинь хүүхдүүд шүү дээ” гэж Таннерын аав Тэрри хэлэв. “Хормын төдийд л анхаарал нь суларч болно.”

Харин тохинуулал тэднийг анхааралтай байхад тусалж чадах юм. “Тохинуулал гэдэг нь бусдын хэрэгцээг хангах явдал гэсэн утгатай” гэж Оолсон эмч хэлжээ. “Сүмийн бүхий л зүйл хүн бүрийн хэрэгцээнд мөн тэдний сүнслэг болон бие махбодын хэрэгцээнд нийцэж байгаа эсэхэд тулгуурладаг.”

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Шэрон Юбанк: “Христ нифайчуудад ‘Би *та нарын хэнийг* нь ч зайлан явахыг та нарт зарлиг болгосонгүй’ . . . гэж хайрлангуй айлдсан. Христийн шашинтай шавь нар болон хожмын үеийн гэгээнтнүүд бие биедээ жинхэнэ хайрыг үзүүлэх нь үл хувирах шаардлага билээ[12] гэж хэлсэн юм.

Францэскагийн хувьд, тэрээр хүүхдээ яагаад хүнсний харшилтай болсныг ойлгох гэж ихэд хичээсний эцэст “Бурхан заримдаа Өөрийн алдар сууг улируулан авчрахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хэн нэгнийг эдгээдэг ч заримдаа бусад хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрхэн хандаж байгаагаар Өөрийн ажлуудыг үзүүлэхийг хүсдэг учраас бэрхшээлтэй хэвээр нь үлдээдэг. Мөн Бурхан хэн нэгний зовлон зүдгүүрт гайхамшиг тохиохыг зөвшөөрснөөр элдэг байхад болон Өөртэй нь адилхан болоход суралцах бүхий л боломжийг олгосон” гэдгийг ойлгожээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. “Food Allergies: Global Burden, Causes, Treatment, Prevention and Public Policy” (consensus study by the U.S. Institute of Medicine, 2017), National Academies of Science-ыг үзнэ үү.
2. Wenyin Loh and Mimi L. K. Tang, “The Epidemiology of Food Allergy in the Global Context,” *International Journal of Environmental Research and Public Health,* vol. 15, no. 9 (Sept. 18, 2018), 2043, ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC6163515.
3. Alison Joanne Lee, Meera Thalayasingam, and Bee Wah Lee, “Food Allergy in Asia: How Does It Compare?” *Asia Pacific Allergy,* vol. 3, no. 1 (Jan. 2013), 3–14, ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC3563019/; FARE: Food Allergy Research & Education. “Food Allergy Facts and Statistics for the U.S.,” foodallergy.org/sites/default/files/migrated-files/file/Final-FARE-Food-Allergy-Facts-Statistics.pdf. Зарим хүнсний харшлаас ангижирч болдог бөгөөд энэ нь насанд хүрэгчидтэй харьцуулахад хүүхдүүдэд их тохиолдож байна.
4. FARE, “Food Allergy Facts and Statistics for the U.S.”
5. Loh and Tang, “The Epidemiology of Food Allergy in the Global Context.”
6. “Signs and Symptoms,” anaphylaxis.org.uk/hcp/what-is-anaphylaxis/signs-and-symptoms.
7. Mayo Clinic, “Food allergy,” mayoclinic.org.
8. Марк 6:37–44; Лук 9:10–17-г үзнэ үү.
9. Жэффри Р.Холланд, “Бурханы Хургыг болгоогтун,” *2019 оны 4-р сарын Ерөнхий чуулган*.
10. “Food Allergies,” in the Policies and Guidelines section of disability.ChurchofJesusChrist.org.
11. M. Russell Ballard, in “April 2015: Sabbath Day Observance” (video), ChurchofJesusChrist.org/media-library.
12. Sharon Eubank, “Christ: The Light That Shines in Darkness,” *Liahona,* May 2019, 74; emphasis added.



Бид бодол болон үг маань бидэнтэй адил аяллыг туулж байгаа хэн нэгнийг адислаасай гэсэндээ тусгай хэрэгцээтэй охин Дорагийнхаа туршлагаас сурсан цөөхөн хэдэн зүйлээ хуваалцмаар байна.

Далын ахлагч
Паул Б.Пиепэр ба Мэлиссан Т.Пиепэр

Тусгай хэрэгцээ ба онцгой сургамж

Охин Дорагаа кесарево хагалгаагаар төрүүлээд хэд хоносны дараа бид түүний ямар нэг зүйл өөр байгааг мэдсэн юм. Гэхдээ түүнийг төрөөд, гурван долоо хоносны дараа эмчийн үзлэгийн өрөөнөөс эмнэлэг рүү яаралтай хүргэгдэхэд л бид түүний төрсөн нь манай гэр бүлийн амьдралыг өөрчлөх үйл явдал болно гэдгийг ухаарч эхэлсэн.

Дараагийн хэдэн сар мэргэжилтнүүд Дорагийн нөхцөл байдлыг оношлохоор хичээх үед бид их итгэл найдвар өвөрлөхийн зэрэгцээ бас айж, сэтгэл тавгүйтэж байлаа. Шинэ онол бүр сэтгэл түгшээж байв.

Бид нэг онош тавигдахад “Өө үгүй ээ, *энэ л* биш байгаасай. Бид охиноо алдмааргүй байна” гэж байв. Өөр онош тавих үед “Энэ бүхэн *үнэн* бол бид хэрхэн даван туулахаа мэдэхгүй байна” гэж хариулж байлаа.

ПИЕПЭРИЙН ГЭР БҮЛИЙН ӨГСӨН ДОРАГИЙН ЗУРГУУД

Онош нь хоёр иртэй сэлэм шиг байв. Энэ нь хариултыг өгч, ирээдүйгээ ямархуу байхыг харахад хэн нэгэнд тусалж болох ч нөгөө талдаа бас бодит бус ч байж болох шаардлага юм уу хязгаарлалтуудыг үүсгэж болох байв. Бүх онол дүгнэлт, шинжилгээ гарсны дараа эмч нар Дорагийн өвөрмөц оношийг гаргаж чадаагүйд бид хувьдаа талархдаг.

“Тэр бие физиологийн хувьд бүх талаараа зүгээр боловч булчингийн сулралтай мөн татаж унадгаас болж өвдсөн байна” гэж тэд хэлсэн юм.

Бид сүүлийн 28 жил ийм дүгнэлттэйгээр буюу тодорхойгүй байдал, төвөгтэй асуудал, бэрхшээл, баяр баясгалан, боломжуудтай хамт амьдарч ирсэн. Бид

Бид Дораг түүний хязгаарлагдмал байдлаар биш, түүний чадвараар тодорхойлох дуртай.

замаа ямархуу байхыг огт мэдээгүй боловч эмнэлгийн тодорхой оношоос болж бидэнд хэзээ ч хязгаарлагдмал мэдрэмж төрж байгаагүй.

Тусгай хэрэгцээтэй хүнийг тодорхойлох

Бид олон жил Дорагийн талаарх "Түүнд юу тохиолдсон юм бэ?" "Тэр ямар өвчинтэй вэ?" гэдэг асуултуудыг их сонсдог байв. Бид ерөнхийдөө "Тийм ээ, тэр ярьж чадахгүй, тусламж авахгүй бол явж чадахгүй, өөрийгөө хооллож эсвэл хувцаслаж чадахгүй ч түүнд үүнээс илүү олон зүйл бий" гэхчлэн хариулдаг байв.

Бид түүнийг хязгаарлагдмал байдал болоод чадахгүй зүйлсээр нь тодорхойлохгүй байхыг сурсан. Харин бид түүнийг чаддаг зүйлсээр нь тодорхойлох дуртай.

Жишээ нь, Дора инээж чадна. Түүний инээмсэглэл эргэн тойрныхныгоо инээлгэдэг. Танихгүй хүмүүс хүртэл Дорагийн гэрэлтсэн инээмсэглэлд автсандаа түүнтэй зураг авахуулахыг хүсэн, биднийг нисэх онгоцны буудал дээр саатуулж байсан.

Тэр тэвэрч чадна. Танд Дорад тэврүүлэх аз таарвал таны амьдрал өөрчлөгдөж ч болно. Нэг удаа, биднийг спортын тоглолтоос гарч явтал Дора явган хүний зам дээр сууж байсан орон гэргүй хүний дэргэдүүр өнгөрөхдөө түүнд хүрч, тэвэрсэн юм. Охины минь тэврэлт тэр өдөр түүнд тохиолдсон хамгийн гайхамшигтай зүйлийн нэг байсан нь түүний царайнаас илт байв.

СУЛ ДОРОЙ БИЕ, ТЭНГЭРЛЭГ ХУВЬ ТАВИЛАН



"Бурханлаг чадавхдаа хүрэхийн тулд төгс биетэй байх шаардлагагүй. Үнэндээ, хамгийн энхрий зөөлөн сүнснүүд хамгийн сул дорой биед оршдог. Сул дорой биетэй хүмүүс сорилттой тулгардаг тул тэд асар их сүнслэг хүчийг хөгжүүлсэн байдаг. Ийм хүмүүс итгэлтэй бөгөөд дуулгавартай хүүхдүүддээ зориулан Бурханы бэлдсэн бүх адислалыг хүртэх эрхтэй."

President Russell M. Nelson, "Your Body: A Magnificent Gift to Cherish," *Liahona,* Aug. 2019, 53.

Дора хүмүүст хайр мэдрэхэд тусалдаг. Дора тантай нэг хором боловч харц тулгарах л юм бол та хайрыг мөн нүдэндээ нулимс цийлэгнэх баяр баясгаланг мэдрэх болно. Ийм гайхалтай бэлгүүд байхад бид яагаад түүнийг "хөгжлийн бэрхшээлтэй" эсвэл "тахир дутуу" гэж цоллох ёстой билээ? Тэр зөвхөн байгаа байдлаараа болон байнга хийдэг зүйлсээрээ олон зуун хүний амьдралд сайн нөлөө үзүүлсэн юм.

Нэг өдөрт нэг л удаа

Эцэг эхчүүд хүүхдээ насан туршдаа өөрсдийг нь түшиж тулгуурлана гэдгийг мэдээд, санаа зовох нь амархан байдаг. Хүүхэд байнга бие махбод, сэтгэл санааны болон эмнэлгийн тусламж шаарддаг бол сэтгэлийн зовлонг улам нэмж болно. Хүүхдээ өдөр бүр хооллож, хувцаслаж, усанд оруулж, асран хамгаалж, тэтгэнэ гэсэн бодол нь авирч гарахад хэт өндөр уул мэт харагдаж болно.

Ийм үед түр зуур амсхийнгээ, "Би өнөөдөр л үүнийг хийх хэрэгтэй" гэж хэлэх нь чухал. Зөвхөн тухайн өдрийн хэрэгцээ, боломждоо анхаарлаа хандуулснаар ажлуудаа илүү сайн хийж болмоор болж байгааг бид олж мэдсэн. Бид нэг өдөрт нэг л удаа амьдарч чадах бөгөөд тэр өдөр ирдэг баяр баясгалан, өсөлтийг хайж олох боломжтой.

Өсөж томрох чадвартай

Дэлхийд илгээгдсэн бүх сүнс “өсөж томрох”[1] чадвартай. Бид бүхнийг сонгох эрхээ чадах чинээгээрээ ашиглаасай гэж хүсдэг. Бид асран хамгаалагчдын хувьд асрамждаа байгаа хүмүүсээ бие бялдар, сэтгэл зүй, сүнслэг байдлаараа өсөж хөгжихөд нь чадах чинээгээрээ туслах үүрэгтэй. Энэ нь Дорад тэвэрч, инээмсэглэх гээд үйлчлэх боломжуудыг гаргаж тусална гэсэн үг. Энэ нь тэдэнд эмчилгээ, үйл ажиллагаанд хамрагдах, бие махбод болон сэтгэцийн чадвараа ашиглах мөн боломжтой бол нэмэгдүүлэхэд нь тэдэнд тусална гэсэн үг юм.

Ингэхдээ бид бодитой хандах хэрэгтэй. Хэрэв бид байнга бухимддаг бол хэтэрхий хүчилдэг байж магадгүй юм. Их Эзэн бидэнд тусалж чадах бөгөөд боломжтой, тохирох зүйлсийг хийхэд биднийг Өөрийн Сүнсээр дамжуулан удирдан чиглүүлж чадна. Зарим тохиолдолд Тэр бидэнд жижиг гэлтгүй гайхамшгуудыг өгөх болно.

Дораг ортопедын тэргүүлэх мэргэжилтэн хэзээ ч алхаж чадахгүй гэж байсныг бид тодхон санадаг. Гэвч олон жил залбирч, мөн шаргуу хөдөлмөрлөсний эцэст одоо Дора бусдын тусламжтайгаар алхаж чадах болсон. Түүний биеийн байдал өөрчлөгдөөгүй ч Их Эзэн түүнийг өсгөн торниулж, амьдралаас илүү таашаал авахад нь туслахын тулд бидэнд олон жижиг гайхамшгийг өгсөн юм.

Эдгэрэхгүй байсан ч итгэлтэй байх

Бурханы үнэ цэнтэй, ямар нэг асуудалтай хүүхдийг бидэн дээр ирэх үед цаанаасаа л *яагаад* гэж асуух гээд байдаг. Бид нэг л мэдэхэд итгэлээрээ эдгэрэх боломжтой юу эсвэл хүүхдийн нөхцөл байдлыг арилгаж болох уу гэж Бурханаас асуудаг. Бурхан охиныг минь эдгээж чадна гэдэгт бид бүрэн итгэдэг ч үүнийг одоо хийх нь Түүний хүсэл биш гэдгийг бидэнд ойлгуулсан юм.

Тэнгэрлэг Эцэг Дораг бидэнд илгээхдээ, Өөрийн гэсэн зорилготой байсан бөгөөд Тэр түүнийг хүссэн цагтаа, эдгээх цагтаа эдгээх болно. Тэр өдөр эцсийн эдгээлт болох Амилалтын цагийг хүртэл ирэхгүй байж ч мэднэ. Тэр эдгээр хүүхдийг одоо эдгээж чадна гэдэгт итгэдэг шигээ энэ эрхэм хүүхдүүд маань одоо эдгээгдэхгүй гэдэг нь Бурханы хүсэл гэдгийг хүлээн зөвшөөрөхөд маш их итгэл шаардагддаг. Дораг бидэнд ямар нэгэн зорилгоор илгээсэн бөгөөд бид *яагаад* гэдгийг эрэлхийлэх бус, харин Тэнгэрлэг Эцэг биднийг *юуг* сураасай гэж хүссэн сануулгыг мэдэрсэн.

“Энэ явдал яагаад надад тохиолдов? Юуны учир би одоо ингэж зовох ёстой юм бэ? Би ийм зүйл болох юуг хийсэн юм бол? гэх асуултууд таныг мухардалд хүргэнэ” гэж Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт (1928–2015) хэлжээ. Харин оронд нь, “Би юу хийх ёстой вэ? Энэ туршлагаас би юу сурч авах хэрэгтэй вэ? . . . гэж асуу. Таны хүслийг мэдэх боломжийг надад олгоно уу,’ ‘Таны хүсэл биелэгдэх болтугай’ гэсэн чинхүү итгэл үнэмшлээр та залбирдаг бол, хайраар дүүрэн Эцэгээсээ хамгийн их тусламж хүлээн авах баталгаатай байр сууринд байгаа нь тэр”[2] гэж тэр хэлсэн.

Заримдаа Аврагчийн мөнх бус амьдрал дахь тохиолдлын үеэр Түүний эдгээсэн хүүхдүүдийн эцэг эхийн талаар бид боддог. Магадгүй тэр эцэг эхчүүд ч гэсэн бидэнтэй адил хүүхдүүд нь ямар зорилгоор тэдэнд ирснийг гайхаж байсан байх. Аврагч тэднийг эдгээснийхээ дараа, хэрэв тэнд эдгээх хэн нэгэн байгаагүй бол Өөрийн эдгээх хүч болоод бурханлаг байдлыг үзүүлэх боломж Түүнд байхгүй байсан гэдгийг тэр эцэг эхчүүд ойлгосон. Эдгэх цаг хугацаа Бурханы бүх хүүхдэд ирнэ гэдэгт бид итгэдэг.[3]

Бид тэр өдрийг тэсэн ядан хүлээж байна. ■

Бид асран хамгаалагчдын хувьд, асрамжилж байгаа хүмүүсээ бие бялдар, сэтгэл зүй, сүнслэг байдлаараа өсөж хөгжихөд нь чадах чинээгээрээ туслах үүрэгтэй.

ЭШЛЭЛҮҮД

1. “Бурханы дэлхийд илгээсэн бүх оюун ухаан болон сүнснүүд өсөж хөгжих чадвартай” хэмээн бошиглогч Иосеф Смит заасан байдаг (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* 2007, 210).
2. Ричард Г.Скотт, “Trust in the Lord,” *Ensign,* 1995 оны 11-р сар, 17.
3. “Эдгэрэхгүй байсан ч итгэл”-тэй байх талаар ойлгодог болохын тулд ахлагч Дэвид А.Бэднарын “Accepting the Lord’s Will and Timing,” *Liahona,* Aug. 2016, 16–23-ыг үзнэ үү.

Хүн бүрд хандсан бошиглогчийн үг

Би Бурханы бошиглогчийн үгийг сургуулийн ханан дээрээс олж харна гэж огт бодож байгаагүй.

Би өглөө эрт сэрж, ажилдаа бэлдэв. Би багшийн ажилдаа ихэнхдээ дуртай байдаг ч сэтгэл санаа онцгүй байсан тул хөнжилдөө буцаж шурган, дахин унтмаар санагдаж байлаа.

Би ахлах сургууль дээр ирээд, оюун санаагаа ажилдаа бэлдэх гэж хичээж байв. Би математикийн хичээл удахгүй заана гэдгээ мэдэж байсан ч зүрх, толгой хоёр дүйнгэтэж, сэтгэл хямарсан байв. Сэтгэл санаа минь бүхэлдээ сөрөг болсон байв.

Би хичээл эхлэхээс өмнө ариун цэврийн өрөө орохоор шийдэв. Хэн нэгэн үе үе сурагч, ажилтнуудад зориулсан мэдээлэл бүхий хуудсыг ариун цэврийн өрөөнд байрлуулдаг байв. Нүдний буланд нэгэн хуудас харагдлаа. Тэнд “Хэрэв та бусдад гэрэл өгөхийг хүсвэл, өөрөө гэрэлтэн гялалзах хэрэгтэй”[1] гэж бичсэн хуудас байв. Би энэ үгс ерөнхийлөгч Томас С.Монсоны (1927–2018) хэлсэн үг болохыг хараад гайхав.

Би Бурханы бошиглогчийн үгийг сургуулийн ханан дээрээс олж харна гэж огт бодож байгаагүй. Би АНУ-ын Пеннсильвани мужийн жижиг хотод амьдардаг ба сургуулийнхаа цөөхөн хэдэн эсвэл цорын ганц Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн гэдэгтээ итгэлтэй байна. Би олон жил бошиглогчоор дэмжиж ирсэн ерөнхийлөгч Монсоны хэлсэн үгийн ач холбогдлыг ойлгох цөөн хүний нэг гэдгээ мэдэж байв. Энэ захиас надад зориулагдсан байсныг би мэдэрсэн. Энэ нь миний сэтгэлийг зөөллөж, зан аашийг сэргээв. Гэрчлэлдээ талархах талархал зүрх сэтгэлийг минь дүүргэж, Тэнгэрлэг Эцэгийн хайр намайг хүрээлсэн юм.

Би ханан дээрээс хуудсыг авч, сэтгэл санаагаа өөдрөг байлгахаар өдөржин халаасандаа байлгахыг хүссэн ч гэнэт нэг зүйлийг ойлгов. Ерөнхийлөгч Монсон зөвхөн миний болон Сүмийн гишүүдийн бошиглогч биш, харин дэлхийн бошиглогч байсан. Түүний үгс өнөөгийн ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны үгстэй адил хүн бүрд зориулагдсан. Бошиглогчийн үгс тэднийг сонсох хүн *бүрд* тусалж мөн тэднийг өргөх болно. Би утсаараа уг эшлэлийн зургийг аваад, хэрэг болж магадгүй хүмүүст зориулан зурагт хуудсыг тэнд нь орхив.

Тэнгэрлэг Эцэг тэр захиасыг зам дээр минь үлдээсэнд би талархаж байна. Би бусдад гэрэл түгээхийг хүсэж байна. Бид Аврагчид дуулгавартай байж, Түүн рүү ойртсоноор харанхуй намайг замаас маань гаргахыг хүссэн үед ч гэрэлтэж чадна. ■

Кэтрин Фургесон, АНУ-ын Пеннсильвани

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МЭРРИЛИЙ ЛИДИАРД

ЭШЛЭЛ

1. Thomas S. Monson, “For I Was Blind, but Now I See,” *Liahona,* July 1999, 69.

“Би итгэлээ үгүйсгэхгүй”

Ажил дээр намайг шоолж, үл тоомсорлодог байв. Яагаад би сүнслэг сайн сайханд минь аюул учруулсан ажилтайгаа зууралдсаар байгаа юм бол?



Намайг томоохон номын сангийн захирлын туслахаар ажилд орсны дараахан манай хамт олон 37000 номыг цахим болгох томоохон төслийг эхлүүлсэн. Нэг өдөр манай ахлах ажилтан намайг өрөөндөө дуудлаа.

Тэр “Эдвард, намайг АНУ-д номын цахим төслөө танилцуулж, шинэ худалдан авалтууд нэмж хийхэд урьсан. Тэд надаас итгэлтэй хүнээ авчрахыг хүссэн юм. Би танай сүмд биш, харин чамд итгэдэг. Хэрэв чи итгэлээ орхих юм бол надтай хамт явж болно” гэж хэлэв.

Намайг юм хэлж амжаагүй байхад тэр энэ талаар бодож үзээрэй гээд намайг орхиж явсан.

Орой нь би эхнэртээ юу болсон тухай хэлэв. Тэр намайг итгэлтэй байхад урамшуулсан юм. Маргааш нь би ахлах ажилтандаа итгэлдээ үнэнч хэвээр байна гэдгээ хэлсэн. Тэр уурлаж, аялалдаа ганцаараа явна гэв.

Нэг жилийн дараа надад номын сангийн санхүүжилт, шинэ худалдан авалт, менежментийн чиглэлээр сургалтад явахын тулд Франц руу аялах боломж олдов. Би зөвхөн ахлах ажилтнаараа батлуулах хэрэгтэй байлаа. Тэр намайг итгэлээ үгүйсгэвэл зөвшөөрнө гэв. Би дахин татгалзсан. Гэтэл тэр бичиг баримтуудыг урж, миний нүүр рүү шидсэн юм. Хэсэг хугацааны дараа ахлах ажилтан маань над дээр дахин ирж, “Би өөр аялалд явах гэж байгаа. Чи надтай хамт явж болно, гэхдээ болзол хэвээрээ. Би хэзээ ч танай сүмийн гишүүнтэй хамт аялахгүй” гэв.

Би тэгэхэд нь, “Би итгэлээ үгүйсгэхгүй” гэсэн юм. Тэр юу ч хэлэлгүй цааш явав. Удалгүй тэр миний талаар ажлынханд маань ярьж эхлэв.

“Би түүнд олон боломж олгосон ч тэр мухар сүсгээсээ болоод боломжуудаа үгүй хийсэн. Тэр тэнэг” гэж хэлсэн байв.

Тэр цагаас хойш ажил дээр намайг шоолж, үл тоомсорлодог болсон юм. Би сэтгэлээр унав. Би нэг орой энэ асуудал дээр анхаарлаа төвлөрүүлж байхдаа Библиэ гаргаж, “Баруун нүд чинь чамайг бүдрүүлбэл ухаж аваад хая. Учир нь бүтэн бие чинь тамд хаягдсанаас эрхтний чинь нэг байхгүй нь чамд дээр” (Матай 5:29) хэмээн уншлаа.

Хэрэв Их Эзэн биднийг өөрсдийгөө аврахын тулд ямар нэгэн юмнаасаа сал гэсэн юм бол би яагаад сүнслэг сайн сайханд минь аюул учруулсан ажилтайгаа зууралдсаар байгаа юм бэ? Маргааш нь би халагдах өргөдлөө өгсөн.

Өнөөдөр би энэ сонголтдоо баярладаг. Есүс Христэд итгэх итгэл, зоригоосоо болоод би ажил дээрээ доромжлуулж, түр зуур ажилгүй байж үзсэн. Миний шинэ ажил одоо надад урьд өмнө байгаагүй боломжуудыг олгож байна. Их Эзэн намайг адисалсан бөгөөд Түүний сайхан сэтгэл, намайг гэсэн хайранд би талархаж байна. ■

Эдвард Нгинду, Катока, Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс

ЗУРГИЙГ ГРЭГ СТИВЭНСОН

Бидэнд дахин нэг гайхамшиг хэрэгтэй байв

Манай эхнэрийг жирэмслэхэд бидэнд аль хэдийн нэг гайхамшиг тохиолдсон байсан. Одоо өөр нэг гайхамшиг тохиох хэрэгтэй болоод байв.

Манай эхнэр Сара 24 долоо хоногтой жирэмсэн байхдаа маш хүндээр өвдөж эхэлсэн юм. Би түүнд адислал өгөөд, дараа нь ажилдаа явлаа. Намайг ажил дээрээ байж байтал тэр эмнэлэг рүү хүргүүлэх гэж над руу залгасан юм.

Биднийг ирэхэд “Хүүхэд чинь төрөх гэж байна” гэж хэлэв. Сара 24-хөн долоо хоногтой байсан тул хүүхдийг амьд авч үлдэх хамгийн сайн арга бол кесарево хагалгаа байлаа.

“Эхнэр чинь үүнээс илүү хүндрэл нэмж туулах хэрэггүй. Таны хүүхэд амьд үлдэж чадахгүй болж байна” гэж эмч хэлэв.

Сара бид хоёр эмчийн хэлсэн зүйлсийн талаар ярилцаж, залбирсан. Хүүхдэд маань амьд гарах жаахан ч гэсэн боломж байгаа бол бид тэр боломжийг ашиглахаар шийдсэн юм. Бид хүүхэдтэй болж чадахгүй байсан болохоор том хүү Тэйлороо өргөж авсан байв. Тэйлорыг өргөж аваад хоёр жил болсны дараа Сараг жирэмслэхэд бид үүнийг гайхамшиг гэж үзсэн. Тэгвэл одоо хоёр дахь гайхамшиг хэрэгтэй болсон нь энэ байв.

Хэсэг хугацааны дараа нэг нарийн мэргэжлийн эмч бидэн дээр ирж, “Бидэнд таны эхнэрийг дутуу төрсөн, хүнд өвчтэй нярайнуудыг эмчлэх тоног төхөөрөмжөөр хангагдсан Техасын Эль Пасо дахь хүүхдийн эмнэлэгт хүргэх цаг байгаа байх гэж бодож байна. Хүүхэд тань тэнд амьд гарах боломж байгаа” гэж хэлэв.

Түргэн тусламжийнхан Сараг орон нутгийн эмнэлгээс авч, 45 минутын зайтай байдаг хүүхдийн эмнэлэг рүү хурдлан явлаа. Би араас нь ойрхон дагаж, гайхамшиг тохиохыг гүйн Их Эзэнд залбирч байв. Би сайн мэдээний зам дээр үлдэж, илүү сайн байхыг хичээнэ хэмээн Түүнд амласан.

Би эмнэлэгт нярайн эрчимт эмчилгээний тасгийн эмчид “Эхнэр маань жирэмсэлж, бидэнд нэг гайхамшиг тохиолдсон гэдгийг бид мэднэ. Одоо бидэнд өөр нэг гайхамшиг хэрэгтэй байна” гэж хэлж билээ.

Төрөлт сайн явагдаж, хүүхэд маань эсэн мэнд үлдсэн юм. Тэрбээр нярайн эрчимт эмчилгээний тасагт дөрвөн сар гаруй хугацааг өнгөрөөсний дараа бид Шаннаг гэртээ авчирсан. Бидэнд хоёр дахь гайхамшиг *тохиолдсон* юм. Цөөн хэдэн жилийн дараа бидэнд дахин нэг гайхамшиг тохиож, Их Эзэн биднийг ихэр хүүхдээр адислав.

Шанна IQ багатай, тэргэнцэр дээр байдаг ч баяр хөөрөөр дүүрэн, үргэлж эерэг байж, хүн бүхэнд нөхөрсөг ханддаг. Тэр өдрөө хэрхэн өнгөрүүлснээ ярих дуртай байдаг бөгөөд амьдралдаа баяр хөөртэй байдаг. Тэр биднийг инээлгэж, аз жаргалтай байхыг зааж өгдөг. Бид охиндоо хайртай бөгөөд түүний төлөө талархдаг. Шанна бол үнэхээр бидэнд ирсэн адислал юм. ■

Даниел Пэйн, АНУ, Нью Мехико

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРЭДЛИ КЛАРК

Ариун сүмийн нээлттэй хаалганы өдөр зүрх сэтгэлийг минь нээсэн

Ариун сүмийн нээлттэй хаалганы өдөр зарлагдахад Их Эзэн намайг Өөрийн өргөөнд орохыг хувиараа урьж байгаа юм шиг надад санагдсан.

Би 15 насандаа баптисм хүртсэн юм. Олон хүн миний шинэ итгэл үнэмшлийг ойлгохгүй байлаа. Зарим хүн тэр дундаа найз нөхөд маань хүртэл Сүмд нэгдэх шийдвэр гаргасанд намайг шоолж байв. Эцэг эх маань Сүмийн гишүүд байгаагүй тул намайг дэмждэггүй байлаа.

Үүний улмаас сүмд явж, сайн мэдээний дагуу амьдрах нь надад хэцүү болсон. Би 19 хүрэхдээ сүмд явахаа больсон байлаа.

Арван жилийн дараа Эль Сальвадорт ариун сүм баригдах гэж байгааг би олж сонссон юм. Их Эзэний өргөө эх оронд минь баригдах гэж байгааг сонсоод би гайхсан. Дөрвөн жилийн дараа Эль Сальвадорын Сан Сальвадор ариун сүм баригдаж дуусан, ариун сүмийн нээлттэй хаалганы өдөр зарлагдав. Би нээлттэй хаалганы өдрөөр ариун сүмд орох боломж гарч байгааг дуулаад, Их Эзэн намайг Өөрийн өргөөнд орохыг хувиараа урьж байгаа мэт санагдсан.

Ариун сүмээр алхаж орсон тэр өдөр амьдралын минь хамгийн сайхан өдрүүдийн нэг байсан юм. Нээлттэй хаалганы өдрөөр би онцгойлон адислагдсан ариун сүм дотор юу болдог талаар илүү ихийг мэдэж авсан. Би бас хүмүүсийн Бурхантай байгуулдаг, ариун сүмийн нандин гэрээнүүдийн талаар мэдэж авсан.

Ариун сүмийн өрөө болгоноор явж үзэхдээ би Бурханы оршихуйг мэдэрч байв. Би амар амгаланг мэдэрсэн. Ариун сүмд зочилсон маань Сүмдээ эргэн ирж, сайн мэдээний дагуу дахин амьдрах хүслийг надад төрүүлсэн. Би Бурханы агуу ажилд оролцож чадна гэдгээ ухаарах үедээ өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ажлыг гүйцэтгэж, санваарыг ашиглахыг хүссэн билээ.

Тэр өдөр ариун сүмд өнгөрүүлсэн туршлага намайг өөрчилсөн. Би одоо тойргийн гишүүддээ ариун сүмд бэлтгэхэд нь тусалж мөн өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ажил хийх боломж олгохын тулд гэр бүлийн түүхээ хийхэд нь тусалдаг.

Сүмдээ эргэн ирэхэд хэзээ ч оройтохгүй. Сайн үйл хийхэд хэзээ ч оройтохгүй. Их Эзэн хязгааргүй хайраараа бидэнтэй үргэлж хамт байдаг. Ариун сүм биднийг Түүнтэй нэгтгэж мөн хэзээ нэг өдөр Түүнтэй хамт амьдрахаар буцаж очих боломжийг олгодог газар юм. ■

Рикардо Матаморос, Эль Сальвадор, Агуачапан

Хайрын бэлэг

Фэйт С.Вотсон

Би нөхрийгөө бяцхан охиноо адислах үед Тэнгэрлэг Эцэгийн хайрын бэлэг болсон санваарыг илүү гүн, өргөн хүрээнд ойлгодог болсон юм.

Би Сүмийн шинэ гишүүн, шинэ эхнэр, тэгээд шинэ ээж болсон байв. Мацгийн ням гараг байсан ба бяцхан охин минь нэрийн адислалаа авах гэж байв. Бид цөөн залуу гэр бүлтэй тойрогт амьдарч байсан болохоор би өмнө нь хүүхдийг адислахыг харж байгаагүй юм. Би юу болдгийг мэдэхгүй байлаа. Гэвч би үүнийг маш онцгой, чухал зүйл гэдгийг Сүнсээр мэдэрч байсан.

Нөхөр маань хүндэтгэлтэй хэдэн санваартны хажууд энхрий бяцхан охиноо өлгийтэй нь болгоомжтой тэвэрч байв. Сүнсний сайн сайхан намайг баяр хөөрөөр дүүргэж байлаа. Хацар даган нулимс урсаж, оюун бодолд минь олон бодол төрсөн. Би Тэнгэрлэг Эцэгийн хайрын үүднээс бидэнд өгсөн гайхамшигт бэлэг болох санваарыг илүү гүн, өргөн хүрээнд ойлгож эхэлж байгаагаа мэдсэн юм.

Номлогчдыг надад хичээл заах үед би тэднийг санваартаа хэчнээн хүндэтгэлтэй хандаж байгааг хардаг байсан. Тэд намайг мэргэн ухааны үгтэй холбоотой асуудлаа даван туулах адислал өгөх үед би тэдний үг болон залбирлаас үүнийг сонсож байв. Миний толгой дээр зөөлөн тавьсан тэдний чичирч байгаа гарыг мэдэрч, хэлж байгаа хайрын болон эдгээх үгс нь Их Эзэнээс ирж байгааг би мэдсэн.

Би удалгүй баптисм хүртсэн бөгөөд санваартнууд дахин миний толгой дээр гараа тавьсан. Би Их Эзэний Сүмийн гишүүнээр батлуулж, Ариун Сүнсний бэлэг хүртсэн юм. Би цэвэршиж, шинээр төрсөн. Би бүх биеэрээ санваарын хүчийг мэдэрч, амьдралдаа анх удаа баяр баясгаланг мэдэрч билээ.

Би баптисм хүртээд, удалгүй нөхөртэйгөө гэрлэсэн. Нөхрийн маань эцэг эх Сүмийн гишүүд бөгөөд тэдний гэр орон сайн мэдээнд төвлөрсөн байсан ч түүний гэрчлэлийн суурь сайн байгаагүйг би мэдэж байв. Гэвч би үүнд санаа зовсонгүй. Шинэхэн итгэл маань намайг өөдрөг болгосон байв. Би зүгээр л түүнийг хайрлаж, тэвчээртэй хандаж, залбирах болно.

Анхны үрээ тээж байсан саруудын туршид бусад ээжийн нэгэн адилаар хүүхэдтэйгээ дотносож, өөрийн дотор бүрэлдэж буй энэ шинэ амийг биширдэг байв. Охиноо төрөхөд түүнтэй тогтоосон холбоо минь хайрын, хүч чадлын, сайн сайхны холбоос болсон юм.

Гэвч би нөхөртөө санаа зовж байв. Түүнд миний охинтойгоо ийм дотно байсан шиг дотносох боломж байгаагүй. Мэдээж, тэр охиндоо хайртай хэдий ч би тэр хоёрыг тийм хүчтэй холбоо тогтоож чадах эсэхэд эргэлзэн, санаа зовж байлаа. Нөхрийгөө ихэнх цагийг гэр бүлээ тэтгэхээр ажиллаж өнгөрүүлж байх хооронд би охиноо асарч, усанд оруулж, тэврэн цаг өнгөрүүлж байгаадаа санаа зовдог байв.

Гэтэл одоо охин минь төрөөд, хэдхэн долоо хоногийн дараа бид ариун ёслолын танхимд сууж байлаа. Нүдний минь өмнө, зүрх сэтгэлд минь нэгэн гайхамшиг тохиох нь тэр. Нөхөр маань тойрогт зогсож байсан ах нар луу гэрэлтсэн, нулимстай харцаар даруухан инээмсэглэн харж байв. Хариуд нь эдгээр ахаас түүн рүү, тухайлбал тэднийг мөр мөрөн дээрээ гараа тавьж, цэвэр ариун нандин хайраар бялхуулсан бяцхан тойрог үүсгэн, нялх хүүхдийг тэврэхэд туслах үед түүн рүү хайр, дэмжлэг урсан ирж байв. Нөхрөө адислал өгч эхлэхэд би түүний хоолой чичирч байгааг сонссон ба Их Эзэний хүч чадлыг мэдэрч, санваартаа хүндэтгэлтэй хандаж байгааг нь мэдэрсэн.

Би түүний охиноо гэсэн агуу хайрыг мэдэрч, Тэнгэрлэг Эцэгийн охинд маань зориулсан адислалуудыг охиндоо өгөхийн тулд өөрийгөө бэлтгэхээр хичээснийг мэдэж байсан юм. Түүнийг одоо охинтойгоо ийм нягт холбоотойг мэдэрсэн болохоор миний сэтгэл

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АЛЕ + АЛЕ, МОРГАН ГАЙНИН

баяр хөөрөөр дүүрсэн. Энэ бол хэзээ ч сулрахгүй холбоо байв.

Энэ туршлагаас хойш олон жил улиран өнгөрчээ. Тэнгэрлэг Эцэгийн олон хүүхдэд олон арга замаар, олон газарт санваарын хүч чадал, сайн сайхан зүйлс хэрэгжиж байгааг би олон удаа харж, мэдэрч байсан. Би гайхалтай авралын ёслолууд өгөгдөж, зүрх сэтгэлүүдийг дүүргэж байгааг харж байсан. Би ариусгагдаж, эдгэрч, тайтгарч байгаагаа мөн надад зааж байгааг ажигласан. Би ачаануудыг өргөж байгааг харж мөн мэдэрсэн.

Би санваарын бүрэн дүүрэн сүр жавхланг хараахан бүрэн ойлгоогүй гэдгээ мэднэ, гэхдээ хүүхдийн адислалыг харах болгондоо ууган хүүхдийнх шигээ мэдрэмжийг мэдэрдэг. Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүчийг бидэнтэй хуваалцан бидэнд хайраа харуулдагт би гайхан биширдэг. Би Түүний тухай, Түүний хайрт Хүүгийн тухай мөн сэргээгдсэн гайхалтай сайн мэдээний тухай гэрчлэлдээ үгээр илэрхийлэхийн аргагүй талархаж байна. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Алма 5–7
6-Р САРЫН 1–7

Алмагийн асуултууд бидэнд хэрхэн сүнслэгээр өсөж хөгжихөд тусалдаг вэ?

БИ ХЭР БАЙГАА ВЭ?

Алма Зарахемлагийн хүмүүст сүнслэг өсөлт хөгжлөө дүгнэж цэгнэхэд нь туслах 36 асуултыг тавьжээ. Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард сүнслэг дүгнэлт хийх нь ач тустай байдаг хэмээн тайлбарласан. Тэрээр "Ийм [дүгнэлт хийх] үедээ . . . би Алмагийн тавдугаар бүлэгт гардаг өөрийгөө дүгнэж цэгнэх үгсийг уншиж, тунгаан бодох дуртай"[1] гэжээ.

Би юуг өөрчлөх хэрэгтэй вэ?

Та нар Алма 5:7–13-ыг уншиж байхдаа, бид хэрхэн өөрчлөгдөж мөн Христэд ойртон ирж болох талаар Алма юу гэж заасныг олж уншина уу. Өөрчилж чадах зүйлсээ тунгаан бодоод, үйлдэх төлөвлөгөө гарга.

Их Эзэн намайг хэрхэн адисалсан бэ?

Алма бас хүмүүсийг Их Эзэн өвөг дээдсийг нь хэрхэн чөлөөлснийг мөн тэдний хөрвөлтийг эргэн санахад уриалсан. Их Эзэн таныг хэрхэн адисалсныг санахын тулд өөрийн хөрвөгдсөн түүхийг бичих талаар бод. Та бас өвөг дээдсийнхээ юм уу Сүмийн анхны гишүүдийн тухай хөрвөгдсөн түүхүүдийг уншиж болно.

"Хожмын үеийн гэгээнтэн бүр өвөг дээдсийнхээ хөрвөлтийн түүхүүдийг мэддэг бол гайхалтай шүү дээ. . . . Бид Их Эзэний Сүмд нэгдсэн өвөг дээдсийнхээ итгэл, золиослолын түүхийг мэдэж авах юм бол бидний хүн нэг бүр агуу ихээр адислагдах болно."[2]

ЭШЛЭЛҮҮД
1. М.Рассэлл Баллард, "Эргэж очоод, хүлээн ав," *2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 51.
2. Виллиам Р.Вокэр, "Итгэлдээ үнэнч амьдрагтун," *2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган,* 117.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭРОЛИН ВИББЕРТ

Алма 8–12
6-Р САРЫН 8–14

Зөөлөн зүрх сэтгэлийг хөгжүүлэх нь сүнслэг мэдлэг олж авахад бидэнд хэрхэн тусалдаг вэ?

Алмаг Аммонайхад сайн мэдээг номлох үед ихэнх хүн түүнийг эсэргүүцсэн ч Амюлек сонсож, итгэсэн юм. Амюлек ба Аммонайха хотын бусад хүний ялгаатай тал нь гэвэл, Бурханы зүйлүүдэд зөөлөн эсвэл хатуурсан зүрх сэтгэлээр хандахын үр дагавруудыг харуулдагт оршино (Алма 12:10-ыг үзнэ үү). Та зөөлөн зүрх сэтгэлтэй байхыг сонгож чадна.



Амюлек ба Аммонайха хотын хүмүүс

Амюлек Алмаг Бурханы бошиглогч гэдэгт итгэдэг байв (Алма 8:20-ийг үзнэ үү). Тэнгэр элч Алмаг гэртээ аваач гэж түүнд хэлэхэд тэр дуулгавартай дагахыг сонгосон (Алма 10:8-ыг үзнэ үү). Тэрээр мөн сайн мэдээг номлох Бурханы дуудлагад хариулсан юм (Алма 8:29–30-ийг үзнэ үү). Гэвч хотын бусад хүн Алмаг эсэргүүцэж, итгэхээс татгалзжээ.

Зөөлөн зүрх сэтгэлийн адислалууд

Амюлек Бурханы үгийг хүлээн авсан тул сүнслэг мэдлэгээр адислагдсан юм. Тэр "Ариун Сүнсээр дүүргэгдэн" (Алма 8:30), Бурханы хүчний талаар гэрчлэлтэй болж (Алма 10:5-ыг үзнэ үү), тэр байтугай өөрийг нь мэхлэх гэж оролдсон хүмүүсийн бодлыг мэдсэн (Алма 10:17-г үзнэ үү). Та ч гэсэн Бурханы үгийг хүлээн авахыг сонгож, Түүний адислалуудыг авч чадна.





Хатуу зүрх сэтгэлийн үр дагавар

Аммонайха хотын хүмүүс Алмагийн заасан зүйлсэд зүрх сэтгэлээ хатууруулсан учраас үнэ цэнтэй адислалуудыг алдсан юм. Тэд Бурханы гайхамшгуудын талаар ямар ч мэдлэггүй байсан (Алма 9:5) ба Бурхан тэднийг устгаж мөн Бурханы хаант улсыг өвлөхгүй гэдгийг тэдэнд сэрэмжлүүлсэн (Алма 9:12-ыг үзнэ үү).

ЯРИЛЦЛАГА

- Амюлек ямар ямар зан чанартай байсан бэ? Та түүний сайн зан чанаруудыг хэрхэн хөгжүүлж чадах вэ?
- Хэрэв та тодорхой асуултад хариулт авахаар эрэлхийлж байвал Тэнгэрлэг Эцгээс ирсэн илчлэлтийг илүү сайн хүлээж авахын тулд юу хийж чадах вэ?
- Зөөлөн, дуулгавартай зүрх сэтгэлтэй байхыг сонгосноор Их Эзэн танд болон таны гэр бүлд ямар адислалуудыг өгч болох вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭН СИМОНСЭН

Алма 13–16
6-Р САРЫН 15–21

Авралын ёслолууд намайг хэрхэн Есүс Христ рүү чиглүүлдэг вэ?

“Сайн мэдээний ёслолуудгүйгээр сайн зан үйл үйлдэх нь хүн төрөлхтнийг гэтэлгэж ч, өргөмжилж ч чадахгүй.”[1]

БЭЛД

Их Эзэн Алма, Амюлек хоёрыг Өөрийн зарлигуудыг хүмүүст заалгуулахаар дуудаж мөн бэлтгэсэн байв (Алма 13:3-ыг үзнэ үү). Тэд “ариун ёслолоор томилогдсон” (Алма 13:8) байв. Бид нүглүүдийнхээ ангижралыг хаанаас хайхаа мэдэж болохын тулд энэ болон бусад ёслол өгөгдсөн юм (Алма 13:16-г үзнэ үү). Бүх ёслол биднийг Есүс Христ рүү чиглүүлдэг.

Та сайн мэдээний авралын ёслолуудыг хүлээн авахын тулд хэрхэн бэлтгэж чадах вэ?

НАМАНЧИЛ

Наманчлал нь бидний зүрх сэтгэлийг Аврагч руу эргүүлдэг. Авралын ёслолууд бидний оюун санааг Христэд болон Түүний ач ивээлд төвлөрүүлдэг ба тэгснээр бид Түүн дээр буцаж очиж чадна (Алма 13:16-г үзнэ үү).

ХҮЛЭЭН АВ

Бид “авралд хүргэх Христийн хүчийг” (Алма 15:6) мэдэрч болохын тулд Их Эзэн авралын ёслолуудыг өгсөн.

Та ямар ямар авралын ёслол хүлээн авсан бэ, мөн эдгээр нь таныг Аврагчид хэрхэн ойртуулсан бэ?

ЭШЛЭЛ

1. Boyd K. Packer, “The Only True Church,” *Ensign,* Nov. 1985, 82.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КАТЛИН ПЕТЕРСОН

Алма 17–22
6-Р САРЫН 22–28

Би итгэлээрээ хэрхэн шууд үйлддэг болох вэ?

Мормоны Номон дээрх Абишийн итгэлтэй, шуурхай үйлдэл нь бусдыг Христэд авчрахад итгэл хэрхэн тусалдгийг харуулдаг. Тэр "Их Эзэнд хэрхэн бүрэн дүүрэн хөрвүүлэгдсэнийг" (Алма 19:16) бодож үз.

ЯРИЛЦЛАГА
Та өөрийгөө, магадгүй бусад хүнийг Бурханы хүслийн дагуу шууд, бүрэн дүүрэн үйлдэх хүчтэй болтол Их Эзэнд итгэх итгэлээ хэрхэн хүчирхэгжүүлж болох вэ?

Тэр үүнийг мэдэж байв

Абишийн итгэл хүчтэй байсан тул тэр Лемонайн гэрийнхний газарт унасныг хараад, "энэ бол Бурханы хүч гэдгийг мэдэв" (Алма 19:17). Та Бурханы хүчийг хэрхэн Абиш шиг мэддэг болж, итгэлээ хөгжүүлж чадах вэ?



Тэр гүйж гарсан

Абиш Бурханы хүчийг таниад, "байшингаас байшин руу гүйн" хүмүүсийг ирж, гайхамшгийг үз гэв (Алма 19:17). Итгэл нь түүнд хурдан шуурхай үйлдэх хүчийг өгсөн байв. Танд Бурханы хүслийн дагуу итгэлтэйгээр үйлдэхээр гүйж гараагүй ч сайн мэдээний хувьд алхаад ч болсон явж байгаа зүйл байна уу?

Тэр бусдыг гараас нь барьсан

Абиш хатныг босгож зогсоохын тулд "хатныг гараас нь итгэлтэйгээр барьсан" (Алма 19:29). Тэр Бурханд итгэх итгэлийнхээ улмаас боломжгүй мэт санагдсан зүйлийг хийсэн. Та Бурханд итгэх итгэлээ хэрхэн хүчирхэгжүүлж мөн амьдралдаа боломжгүй зүйлсийг гүйцэлдүүлж чадах вэ?

ЗУРГИЙГ АНДРЬЮ БОСЛИ; ДЭВСГЭР ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС

Залуучуудад зориулав

Энэ хэсэгт

44 **Мөнхийн ханиа олохдоо өөрийгөө шахахгүй байх нь**
Доминика Стойка

48 **Ганц бие байхдаа аз жаргалтай байж сурах нь**
Ландон Хоос

Зөвхөн цахим хувилбараар

Ирээдүйн ханиасаа асуух 10 асуулт

Хоёр дахь сэтгэгдэл болон Сүнсний удирдамжид найдах нь
Мари Нетцлер

Ганц бие байх нь Бурханы надад зориулсан *бүрэн* төлөвлөгөөнд найдахыг сануулдаг.
Кристина Коттералл

Алслагдмал газраас харилцаагаа үргэлжлүүлэхэд тань туслах 7 зөвлөмж

Түүхээ хуваалц

Танд хуваалцах туршлага байна уу? Эсвэл та аль нэгэн сэдвээр бичсэн нийтлэл уншмаар байна уу? Хэрэв тийм бол бид таниас сонсохыг хүсэж байна! Та өөрийн нийтлэл болон санал, сэтгэгдлийг **liahona.ChurchofJesusChrist.org** руу илгээнэ үү.

Ханиа хайх ба Аврагчийн ач ивээл

Их Эзэн "номхон дөлгөөн тэдэнд [Түүний] ач ивээл хангалттай" (Ифер 12:26) хэмээн амласан. Энэ үгс ганц бие залуучуудад, ялангуяа тэднийг мөнхийн ханиа хайж байгаа үед итгэл, найдвар, тайтгарал өгөх болно. Христийн итгэмтгий шавь нар нээлттэй зүрх сэтгэлээр хайрыг эрж хайх нь олонтоо бөгөөд заримдаа биелэхгүй итгэл найдвараасаа болж урам хугарч эсвэл болзож байгаа хүнийхээ муу зуршлаас болж гонсойх нь бий. Ялангуяа таныг төлөвлөснөөсөө хойш олон жил гэрлэхгүй, ганц бие явах үед энэ хайгуул айдас, уур хилэн, хорсол, сэтгэлийн дарамт үүсгэж болно.

Гэхдээ таны төсөөлж байгаагаар, эдгээр сэтгэл хөдлөл нь гэрлэж, зөв шударга, аз жаргалтай гэр бүлүүдийг бий болгох тухай Бурханы зарлигуудыг дагаж мөрдөхөд Түүний биднээс байнга мэдрэхийг хүсдэг зүйл биш юм. Үнэндээ **Бурхан биднийг энэ эрэл хайгуулынхаа үед ч баяр баяслыг мэдрээсэй** хэмээн хүсдэг.

Энэ үүднээс энэ хэсгийн нийтлэлүүд **мөнхийн ханиа олохдоо сэтгэлийн дарамтгүй байхад тань туслах зорилготой.** Таны гэрлэсэн эсэхээс үл хамааран та **амьдралдаа хэрхэн өсөж хөгжих** тухай түүхүүдийг болон эцэст нь таныг хайраар дүүрэн, халамжит, бат суурьтай гэрлэлтэд **бэлтгэх зөвлөгөөг** хүлээн авна.

Зүрх сэтгэлээ өгөхөд тань буцаагаад бүх зүрх сэтгэлээ танд өгөх хүнийг хайж олох явцдаа эдгээр нийтлэлийг унших цаг зав гаргана уу. Тэдгээрийн нэг нь зүрх сэтгэлийг тань гэрэлтүүлж, **Аврагчийн ач ивээл танд үнэхээр хангалттай** гэдэгт итгэхэд тусална гэдгийг би амлаж байна.

Хүндэтгэсэн,
Ландон Хоос

Сүмтэй холбоотой эргэлзээг даван туулах хамгийн сайн арга юу вэ? Хариултаа **liahona.ChurchofJesusChrist.org** вэбсайтаар 2020 оны 6-р сарын 30-ны дотор бидэнд илгээнэ үү.

GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Мөнхийн ханиа олохдоо өөрийгөө ШАХАХГҮЙ байх нь

Доминика Стойка

Сүм Польшид маш жижигхэн. Үнэндээ Сүм Зүүн Европт хаа сайгүй л жижиг байдаг. Манай тойрог, гадсанд байтугай бүхэл улс даяар бидний насны Сүмийн гишүүд тийм их байдаггүй. Аз болоход, Европын олон оронд жил бүр ганц бие залуучуудад зориулсан чуулганууд зохион байгуулагддаг.

Эдгээр чуулган "төгс тохирох" хүнээ олоход тань туслах зорилгоор бус, харин залуучуудад адил итгэл үнэмшилтэй шинэ найз нөхөдтэй болж, сүнслэг туршлагаа бусдад ярих замаар тэдний итгэлийг хүчирхэгжүүлэх зорилгоор зохион байгуулагддаг.

Үерхэж нөхөрлөхөд төвлөрөх

Би 2010 онд Польшт болсон чуулганы үеэр Радутай танилцаж байсан. Тэр Румын улсын иргэн байв. Бид товч ярилцаад өнгөрсөн ч тэр удалгүй номлолдоо гарсан ба бид гурван жилийн дараа өөр нэг Ганц бие залуучуудын чуулган болтол таараалдаагүй. Тэнд үнэндээ бидэнд бие биетэйгээ танилцах багахан цаг гарсан ч би сарын дараа номлолдоо гарах гэж байв. Раду надад сайн сайхан бүхнийг хүсээд, "холбоотой байцгаая" гэлээ. Би түүнийг холбоо барина гэж бодоогүй байсан ч тэр холбоо барьсан юм. Намайг номлолд байх хугацааны туршид тэр захиа бичсээр байсан. Түүний захидалд романтик зүйл байдаггүй байсан ч тэр миний сайн найзуудын нэг болсон байсан. Түүний надад болон номлогчийн ажилд хүндэтгэлтэй ханддаг байсан нь надад таалагддаг байв.

Би гэртээ харьж, Раду бид хоёр бие биенээ зохих ёсоор таньж мэдэх боломжтой болсондоо хоёулаа баяртай байсан. Бид олон жилийн дараа л энэ бүхнийг боломжтой болгосон юм. Бид хамтдаа цагийг өнгөрөөхөөр аль алиндаа боломжийн уулзах газар (тухайн үед Бельги байсан) сонгов . Бид ярилцсаар, ярилцсаар л, олон зүйл ярилцдаг байв.

Амьдрал нь гэрлэх гэхээсээ илүү бид өөрийнхөө хамгийн сайн хувилбар болж, Бурханд төлөвлөгөөнийхөө дагуу бидний амьдралд ажиллах боломжийг олгох явдал юм.

Бид харилцаандаа ямар ч дарамт шахалт үүсгээгүй юм. Бид нөхөрлөж, бие биенээ зүгээр л таньж мэдэхэд анхаарлаа хандуулсан. Бид үргэлж хамтдаа маш хөгжилтэй байдаг байсан. Гэхдээ бас хамгийн чухал зүйлсийн талаар маш чухал, гүн гүнзгий яриа өрнүүлдэг байлаа. Хэсэг хугацааны дараа бидний нөхөрлөл улам гүнзгийрсэн. Бид бараг өдөр бүр Skype-аар ярьдаг байсан бөгөөд яваандаа бид орой хамт залбирч эхэлсэн юм. Бид сүүлдээ хэдэн сар болоод л бие биенийхээ улсаар аялж эхлэв.

"Энэ талаар залбирцгаая"

Хэсэг хугацааны дараа бидний үерхэл илүү гүнзгийрч байгаад миний санаа зовж эхлэж билээ. Тэр румын хүн. Харилцаа маань гэрлэлтэд хүргэж, бидний хэн нэгийг өөр улс руу нүүхэд хүргэх байсан тул би холын харилцааг хүсэхгүй байв. Би үүнд бэлэн гэж бодохгүй байсан.

Намайг нэг өдөр үүнд бүр их санаа зовж байх үед Раду надад нэгэн энгийн боловч хүчирхэг зарчмыг сануулсан юм. Тэр "харилцааныхаа талаар залбираад, ямар мэдрэмжтэй байх нь вэ үзье" гэлээ.

Би урьд нь яагаад харилцааныхаа талаар залбирах тухай бодож үзээгүйгээ ойлгоогүй юм. Гэвч энэ нь миний тэр үед хүлээн авсан хамгийн сайн зөвлөгөө байсан. Тиймээс би удирдамж хүсэн залбирсан.

Тэр үед надад тодорхой хариулт ирээгүй боловч Радутай улам сайн танилцъя гэж шийдэв. Хэрэв бид харилцаагаа үргэлжлүүлэх ёсгүй бол Тэнгэрлэг Эцэг надад сэрэмжлүүлэг өгнө гэдэгт би итгэлтэй байсан. Гэвч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр миний асуултын хариу *ирсэн*. Би Радугийн талаар гэрийнхэн болон найзуудтайгаа ярилцсан ба ярилцах тоолондоо би зөв зүг рүү явж байгаадаа итгэлтэй болж байв.

Удалгүй нэгэн хөгжилтэй бодол орж ирсэн юм. Нэг орой Радутай Skype дээр гайхалтай яриа өрнүүлсний дараа би "Тэр үнэхээр миний хамгийн сайн найз шүү. Би үүрд түүний найз болмоор байна!" гэж өөртөө хэлэв. Ингэж л надад орж ирсэн юм. Гэнэт доторх дуу хоолой минь миний бодолд хариулав. "Тэгвэл чи түүнтэй гэрлэх хэрэгтэй!" Тэнгэрлэг Эцэг Радутай үүсгэсэн харилцаанд минь тааламжтай байгааг би мэдсэн юм. Тэр миний хамгийн сайн найз бөгөөд бид хамтдаа аз жаргалтай байж чадна гэдгийг би ойлгосон.

Ханиа олохдоо өөрийгөө шахахгүй байх нь

Тиймээс би Румын руу нүүж, Радутай гэрлэсэн. Би Румынд амьдарна гэж хэзээ ч бодож байгаагүй. Бид одоо гэрлээд, дөрвөн жил болж байгаа бөгөөд Амилиа гэдэг хөөрхөн охинтой болсон.

Би таны юу гэж бодож байгааг гадарлаж байна. Би бол Ганц бие залуучуудын чуулган дээр "заяаны хань"-тайгаа учирсан ганц бие залуучуудын нэг бөгөөд бүх зүйл сайхан болж өнгөрсөн. Гэхдээ тийм биш ээ. Миний энэ түүхийг танд хэлэх шалтгаан бол мөнхийн ханиа олох гэж өөрийгөө шахахаа больж, оронд нь Бурханд таныг удирдан чиглүүлэх боломжийг олгох явдал юм.

Би нөхөртэй болох гэж эдгээр ганц бие залуучуудын чуулганд явсан гэж үү? Үгүй.

Би тэнд танилцах залуучуудын нэгийг нөхрөө болно гэж бодсон уу? Чухамдаа бол тийм биш.

Харин би гэрлэхийг хүсэж байгаа хүнээ олохын тулд өөртөө дарамт шахалт үзүүлэлгүйгээр, бусадтай холбоо тогтоож, нөхөрлөхийн тулд эдгээр чуулганд явсан. Эхэндээ Раду бид хоёрын харилцаа тийм л байсан.

Мөнхийн ханиа болж өгвөл аль болох хурдан ол гэсэн дарамт шахалт нь заримдаа үнэхээр бодит дарамт болдог. Гэвч мөнхийн харилцаанд цаг хугацааны хязгаар үгүй бөгөөд үүнд стрессдэх шаардлагагүй. Амьдрал нь гэрлэх гэхээсээ илүү бид өөрийнхөө хамгийн сайн хувилбар



болж, Бурханд төлөвлөгөөнийхөө дагуу бидний амьдралд ажиллах боломжийг олгох явдал юм. Тийм ээ, бид бүгдээрээ гарч, үйл ажиллагаанд оролцон, хүмүүстэй танилцаж, шинэ найз нөхөдтэй болж, тав тухтай бүсээсээ гарах ёстой. Гэвч бид “хэн нэгнийг хайж олохын тулд байнга сэргэг байхгүй бол амьдралын бүх төлөвлөгөөгөө бүтэлгүйтүүлнэ” гэхийн оронд “Би цагийг хөгжилтэй өнгөрөөж, гайхалтай найз нөхөдтэй болно” гэсэн бодолтойгоор хийх хэрэгтэй.

Раду сүй тавьсныхаа дараа, таалагддаг охид нь түүнийг бага зэрэг стрессдүүлдэг байсан ч намайг тэгж байгаагүй гэж надад хэлсэн юм. Тэр бидний нөхөрлөлийн ачаар үргэлж тайван байж, өөрөөрөө байж чаддаг байсан гэсэн юм.

Тиймээс өөрийгөө хүрээлэх сайн хүмүүсийг олж, одоо байгаа байдалдаа сэтгэл хангалуун бай. Үнэнийг хэлэхэд, стрессдэхээ больж, зүгээр найзалж, нөхөрлөн, өөрийн хэн гэдэгт мөн байгаа байдалдаа сэтгэл хангалуун байж сурвал амьдрал илүү их таатай болно.

Бидний ирээдүйд зориулсан Бурханы төлөвлөгөөнд итгэх

Раду бид хоёр төгс биш. Бид үнэхээр “төгс” хүн хайлгүй, өөрсдийнхөөрөө байсан. Миний анзаарснаар та өөрийн хэн болох мөн өөрийн амьдарч буй байдлаар бусдын анхаарлыг ихээр татаж байдаг. Та Есүс Христийг дагахыг хичээснээр Түүнийг дагахын төлөө чадах бүхнээ хийж буй хүмүүсийн анхаарлыг ч бас татах болно.

Бид өөрсдийгөө сайжруулж, Бурханы харж хандаж байгаад бүрэн итгэж найдах үедээ Түүний мутрыг амьдралдаа урьж, мөн Түүний мутрыг таньдаг болсноор ирээдүйд айх шаардлагагүй юм гэдгийг би ойлгосон. Их Эзэний Нифайд юу гэж заасныг санагтун. “Мөн түүнчлэн аглаг буйдад би та нарын гэрэл байх болно; мөн би та нарын өмнө замыг бэлтгэнэ, хэрэв та нар миний зарлигуудыг дагавал; иймийн тул, та нар миний зарлигийг дагахын хэрээр, та нар амлагдсан нутгийн зүг удирдагдах болно; мөн та нар надаар удирдагдаж байгаагаа мэдэх болно” (1 Нифай 17:13).

Бид өөрсдийн цаг хугацаанд тодорхой хүлээлт, үе шатыг биелүүлээгүйн төлөө өөрийгөө байнга дарамтлан шахах ёсгүй. Үнэндээ Тэнгэрлэг Эцэгийн цаг хугацаа биднийхээс өөр бөгөөд мөнхийнх юм. Бидний эрж хайж буй адислал бүрийг гүйцэлдүүлэх төлөвлөгөө Түүнд бий. Бид Түүний төлөвлөгөөнд итгэж, мөн ямар ч нөхцөл байдалд байсан сэтгэл хангалуун байвал *бид* жинхэнэ аз жаргалыг олох болно. Түүний төлөвлөгөө үргэлж бидний өөрсдөдөө зориулсан төлөвлөгөөнөөс илүү дээр байдаг. ■

Доминика Стойка *бизнес эрхлэгч ээж юм. Тэр хоол хийж, бүжиглэж, хүмүүсийг инээлгэх дуртай. Тэрээр амьдралын хэв маягийн блог хөтөлж, зураг засварлах, дугуй унах, ууланд цагаа өнгөрөөх дуртай.*

Ландон Хоос

ГАНЦ БИЕ БАЙХДАА АЗ ЖАРГАЛТАЙ БАЙЖ СУРАХ НЬ

Би буруу аргаар болзож байснаа ойлгосон.

"Яагаад бусад хүн болзож, хөгжилтэй байдаг юм бол?"

"Би яагаад гэрлээгүй юм бэ?"

"Би ячихсан юм бол оо?"

Ихэнх ганц бие залуу эдгээр асуултыг дор хаяж нэг удаа өөрсдөөө тавьж байсан байх! Мөнхийн ханиа хайх нь хамгийн үнэнч хожмын үеийн гэгээнтнүүдийн ч итгэл, найдварыг шалгаж болно. Тийм ээ, миний хувьд ч гэсэн болзох хэцүү байсан.

Миний хувьд гэрлэлт ямагт гайхалтай адал явдал мэт санагддаг байсан бөгөөд багаасаа гэрлэхийг тэсэн ядан хүлээдэг байв. Гэвч коллежид сурч байхдаа болзож үзээд, бүтэлгүй юм шиг санагдахаар би сэтгэлээр унадаг байсан. Хэдийгээр би олон удаа болзож, хэд хэдэн ноцтой харилцаа үүсгэж, амжилттай яваа, сонирхол татахуйц эмэгтэйчүүдтэй танилцаж байсан ч гэрлээгүй юм. Би хувьдаа энэ бүх бүтэлгүй харилцааг өөрийнхөө доожоогүй, сэтгэл татам биш байгаагийнх гэж бодох болов.

Мэргэжлээрээ ажиллаж эхлээд, хэд хэдэн удаа болзоод бүтэлгүйтсэний дараа ганц бие байгаадаа улам гутарч байлаа. Миний юу болохгүй, гэрлэж байгаа хүмүүсийн юу нь болоод байгааг асуух л надад амархан санагдаж байв. Миний патриархын болон нэлээн хэдэн санваарын адислал дээр намайг мөнх бус амьдралдаа зөв шударга эмэгтэйтэй лацдан холбогдох болно хэмээн онцгойлон, тодорхой хэлсэн байсан. Тийм байхад яагаад энэ нь тохиолдохгүй байна вэ?

Би "Бурханы надад зориулсан төлөвлөгөөг нураах ямар нэгэн зүйл хийчихсэн юм болов уу?" ч гэж бодож үзэв.

Эцэст нь залбирч, судраас судалж мөн ариун сүмд очих зэргээр олон жил Бурханы өмнө өөртэйгөө "тэмцэлдсэний" эцэст би өөрийн нөхцөл байдлын талаар өөрийн найз, зөвлөх Брэдээр (нэрийг өөрчлөв) дамжуулан илчлэлт хүлээн авсан юм. Биднийг зөвлөлдөж байх үеэр тэр "Чиний аз жаргал өөр хэн нэгнээс биш, зөвхөн чамаас шалтгаална. Чи ганц бие байхдаа аз жаргалтай байвал ямар ч нөхцөл байдалд аз жаргалтай байж чаддаг болно" гэж хэлсэн. Үүний адил, ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон "Бидний баяр баясгалан амьдралын маань нөхцөл байдлаас биш, харин амьдралдаа юунд ач холбогдол өгч байгаатай холбоотой" гэж заасан байдаг ("Баяр баясгалантай байж, сүнслэг байдлын хувьд тэсэж үлдэх нь" *2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 71).

Сүнс эдгээр үгийг миний зүрх сэтгэлд хүчтэй хүргэж нөлөөлснөөр миний үзэл бодол бүхэлдээ өөрчлөгдөж билээ. Би ганцаараа байхгүйн тулд, гэрлэх хэрэгцээ буюу өөрийн нөхцөл байдал дахь хэрэгцээгээ хангахын тулд болздог байснаа ойлгосон.

Энэ бол мөнхийн хайрт хань руу минь хөтөлнө гэж бодож буй арга зам биш байсан нь мэдээж! Их Эзэн Брэдээр дамжуулан охид, хөвгүүддээ зориулсан төлөвлөгөө нь тэднийг хэрэгцээ шаардлага, соёлын дарамт шахалт эсвэл айдас дээр үндэслэн гэрлэхэд зориулагдаагүй гэдгийг надад эвтэйхэн гэгч заасан. Гэрлэлт Христийнхтэй адил хайр дээр үндэслэдэг. Дараа нь миний гэрлээгүй байдал надад ашиг сонирхол дээр биш, харин цэвэр хайранд суурилан амьдрахыг мөн гэрлэлтийг эрж хайх ёстойг зааж чадна гэдгийг Тэр надад ойлгуулсан. Гэрлэлтийг зөв учир шалтгаанаар эрэлхийл.

Би энэ туршлагаараа дамжуулан болзоондоо гутрах болгондоо санаж байх гурван үнэнийг олж мэдсэн билээ. Үүнд:

1. **Таны үнэ цэн гэрлэсэн эсэхээс тань шалтгаалдаггүй.** Исаиа "[Бурханы] бодол санаа [бидний] бодол санаа биш" (Исаиа 55:8) хэмээн заасан. Би өөрийнхөө ганц бие байгааг үнэ цэн багатай байгаагийн үр дүн гэж боддог байсан. Гэвч ганц бие байдал маань намайг төлөвлөсөн цаг хугацаандаа гэрлэснээс илүү сайн гэрлэлтэд бэлтгэж байгаа гэдгийг ойлгоход Бурхан надад тусалсан. Гэрлэлт миний үнэ цэнтэй ямар ч хамаагүй байв.
2. **Бэлтгэлтэй байдал нь санаа зовнил, айдсыг арилгадаг.** Их Эзэн бидэнд "хэрэв [бид] бэлтгэлтэй бол эмээх нь үгүй" (Сургаал ба Гэрээ 38:30) хэмээн хэлсэн. Бурханы хүслийг эрэлхийлж мөн дагах нь гэрлэлттэй холбоотой өмнөх айдас, бухимдлаасаа салахад надад тусалсан. Энэ нь ирээдүйд болох аливаа зүйлд өөрийгөө бэлдэхдээ анхаарлаа төвлөрүүлэхэд тусалсан.
3. **Ганц бие байхад баяр баясгалантай зүйлс байдаг.** Ганц бие байх нь сэтгэл хөдлөм аяллаар явах боломжтой байх, ажил дээрээ өсөж хөгжих, Сүмд үйлчлэх арга замуудаар намайг адисалсан. Би гэрлэж, үр хүүхэдтэй болохыг хүссэн хэвээр боловч Бурхан миний хажууд хань байгаа эсэхээс үл хамааран Түүний хаант улсад хэчнээн их хийх зүйл байгааг ойлгоход надад тусалсан юм.

Би одоо хүртэл гэрлээгүй байгаа. Одоо миний болзоо, гэрлэлтийн талаарх бодол өөрчлөгдсөн ч гэсэн миний эхнэр гайхамшигт арга замаар гарч ирээгүй л байгаа бөгөөд би заримдаа болзооноос болж бухимдах зүйл гарна гэдгийг мэддэг болсон. Гэхдээ гэрлэлттэй холбоотой олон айдас, санаа зовнил маань арилсан. Би одоо Их Эзэн бид хоёрыг энэ болон мөнх амьдралын аль алинд нь буюу Түүний надад өгсөн мөнхийн адислалууд хийгээд амлалтуудыг гүйцэлдүүлэхээр хамтдаа ажиллах үед ганц бие байх нь ерөнхийдөө дажгүй зүйл гэдгийг мэддэг болсон. ■



***Ландон Хоос** бол сайн зохиол, гайхалтай номд болон дэлхийг судлах дуртай, дэлхийг тойрон аялагч, хот төлөвлөгч хүн юм. Та түүнийг орон нутгийн номын сангаас болон бэйсболын багтаа тоглож байхад нь эсвэл хэний ч харна гэж бодоогүй зэлүүд зам дээрх үзэсгэлэнтэй газруудаас хайж олох боломжтой.*

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ХОСЭ ПОРТИЛЛО

Фофоа В., (зүүн талд) 18 настай
Этуаль В., (баруун талд) 16 настай,
Самоагийн Савалийнх.

Манай гэр бүлд хүн бүр тусалдаг.

Фофоа: Манай гэр бүлийнхэн хамтдаа ажиллахад итгэдэг. Манай ах Этуаль бид хоёр хоол хийхээр мод цуглуулдаг. Бид бас зарах хоол хийхэд нь тусалдаг юм. Нэг удаа манай гэр бүл усны өндөр төлбөрөө төлөх хангалттай мөнгө олоогүйг би санаж байна. Тиймээс бид бүгд чадах чинээгээрээ тусалсан. Эгч маань шорлог хийж зарсан. Харин Этуаль бид хоёр наргил модны самар, өөр бусад хоол хүнс цуглуулж, дараа нь мөнгө олохын тулд хоолоо зарж тусалсан. Бид гэр бүлээрээ шаргуу ажиллаж, Бурханд найдсаны дараа усаа эргүүлэн нээлгэж чадсан юм.

Этуаль: Бурхан амьдралын минь бүх зүйлд надад тусалдаг. Тэр надад өдөр бүр хүч өгч, намайг адисалдаг. Би Самоад амьдрах дуртай. Энд маш амар амгалан байдаг. Миний хамгийн том мөрөөдөл бол бүрэн цагийн номлолд үйлчлэх явдал юм. Би Бурханд хоёр жилээ зориулахыг хүсэж байна.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЛЭСЛИ НИЛССОН

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ЭНЭ ХЭСЭГТ



52

52 **Дэлхий даяар гэрчлэл олж авах нь**
Вилмер Амая Мунозь

54 **Залуу эмэгтэйчүүдийн байгууллагын 150 жилийн ой**
Бонни Х.Кордон эгч

58 **Залуу эмэгтэйчүүд: 150 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлэх нь**
Аманда Данн

62 **Асуулт, хариулт: Сэтгэлээр унах ба арьс өнгөөр ялгаварлан гадуурхах**

64 **Сүүлчийн үг: Санваарын хүчээр хамтдаа үйлчлэх нь**
Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард

Дэлхий даяар **гэрчлэл олж авах нь**

Вилмер Амая Муноз

Би Испанид төрж, тэндээ найман жил амьдарсан. Бид сүмд их явдаггүй байсан болохоор найм хүрэхдээ баптисм хүртээгүй байсан ч баптисм хүртэхийг маш их хүсдэг байв. Би нэг өдөр эцэг эхээсээ бид яагаад дахин сүмдээ явахгүй байгааг болон би яагаад баптисм хүртээгүйг асуув.

Тэдэнд баптисм хүртэх хүсэлтэй байгаагаа тайлбарлахад энэ нь тэдний зүрх сэтгэлд хүрч, бид дахин сүмдээ явж эхэлсэн юм. Сайхан санагдаж байлаа. Ээж надад сайн үлгэр жишээ үзүүлж, урам зориг өгдөг байсан. Тэр хүчтэй гэрчлэлтэй байсан төдийгүй судраа байнга уншдаг байв.

Дараа нь бид аавын төрсөн нутаг Венесуэль руу нүүхээр болов. Бид тэнд хоёр жил амьдарч, эдийн засгийн хямралаас болж олон сорилт бэрхшээлтэй тулгарсан. Гэвч сайн сайхан зүйлс ч бас их тохиолдож байв. Надад хоол нь таалагддаг байсан ба тэнд надтай уулзахыг ихэд хүсдэг гэр бүл байсан. Тэд маш даруу хүмүүс байсан ба бид Сүмд хамт явж, Сүнсийг мэдэрдэг байв.

Бид хэдийгээр сүмдээ явж, Сүнсийг мэдэрч байсан ч гэр бүлд маань ямар нэг юм дутагдаад байгааг би мэдэж байсан юм. Бид үнэхээр мөнхийн гэр бүл болж лацдан холбогдох хэрэгтэй байгааг би мэдэрч байв. Нэгэн ням гаргийн өглөө бишоп цуглаанд оролцож байсан хүн болгонд он дуусахаас өмнө Мормоны Номыг уншихад уриалсан юм. Энэ нь надад болон эцэг эхэд маань Их Эзэний сайн мэдээний дагуу илүү бүрэн дүүрэн амьдрахад тусална

ЗУРГИЙГ ПАУЛИН ГРЭЙСОН

Энэ нь миний Сүмд нэгдсэн, манай гэр бүл сайн мэдээнд идэвхтэй болсон тухай түүх юм.

гэдгийг би мэдэж байлаа. Биднийг Мормоны Номоос бага багаар унших үед Аврагч бидэнд илүү их мэдлэг, адислал өгч, бид ч судраас байнга уншсаар байв.

Удалгүй би баптисм хүртсэн. Би ч, эцэг эх маань ч амьдралдаа үнэхээр Сүнсийг мэдэрч байв. Гэрчлэл маань улам бүр өсөж эхэлсэн. Бид АНУ-ын Флорида руу нүүж, Испаниас явсан үеийнх шиг олон өөрчлөлт, золиос гаргах шаардлагатай болсон юм. Гэвч гэрчлэл маань улам бүр хүчтэй болж байв. Бид долоо хоног бүр сүмдээ явж, судраас уншсаар байв.

Бид судар унших, залбирах, зөвийг сонгох тал дээр ихээхэн хичээж чармайсны эцэст бид мөнхийн гэр бүл болж лацдан холбогдох хүсэлтэй болсон байв. Бид бишоптойгоо ярилцаж, хэсэг хугацааг зарцуулсан ч эцэст нь тэр өдөр ирлээ. Бид ариун сүмд орохдоо маш их баярлан хөөрч байсан.

Би эцэг эхийгээ өөрсдийнхөө төлөө ариун сүмийн ажил хийхийг хүлээнгээ нас барагсдын өмнөөс баптисм хүртсэн. Надад дахин баптисм хүртэж байгаа юм шиг санагдсан. Би хөшигний цаана байгаа хүмүүст тусалж байгаадаа үнэхээр баяртай байв. Одоо бид гэр бүлээрээ долоо хоног бүр ариун сүмд явдаг. Би тэнд очин туслахдаа баяртай байдаг болохоор байнга баптисм хүртдэг. Би ариун сүмд эцэг эхтэйгээ үүрд мөнхөд лацдан холбуулж, тэдэнтэйгээ мөнхөд хамт амьдрах боломжтой болсондоо маш их баяртай байна. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

Тэнгэрлэг Эцэгт Аврагчийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэхэд зориулж танаар хийлгэх агуу ажил бий.

Залуу эмэгтэйчүүдийн байгууллагын

150 ЖИЛИЙН ОЙ

Бонни Х.Кордон эгч
Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийнхээ төлөө хийсэн гайхалтай бүхнийг эргэцүүлэн бодох үед Түүний охидоо гэсэн хязгааргүй хайранд зүрх сэтгэл минь гайхах, бахдах зэрэгцдэг билээ. Тэр ТА НАРТ хайртай!

Тэр та нарыг хайрладаг учраас мөн та нарыг ямар болоосой гэж хүсдэг тийм хүн болоход туслахын тулд Сүмийн удирдагчдад Залуу эмэгтэйчүүдийн байгууллагыг байгуулах сүнслэг өдөөлтийг 150 жилийн өмнө өгсөн байна. Бошиглогч Бригам Янг (1801–1877) биднийг сайн мэдээний дагуу амьдарснаар гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд урамшуулсан. "Израилын залуу эмэгтэйчүүд үнэний талаар амьд гэрчлэлтэй болох хэрэгтэй. . . . Бид охидоо сайн мэдээний мэдлэгийг өөрсдөө олж аваасай гэж хүсдэг."[1] Тэр бас "Гэрчлэлийг сөхрөн сууж залбирахаас хөл дээрээ зогсож хуваалцсанаар илүү сайн олж авдаг"[2] гэж хэлсэн.

Залуу эмэгтэйчүүдийн байгууллага энэ олон жилийн хугацаанд цаг хугацааны эрэлт хэрэгцээнд дасан зохицож ирсэн. Хөтөлбөр хувьсан өөрчлөгдөж байсан ч амьд гэрчлэл олж авах, гэрээний зам дээр итгэлтэй урагшлахад нь туслахын тулд залуу эмэгтэйчүүдэд зориулагдсан зорилго өөрчлөгдөж байгаагүй. Өөрийн хэн болохыг мэдэж, итгэлээрээ үйлддэг болсноор та Тэнгэрлэг Эцэгийн өөрт тань зориулсан тэдгээр адислалыг хүлээн авах болно.

Залуу эмэгтэйчүүдийн анги он жилүүдийн явцад

Залуу эмэгтэйчүүд анх эхэлж байхдаа "сайн сайхан, гоо сайхан бүхнийг сайжруулах" зорилгоор "Арвилан хэмнэх холбоо" гэсэн нэртэй байжээ. 1900-аад оны эхээр энэ нь Залуу хатагтай нарын өсөлт хөгжилтийн холбоо болж, удалгүй 12-оос 24 насны залуу эмэгтэйчүүдийг ангиудад хамруулдаг болсон байна. Ангиудын нэр олон жилийн явцад өөрчлөгдөж, Аяллын галын охид, Бийхайв, Асран хамгаалагчид, Усан үзэм хураагчид зэрэг нэртэй байжээ. Сүм өсөж томрон, залуу эмэгтэйчүүд бусад улс оронд болон өөр өөр хэл дээр цугларч эхлэхэд тэд Миа Мэйд зэрэг нэрсээ, жишээ нь герман хэл дээр "Rosenmädchen" (Сарнай охид) болгон өөрчилж, дасан зохицохын тулд чадах бүхнээ хийж байв.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЛЭСЛИ НИЛССОН

Өнөөдөр бараг бүх улс оронд Залуу эмэгтэйчүүдийн ангиуд салбар, тойрог болгоны хэрэгцээ шаардлагын дагуу зохион байгуулагдаж, бүгдээрээ нэгдмэл нэр болох Залуу эмэгтэйчүүд гэсэн нэрээр нэрлэгддэг.

Түүнчлэн Залуу эмэгтэйчүүдийн хөтөлбөрт тавигдах шаардлагууд ч олон жилийн явцад өөрчлөгдсөөр ирсэн. Баруун талд хэд хэдэн хөтөлбөр оруулав.

Хүүхэд, өсвөр үеийнхний хөтөлбөр

Та эдгээр шаардлагыг сүнслэг нүдээр харах юм бол тэд нийтлэг үзэл санаатай байсныг анзаарна. Залуу эмэгтэйчүүдийг Есүс Христтэй илүү ойртуулж, сүнслэг болон оюун ухаан, нийгэм, бие бялдрын хувьд хөгжихөд нь туслахдаа өнгөрсөн ба одоо үед хамтдаа нэгддэг.

2019 онд өөртөө болон Аврагчид найдахыг урьдаг хувь хүний хөгжлийн шинэ хөтөлбөр гарсан. Та нарыг өөрсдийн Аврагч Есүс Христтэй адилхан болохоор хичээхдээ Ариун Сүнсийг эрэлхийлж мөн хувийн зорилгууд тавихад урьж байна! Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гайхалтай залуу эмэгтэйчүүд болох та нарт үзүүлдэг энэ итгэл найдварт би дуртай.

Бишопын болон Залуу эмэгтэйчүүдийн ерөнхийлөгчийн зөвлөлийн дэмжлэгтэйгээр ангийн тань залуу эмэгтэйчүүдийн хөтөлбөрийг төлөвлөж мөн хэрэгжүүлэхээр дуудагдсан ерөнхийлөгчийн зөвлөл буюу үе тэнгийнхэн тань та нарыг удирддаг. Өнөөдөр дэлхий даяар хагас сая гаруй залуу эмэгтэй үе тэнгийнхнээрээ удирдуулж байна!



1915 онд:

- Олон морьд хөллөж, мөн жолоодож сурах
- Судрын хэсгүүдийг цээжлэх.

1940-1960-аад он хүртэл:

- Биеэ тэгш цэх (суух, зогсох, алхахад) авч явснаар өөртөө итгэлтэй байдлаа нэмэгдүүлэх
- Эелдэг байж, хатагтайн шинжийг харуулах

1980-аад онд:

- Номлогчийн хоёр товхимол уншаад, бусад найз юм уу хамаатан садандаа сурсан зүйлээ заах өгөх
- Өдөрт дор хаяж 30 минут, гурван долоо хоногийн турш долоо хоногт таван өдөр биеийн тамирын дасгал хийх

2009 онд:

- Ариун явдал, ариун журмын ач холбогдлыг судлах
- Мормоны Номыг бүхэлд нь унших, тэмдэглэлдээ төрсөн бодлоо бичдэг байх зэрэг юм.

2020 онд:

- Шинэ хөтөлбөрийг танилцуулсан

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КОРИ ЭГБЭРТ

Бүх залуу эмэгтэй дараах суурь зарчмуудыг багтаасан сэдвийн доор нэгддэг билээ. Та бол тэнгэрлэг эцэг эхийн хайртай охин; та бол Есүс Христийн гэрээт шавь; та Ариун Сүнсээр дамжин ирэх хувийн илчлэлтийг эрэлхийлж, үүний дагуу үйлддэг; та бидний Аврагч Есүс Христтэй адил болохыг мөн Түүний ариун нэрээр бусдад тохинуулахыг хичээснээр Бурханы гэрэлтэй гэрч болдог.

Бид танд хайртай, та бидэнд хэрэгтэй!

Та амьд бөгөөд хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэгийн хайртай охины хувьд "Сион уулан дээр аврагч" болохын тулд онцгойлон бэлтгэгдсэн билээ.[3] Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон: Бошиглогч бүр Израилд цугларч, Аврагчийн Хоёр дахь ирэлтэд дэлхий бэлтгэгдсэн байх *бидний* өдрийн тухай ярьсан. Үүнийг бодоод үз дээ! Энэ гараг дэлхий дээр амьдарч байсан бүх хүн дотроос гагцхүү *бид* энэхүү эцсийн бөгөөд агуу цугларалтын үйл явдалд оролцож байгаа"[4] хэмээн хэлсэн.

Энэ бол ариун сүм, гэр бүлийн түүхийн ажилд оролцох, удирдах албан тушаалд үйлчлэх, эгч дүү нартаа тохинуулах, гэрчлэлээ гэр бүл, найз нөхөдтэйгээ хуваалцах ариун урилга юм. Та хайрлагдсан нэгэн бөгөөд та бидэнд хэрэгтэй байна!

Хүндэт найзууд минь, Тэнгэрлэг Эцэгт танаар бидний Аврагч Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн тулд гүйцэлдүүлэх агуу ажил байна. Та бол тэр ажлын чухал хэсэг юм. Тэр танд хайртай. Тэр таныг Өөрийнхөө ажилд оролцоосой гэж хүсдэг; Тэр танд итгэдэг!

"Та нар бол Их Эзэний энэ дэлхийд илгээсэн хамгийн сайн хүмүүсийн *нэг*. Та нар урьд өмнөх бүх үеийнхнээс илүүтэйгээр дэлхийд нөлөөлөхүйц ухаалаг, илүү мэргэн байх чадвартай!"[5] хэмээн хэлсэн эрхэм бошиглогчийнхоо үгэн дээр нэмж, би та нарт итгэж, найдаж явдгаа хэлмээр байна.

Та нар Аврагчид улам ойртож, Түүний тухай илүү ихийг мэдэх боломжийг тэврэн авснаар Залуу эмэгтэйчүүдийн урианы үгсийг зүрх сэтгэлдээ шингээж мөн шинэ хөтөлбөрт урамтайгаар оролцох болтугай хэмээн би залбирч байна. Түүний та нарыг ямар байгаасай гэж хүсэж байгаа тийм хүн бол. Та нар үүнийг хийснээр амьдрал тань Түүний гэрэл, хайрыг гэр бүл, найз нөхөд, эргэн тойрныхоо хүн бүртэй хуваалцах боломжоор дүүрнэ гэдгийг би мэднэ. Та Түүнийг дагахыг хичээх тусам таны гэрчлэл бат бөх, хөдөлшгүй байх болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Brigham Young, in *A Century of Sisterhood: Chronological Collage, 1869–1969* (1969), 8.
2. Brigham Young, in Susa Young Gates, *History of the Young Ladies' Mutual Improvement Association of the Church of Jesus Christ of Latter-day Saints from November 1869 to June 1910* (1911), 9.
3. Квинтин Л.Күк, 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган (*Лиахона,* 63).
4. Мөн Рассэлл М.Нэлсон, "Израилын итгэл найдвар" (өсвөр үеийнхэнд зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт, 2018 оны 6-р сарын 3) HopeofIsrael.ChurchofJesusChrist.org.
5. Рассэлл М.Нэлсон, "Израилын итгэл найдвар," 16–17.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ МАТТ РЭЕР

Залуу эмэгтэйчүүд

150 ЖИЛИЙН ОЙГОО ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ НЬ

Аманда Данн
Сүмийн сэтгүүлүүд

Залуу эмэгтэйчүүдийн байгууллага энэ жил 150 нас хүрч байгаа бөгөөд одоо тэмдэглэх цаг болжээ. Энэхүү байгууллага нь 1870 оноос өнөөг хүртэл хэрхэн өөрчлөгдөж, та нартай адил өсвөр үеийнхэн Залуу эмэгтэйчүүдийн бүлэгт оролцон юу хийж байгаа, түүхэн дэх зориг, итгэл үнэмшилтэй эмэгтэйчүүд танд хэрхэн урам зориг өгч болох талаарх дараах баримтуудыг үзээрэй.

1870–1920

Нэр: Залуу хатагтай нарын хамтын Ажилчдын холбооны залуу хатагтай нарын алба нь Бригам Янгийн удирдлаган доор 1870 оны 5-р сарын 27-нд албан ёсоор зохион байгуулагдаж байсан.[1] Энэ нэр 1877 онд Залуу эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааны холбоо болон өөрчлөгджээ.[2]

Байгууллага ба ангиуд: Бийхайв охидын хөтөлбөр 14 ба түүнээс дээш насны охидын зуны хөтөлбөр болж байгуулагдсан.

Өсөлт хөгжил ба шагнал: Бийхайвын гарын авлага нь 1915 онд хэвлэгдсэн бөгөөд хувийн хөгжлийн долоон "талбарыг" тусгасан. Үүнд шашин, гэр орон, эрүүл мэнд, гэрийн ажил, гадуурх үйл ажиллагаа, бизнес ба олон нийтийн үйлчлэл зэрэг зүйл багтсан байна.[3]

Сэтгүүл ба сонин хэвлэл: *Залуу эмэгтэйчүүдийн сэтгүүлийн* анхны дугаар 1899 онд хэвлэгдэж байжээ.[4] Орон нутгийн Хамтын ажиллагааны холбоо (эсвэл ХАХ) гараар бичсэн ганц, хоёр хувь сонингоо охидын дунд дамжуулан уншуулахаар тараадаг байв.

1920–1970

Нэр: 1934 онд Залуу хатагтай нарын хамтын ажиллагааны холбоо Залуу эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааны холбоо болж өөрчлөгджээ.[5]

Байгууллага ба ангиуд: Бага охидынх нь Бийхайв, том охидынх нь Глийнэрс гэсэн хоёр ангиас бүрдэж байв. Энэ хөтөлбөрт орох нас 14 байснаа 12 болж өөрчлөгдсөн. 1950 онд Миа Мэйд ангийг танилцуулжээ.

Өсөлт хөгжил ба шагнал: Алтан Глийнэр (Golden Gleaner) шагнал гэдэг нь залуу эмэгтэйчүүдийн уг хөтөлбөрөөр авч болох хамгийн өндөр амжилтыг хэлнэ.

1970–2019



ХУВИЙН ХӨГЖИЛ ДЭВШИЛ МЕДАЛИА ЗҮҮСЭН ЗАЛУУ ЭМЭГТЭЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ АЛИСИА СЕРВА
ЗАЛУУ ЭМЭГТЭЙН ПРОФАЙЛ ЗУРГИЙГ СҮМИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙТЛЭВ

Сэтгүүл ба сонин хэвлэл: *Залуу эмэгтэйчүүдийн сонин* 1929 онд бүх өсвөр үеийнхэнд зориулсан *Improvement Era* сэтгүүлтэй нэгдсэн.[6]

Нэр: Залуу эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааны холбоо 1974 онд Залуу эмэгтэйчүүдийн байгууллага болж өөрчлөгдсөн.[7]

Байгууллага ба ангиуд: 1972 он гэхэд Залуу эмэгтэйчүүдийн байгууллага Бийхайв (12–13 нас), Миа Мэйд (14–15 нас), Лоорэл (16–17 нас) гэсэн гурван ангитай болсон байв. 2019 оноос эхлэн залуу эмэгтэйчүүд 12 нас хүрэх оныхоо 1-р сард Бийхайв ангид ордог болсон.

Өсөлт хөгжил ба шагнал: Хувийн хөгжлийн хөтөлбөрийг болон хүзүүний зүүлтийг 1977 онд танилцуулсан. Итгэл, Бурханлаг мөн чанар, Хувь хүний үнэ цэн, Мэдлэг, Сонголт, Үүрэг хариуцлага, Сайн үйлс ба зарчимч байдал зэргийг 1987 онд нэмж оруулсан.[8] Эдгээр эрхэмлэх чанарт Ариун журам гэдэг чанар 2008 онд нэмэгдэн орсон.[9]

Сэтгүүл ба сонин хэвлэл: Өсвөр үеийнхний *New Era* сэтгүүл 1971 онд англи хэл дээр хэвлэгдэж эхэлсэн ба *Лиахона* сэтгүүл өсвөр үеийнхэнд зориулсан нийтлэлүүдийг олон хэл дээр гаргаж эхэлсэн.[10]

Зугаатай баримт

1. 1915 оны Бийхайв гарын авлага залуу эмэгтэйчүүдэд 300 гаруй өөр сонголтуудаас төслүүдийг сонгох боломжийг олгож байжээ. Эдгээр төслийн зарим нь бүтэн улирлын турш зөгийн үүр арчлах, гэр орноо хоёр долоо хонох ялаагүй байлгах эсвэл хамгийн багадаа хагас акр газрын хуурай бутыг татаж цэвэрлэх ажил байдаг байв.[12]

2020

Нэр: Нэр нь Залуу эмэгтэйчүүдийн байгууллага хэвээр үлдсэн.

Байгууллага ба ангиуд: Ангиудыг тойрог, салбар бүрд өөрсдийнх нь хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулж, “Залуу эмэгтэйчүүд” гэсэн нэгдмэл нэрээр тодорхойлно (жишээ нь, “12 настай залуу эмэгтэйчүүд,” “12–15 настай залуу эмэгтэйчүүд” эсвэл бүгд хамтдаа уулзах бол зүгээр л “Залуу эмэгтэйчүүд” гэнэ).

Өсөлт хөгжил ба шагнал: Хувийн хөгжлийн хөтөлбөрийг Хүүхэд, өсвөр үеийнхэн болгож өөрчилсөн. Шинэ хөтөлбөр нь хөгжил, сайн мэдээнээс суралцах, үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэлээр хувьчлан өсөж хөгжих боломжийг олгодог.[11]

Сэтгүүл ба сонин хэвлэл: Өсвөр үеийнхэнд зориулсан *New Era* сэтгүүлийн 50 жилийн ой удахгүй тохиох гэж байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. “Timeline of Young Women History,” history.ChurchofJesusChrist.org/landing/a-brief-timeline-of-young-women-history үзнэ үү.
2. “Young Women’s Timeline,” *Mormon Women’s Studies Resource,* Harold B. Lee Library, Brigham Young University, Provo, Utah, mormonwomen.lib.byu.edu/young-womens-portal/young-women-timeline -ийг үзнэ үү.
3. “History of Young Women Recognition,” history.ChurchofJesusChrist.org-ыг үзнэ үү.
4. “Young Women’s Timeline”-ыг үзнэ үү.
5. “Young Women’s Timeline”-ыг үзнэ үү.
6. “Young Women’s Timeline”-ыг үзнэ үү.
7. “Young Women’s Timeline”-ыг үзнэ үү.
8. “Young Women’s Timeline”-ыг үзнэ үү.
9. “New Young Women Value: Virtue,” Dec. 9, 2008, thechurchnews.com-ыг үзнэ үү.
10. “Young Women’s Timeline”-ыг үзнэ үү.
11. ChildrenAndYouth.ChurchofJesusChrist.org-ыг үзнэ үү.
12. “History of Young Women Recognition”-ыг үзнэ үү.
13. “History of Young Women Recognition”-ыг үзнэ үү.
14. “Young Women Classes and Symbols,” ChurchofJesusChrist.org/young-women/personal-progress-ыг үзнэ үү.
15. “History of Young Women Recognition”-ыг үзнэ үү.
16. “The Annual Report of the Church,” *Ensign*, July 1972, 131–133-ыг үзнэ үү.
17. “Worldwide Statistics,” newsroom.ChurchofJesusChrist.org/facts-and-statistics-ыг үзнэ үү.



2. Тэр үеийн Бийхайв охид орон нутгийн холбоодынхоо гаргаж өгсөн дүрэмт хувцсыг өмсдөг байсан бөгөөд 1922 онд Хамтын ажиллагааны холбооны албан ёсны өнгө болох алтан шаргал, ногоон өнгөтэй болсон.[13]

3. Бийхайв гэдэг нэр нь зөгийн үүрийг ажил, эв найрамдлын бэлгэдэл гэж үздэг байсан анхдагчдаас гаралтай. Миа Мэйд нь Mutual Improvement Association (Хамтын ажиллагааны холбоо) гэдэг үгийн товчлол болох MIA гэдэг үгнээс гаралтай. Лоорэл гэдэг нэр нь лаврын цэцгэн титмийг хэлж байгаа бөгөөд алдар нэр, амжилтад хүрэх гэсэн утгатай.[14]

4. 1940–1960 оны хооронд залуу эмэгтэйчүүд цээжиндээ өмсдөг бандэло хэмээх эсгий туузан дээр оёдог эмблем авдаг байв. Энэ эмблемийг авах нэг шаардлага бол "энэ сар орой бүр бүтэн есөн цаг сайхан унтахыг хичээх"[15] явдал байв.

5. Сүмийн нийт гишүүд 1870[16] онд 110 000 орчим байсан бол 2020[17] онд 16 сая гаруй болж өсжээ. Дэлхий даяар одоо хэчнээн олон залуу эмэгтэй байгааг бодоод үз дээ!

Хэйвэний тусламжийн гар

АНУ-ын Ютад амьдардаг 14 настай Хэйвэн Сүмийн залуу эмэгтэй байгаа боломжоо бусдад үйлчилж тэмдэглэхээр шийджээ.

"Энэ эхлээд жижигхэн санаа байсан" гэж тэр хэлэв. "Нагац ах маань хүмүүнлэгийн аяллаар Бангладеш явж, тэндхийн хүмүүст тохиолдож буй зовлон бэрхшээлийн талаар олж мэдсэн. Би тэдэнд туслахыг хүссэн тул JustServe аппликэйшныг үзэж байгаад, тэндхийн дүрвэгчдэд зориулан гэртээ багц хийж өгөх санаа олсон."

Хэйвэн сургууль дээрээ хандив цуглуулж, GoFundMe хуудас нээж, багцын мөнгөө өсгөхөөр хөршүүдийнхээ хогийн савнуудыг хүртэл гудамж руу гаргаж өгч байв. "Би даваа, мягмар гараг бүр 22 хогийн сав, 11 дахин боловсруулах хог гаргаж тавьж байсан. Би ерөнхийдөө олсон мөнгөө найрал дууны хөтөлбөр болон номлолдоо зориулж хадгалдаг боловч тэр сард материал худалдаж авахад олсон мөнгөө ашиглахаар шийдсэн юм."

Хэйвэн тэгээд гарч, оймс, бээлий, ороолт, малгай зэрэг багцад нь хэрэгтэй бүх зүйлийг худалдаж авчээ. Тэр бүх багцаа цуглуулж дуусаад, Бангладешд багц хүргэх ажлаа зохицуулахаар Lifting Hands International компанийн захиралтай холбоо барив.

"Багц цуглуулах нь миний төслийн хамгийн их цаг зарцуулсан хэсэг нь байсан. Гэхдээ багцдаа ямар нэгэн юм нэмж хийх болгондоо энэ нь тусламж хэрэгтэй хүнд очиж, үүгээр дамжуулан тэд удаан хугацаанд адислагдана гэдгийг би мэдэж байсан юм."

Хэйвэн төслөө хийж дуусах үедээ үйлчлэх чадвартаа улам их итгэдэг болсноо мэдэрсэн байна. "Хэрвээ би шаргуу хичээвэл бусдад хэчнээн их тусалж чадахаа үнээс ойлгож авсан юм. Би бас тусалсан хүмүүсээ өрөвдөн хайрлаж, ингэснээр Аврагчид илүү ойртож, бидний төлөө юу гэж боддогийг нь жаахан ч гэсэн мэддэг болсон."

Бид Залуу эмэгтэйчүүдийн байгууллагын ойг тэмдэглэн өнгөрүүлэхдээ бүгд Христийн үлгэр жишээ байж чадна гэдгээ санаж чадна. Бид Хэйвэнтэй адил, Христийн үйлчлэх байсан арга замаар чадах чинээгээрээ үйлчлэх гэж хичээх юм бол бусдад их тус болж чадна. ■

Би сэтгэлийн хямралд орсон найздаа хэрхэн тусалж чадах вэ?”



“Та эсвэл таны хайртай хүмүүс сэтгэцийн эсвэл сэтгэл санааны хямралд орвол та хэрхэн хандах вэ? Юуны түрүүнд таны ойлгож чадахаас ч илүүгээр таныг хайрладаг Тэнгэр дэх Эцэгтээ итгэх итгэлээ хэзээ ч бүү алд. . . .

. . . Бидний өгч чадах эсэх бусад зүйлээс үл хамааран, бид залбирч мөн “чин сэтгэлээсээ” хайрлаж чадна.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Хагархай сав шиг,” *2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган*



Тэднийг өөртэйгөө хамт байхад урих

Өөртэйгөө хамт хөгжилтэй зүйл хийхэд тэднийг урь. Хэрэв хүссэнээр чинь хандахгүй бол сэтгэлээр бүү уна. Заримдаа ямар нэгэн зүйл хийхэд урих юм уу тэдэнтэй хамт баймаар байгаагаа мэдэгдэх нь л тэдний сэтгэл санааг өргөх арга болж болох юм.

Алисса Ф., 16 настай, АНУ, Вашингтон



Тэднийг ойлго

Би сэтгэлийн хямралд орсон найзуудтайгаа байхдаа тэдний зовлонд хөнгөн хуумгай хандаггүй. Харин тэдэнд асуудлуудаа хөнгөлөхөд нь тусалдаг. Би тэднийг ойлгож, хайраар хандахыг хичээдэг. Би тэдэнд бухимдлаа гаргах боломжийг олгодог.

Ангбо К., 18 настай, Айвори Коаст

Тэдний асуудалд бүү орооцолд

Тэдэнд болон өөртөө туслах хамгийн сайн арга бол чин сэтгэлээсээ байх явдал юм. Өөрт тань баяр баясгалан өгдөг зүйлсийг тэдэнд хэл. Хэрэв та өөрөө аз жаргалтай байж чадахгүй байгаа бол тэдэнд туслахад бэлэн байгаагаа мэдэгдээд бас өөртөө санаа тавиарай. Энэ нь танд тэдний асуудалд орооцолдохоос дээр байх болно.

Кира В., 16 настай, АНУ, Канзас

ГАРНУУДЫН ГЭРЭЛ ЗУРГИЙГ GETTY IMAGES-ЭЭС АВАВ.



Эерэг байх тухай бод

Та амьдралдаа тохиолдсон эсвэл удахгүй тохиолдох сайхан бүхнийг бодож, сэтгэлийн хямралд орсон найзынхаа хажууд эерэг байж чадна. Хөгжилтэй тохиолдол гэх мэт талархаж явдаг зүйлсээ бодоорой.

Лук П., 14 настай, АНУ, Шинэ Мехико

Тэдэнд сайн сайхан зүйлсийг сануул

Би найзынхаа сэтгэлийг хямарсан үед амьдралынх нь сайн сайхан зүйлсийг сануулахын тулд сонирхолтой зүйлсийн талаар ярихыг хичээдэг. Заримдаа би тэднийг инээлгэж эсвэл сайхан сэтгэгдэл төрүүлэхийн тулд магтаж, заримдаа тэднээс чухал зүйл хийхийг хүссэнээр тэдэнд зорилго байгааг сануулахыг хичээдэг.

Карсон Д., 15 настай, АНУ, Техас

Редакторын тэмдэглэл: Энд санал болгосон зөвлөмжүүд тус болох болович сэтгэлийн хямралд орсон хүнд шууд тусалж эсвэл эдгээж чадахгүй. Илүү ноцтой тохиолдлуудад мэргэжлийн тусламж авах шаардлагатай байж болно.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодруулахын тулд хянан засварлах магадлалтай. Хэвлэгдсэн хариулт нь тусламж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Та юу гэж бодож байна вэ?

"Би сонсож байгаа цэвэр бус үг хэллэгээ хэрхэн оюун санаанаасаа салгах вэ?"

Хэрэв та хүсвэл, хариултаа нягтаршил өндөртэй зургийн хамтаар 2020 оны 6-р сарын 15-ны дотор liahona@ChurchofJesusChrist.org хаягаар илгээнэ үү.

Сүм арьс өнгөөр ялгаварлах үзлийн талаар ямар бодлого баримталдаг вэ?

Бид Бурхан бүх хүн төрөлхтний Эцэг гэдэгт мөн "тэрээр хар ба цагаан . . . хэнээс боловч үл татгалздаг; . . . мөн Бурханд бүгд адил" (2 Нифай 26:33) гэдэгт итгэдэг. Бүх хүн Бурханы өмнө эрх тэгш тул арьс өнгө, үндэс угсаа, гарал үүслээсээ болж хэн ч нөгөөгөөсөө давуу эрхтэй гэж үзэхгүй байхад бид итгэдэг. Үүнээс гадна бусдыг арьс өнгөөр нь дорд үзэх, шударга бус хандах, ялгаварлан гадуурхах зэрэг нь нүгэл гэдэгт бид итгэдэг.

Орчин үеийн бошиглогч, төлөөлөгчид арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлыг хамгийн хүчтэй байдлаар буруушаадаг. Жишээ нь:

- Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008): "Бусад хүний талаар арьс өнгөөр нь гутаан доромжилсон үг хэлсэн хэн ч өөрийгөө Христийн үнэн дагалдагч хэмээн бодох ёсгүй. Тэр өөрийгөө Христийн Сүмийн сургаалтай нийцэж байна гэж үзэх ч хэрэггүй."[1]
- Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард: "Бид Бурханы үр хүүхдүүдийг энэрэн хайрлаж, арьс өнгө, яс хүйс, үндэс угсаагаар нь ялгаварлан гадуурхах аливаа гадуурхлыг үгүй хийх ёстой."[2]
- Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгчийн нэгдүгээр зөвлөх Даллин Х.Өүкс: "Өнөө үед арьс өнгөөр ялгаварлах нь гадуурхлын хамгийн түгээмэл эх сурвалж бөгөөд бид бүгд үүнд наманчлахаар дуудагдсан."[3]

ЭШЛЭЛҮҮД

1. Gordon B. Hinckley, "The Need for Greater Kindness," *Liahona,* May 2006, 58–61.
2. М.Рассэлл Баллард, "Аялал үргэлжилсээр!" *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган,* 104.
3. Даллин Х.Өүкс, "Баяр тэмдэглэх шалтгаан," *Лиахона,* 2018 оны 12-р сар, 49.

Санваарын хүчээр хамтдаа үйлчлэх нь

Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард
Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч

Хэдэн жилийн өмнө миний эхнэр Барбара бид хоёр тэнгэр өөд ширтэн, бишрэн зогссон юм. Сая сая од онцгой тод бөгөөд үзэсгэлэнтэй харагдаж байлаа. Дараа нь би Агуу Үнэт Сувд номоос Их Эзэн Бурханы Моисед хэлсэн "Мөн тоо томшгүй олон дэлхийг бүтээсэн буюу би; мөн тэрчлэн өөрийн хувийн зорилгын учир тэрчлэн тэдгээрийг бүтээсэн болой би; мөн миний Төрсөн Ганц болох Хүүгээр би тэдгээрийг бүтээлгэсэн юм" (Мосе 1:33) гэсэн үгсийг уншив.

Тэнгэр, газрыг бүтээсэн энэ хүч бол санваар юм. Энэ санваарын хүчний эх сурвалж нь Бүхнийг Чадагч Бурхан болон Түүний Хүү Есүс Христ хоёр. Аврагч гайхамшгуудыг үйлдэж, хязгааргүй Цагаатгалаар хангаж мөн Амилалтаар дамжуулан бие махбодын үхлийг даван туулахдаа энэ хүчийг ашигласан.

Тэнгэрлэг Эцэгийн маань төлөвлөгөөнд эрэгтэйчүүдэд санваарыг ашиглах онцгой үүрэг өгөгдсөн ч тэд өөрсдөө санваар биш юм. Тэнгэрлэг Эцэг Өөрийн бүх охид хөвгүүдэд санваарын адислалуудыг хүлээн авч мөн санваарын хүчээр хүчирхэгжих арга замыг өгсөн гэдгийг бид ойлгох нь чухал.

Дэлхий ертөнц, галактик болон сансар огторгуйг бий болгосон тэрхүү санваарын хүч нь биднийг өөрсдийн гэр бүл, найз нөхөд, хөршдөө тусалж, тэднийг хүчирхэгжүүлж мөн адислахад бидний амьдралын нэг хэсэг болж чадах бөгөөд тийм байх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, Аврагч өнөөдөр бидний дунд тохинуулж байсан бол хийх байсан тэдгээр зүйлийг хийнэ гэсэн үг (Сургаал ба Гэрээ 81:5-ыг үзнэ үү).

Энэхүү санваарын хүчийн хамгийн чухал зорилго бол биднийг гэр бүлтэйгээ тэнгэрлэг эцэг эхийн дэргэд амьдрах боломжийг олгохын тулд адисалж, ариусгаж, цэвэршүүлэх явдал юм. Ийм арга замаар бүх эрэгтэй, эмэгтэй хүн болон хүүхдүүд ямар ч нөхцөл байдлаас үл хамааран Бурхан, Есүс Христ хоёрын гайхамшигт ажилд оролцож (Мосе 1:39-ийг үзнэ үү) мөн санваарын адислалуудыг хүлээн авч чадна.

Бид ухаалаг байж, өөрийн болон гэр бүлийнхээ амьдралыг мөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг Бурханы санваарын хүчээр дамжуулан хүчирхэгжүүлэхийг эрэлхийлээсэй. ■

2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс.

Эбиш

Түүний итгэл даахуйц үйлдэл **олон лемен хүнийг хөрвөгдөхөд** тус болжээ.





Христийг төрөхөөс 90 орчим жилийн өмнө амьдарч байсан.

Зөв цаг иртэл **тэр өөрийн итгэлийг нууцалсан.**





“Эцэгийнхээ гайхамшигт үзэгдлийн” (Алма 19:16) учир **сайн мэдээнд хөрвүүлэгдсэн.**

Хатанд үйлчилдэг байсан лемен үндэстэн эмэгтэй.

ХАЙЧИЛЖ БОЛОХ ЗУРГИЙГ ГЭЙЛ АРМСТРОНГ; ЗУРААСАН ЗУРГИЙГ КАТИ ДОКРИЛЛ

ГАНЦ БИЕ БАЙГААДАА СТРЕССДЭЖ БАЙНА УУ?

Залуучууд мөнхийн ханиа олохдоо стрессээс хэрхэн гарсан тухай тэдний туршлагаас уншаарай.

42

ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮД

150 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ НЬ

54, 58

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

СЭТГЭЛИЙН ХЯМРАЛД ОРСОН НАЙЗДАА ТУСЛАХ НЬ

62

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

МОРМОНЫ НОМЫН ЭНЭ ТОХИРУУЛДАГ ТОГЛООМЫГ ТОГЛО

H12

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ

MONGOLIAN
4 02167 21363 5

2020 оны 6-р сар

Найз



АБИШИЙН
талаар мэдэж ав
H20–H23-р хуудас

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргадаг *Лиахона* сэтгүүлийн хүүхдүүдэд зориулсан хэсэг

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг
Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Гэрчлэл ба Мормоны Ном



Би Мормоны Номоос
цөөхөн хэдэн мөр уншсан байсан ч
гэрчлэл маань өсөн нэмэгдэж
байгааг болон
энэ ном бол үнэн гэдгийг мөн
Есүс бол Христ бөгөөд
бид Түүнийг гэртээ дагаж
чадна гэдгээ мэдэрдэг.
Энэ нь миний хувьд хамгийн
шилдэг ном байсаар ирсэн билээ.
Энэ бол Бурханы үг юм.

"The Book of Mormon as a Personal Guide,"
Ensign, *Sept. 2010, 4–6 хэсгээс авав.*

Өөрийн тань гэрчлэл

Гэрчлэл гэдэг нь Ариун Сүнс танд ямар нэгэн зүйл үнэн гэдгийг хэлж байгаа сайхан мэдрэмж юм. Чи гэрчлэлтэй болоход хэзээ ч залуудахгүй. Цаасан туузнууд хайчилж, өдөр бүр нэгийг нь сонгохын тулд аяга юм уу шилэн саванд хийгээрэй. Та зүрх сэтгэлдээ гэрчлэл мэдэрвэл үүнийгээ хэн нэгэнд хэлээрэй!

"Би Аврагчийн хайрыг мэдэрдэг" (*Хүүхдийн дууны ном,* 42–43) дууг дуул.

"Гетсемани" (*Лиахона,* 2018 оны 3-р сар, 74–75) дууллыг дуул.

Ариун сүмийн зургийг хар.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсоны хэлсэн үгийг сонс.

Есүсийн зургийг харах юм уу Түүний тухай видео бичлэгийг үзээрэй.

Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч мөн Ариун Сүнсний мэдрэмжүүдийг сонс.

"Христийн үгэн дээр найрла; . . . Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно" (2 Нифай 32:3).

Би

Тэнгэрлэг Эцэгт хандан залбирахдаа,

ариун сүмийн талаар бодохдоо мөн

бусдад туслахдаа Ариун Сүнсийг мэдэрдэг.

Та хэзээ Ариун Сүнснээс гэрчлэл хүлээн авч байсан бэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭТ М.ВИТТАКЕР

Кэллигийн залбирал

Лори Фүллэр Соса
Сүмийн сэтгүүлүүд
(Бодит түүхээс сэдэвлэв)

Кэлли ээжтэйгээ сүмийн цуглааны байр руу очоод, эргэн тойрноо харав. Сүмийн гадаа дал мод найган, үзэсгэлэнтэй харагдаж байлаа. Барилга дээр "Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм" гэсэн нэр байв. Үүнийг малай, хятад, англи гэсэн гурван өөр хэл дээр бичсэн байв!

Кэлли Есүс Христийн талаар тийм ч их зүйл мэдэхгүй ба өмнө нь сүмд ирж байгаагүй юм. Ээжийнх нь найз Ли Лийн энэ сүмд явдаг байв. Тэр Кэллиг ээжтэй нь хамт ирэхийг урьсан байна.

Тэднийг дотогш ороход хүмүүс инээмсэглэн, мэндэлж байв. Хүн бүр сайхан хандаж байлаа. Кэлли ээжтэйгээ Ли Лийнийг даган, дээд давхрын том өрөөнд оров. Ли Лийн үүнийг ариун ёслолын танхим гэв.

Кэлли олон эгнээ сандлуудын дунд ээж, Ли Лийн хоёрын хажууд сууж, цуглаан ч удалгүй эхлэх болов. Тэр дуу хөгжмийг сонсож байлаа. Тэр үгийг нь мэдэхгүй ч хөгжим түүнд таалагдаж байв.

Цуглаан дуусахад нэг эмэгтэй залбирахаар босов. Хүн бүр гараа зөрүүлэн тэвэрч, нүдээ анихад Кэлли эргэн тойрноо харав. Тэр дотроо ямар нэгэн сайхан зүйлийг мэдэрчээ. Энэ юу *байсан бэ*? Энэ бүхэн түүний өмнө нь мэдэрч байсан бүхнээс өөр байв.

Кэлли хожим нь ээжтэйгээ сүмээс гарч явахдаа залбирлын үеэр мэдэрсэн мэдрэмжээ ээждээ хэлэв.

"Би ямар ч онцгой зүйл мэдрээгүй" гэж ээж нь хэлэв.

Гэвч Кэлли Сүм дээр мэдэрсэн зүйлийнхээ талаар бодсоор л байв. Түүнд залбирал таалагдсан байв. Түүнд Есүсийн талаар сонсох сайхан санагджээ.

"Номлогчид надад зааж чадах болов уу?" гэж Кэлли ээжээсээ асуув. "Би илүү их зүйлсийг сурахыг хүсэж байна."

"Хэрэв чи хүсэж байвал болно" гэж ээж нь хэлэв.

Номлогчид Кэллид хэрхэн залбирч, судраас унших талаар зааж өгөв. Тэд Есүсийн талаар, Тэр бидэнд хэчнээн их хайртайг түүнд заав. Кэллид мэдэж авсан бүхэн нь таалагджээ.

Нэг өдөр номлогчид түүнд онцгой даалгавар өгчээ.

"Чи энэ долоо хоногийн туршид залбирах гэж оролдож үзэх үү?" гэж номлогч Паркер асуув.

Кэлли одоо болтол зөвхөн номлогчидтой хамт залбирдаг байсан ч өөрөө оролдож үзэхээр шийдэв. Тэнгэрлэг Эцэг үргэлж сонсдог бөгөөд Тэр түүнийг сонсохыг хүсэж байгааг тэр мэддэг болсон.

"Би залбирна" гэж тэр амлав.

Маргааш нь сургууль дээр нь онцгой өдөр болов. Кэлли тэмцээн дээр дуулах гэж байв. Тэр нэгэн

ЗУРГИЙГ ТАММИ ЛИОН

шинэ, гайхалтай хятад дуу сурсан байв. Бүх нот, аяыг сурах хэцүү байсан ч тэр олон дахин давтжээ.

Кэллигийн тайзан дээр гарах цаг болоход тэр сандарч байлаа. Тэр өглөө дүрэмт хувцасныхаа халаасанд хийсэн Есүсийн зургийг гаргаж ирэв. Тэр номлогчдын зааж өгснөөр залбирахаар шийдэв. "Тэнгэрлэг Эцэг минь, сандрахаа болиход минь туслаач" гэж тэр залбирав. "Есүс Христийн нэрээр, амен."

Дараа нь Кэлли тайзан дээр гарав. Тэр үзэгчид болон шүүгчид рүү харав. Түүнийг халаасандаа байгаа Есүсийн зургийн талаар бодоход түүний сэтгэл санаа дээрдэв. Тэр гүнзгий амьсгал аваад, дуулж эхэллээ.

Тэр давтаж байсан шигээ бүх үгээ хэлж дуулав. Кэлли сүүлийн нотоо дуулж, ёслохдоо Тэнгэрлэг Эцэг залбирлыг нь сонсож мөн түүнд тусалсныг мэдэж байлаа.

Кэлли инээмсэглэн тайзнаас буув. Тэр юу болсноо номлогчдод хэлэхээр тэсэн ядан хүлээж байлаа. Тэр өдөр бүр залбирахыг хүсдэг болсон байв. ●

Сайн байна уу? Германаас мэндчилж байна!

Герман буюу *Дойчланд* нь Европын төв хэсэгт байдаг. Энэ нь ой, гол мөрөн, уул, далайн эрэг, тосгон, том том хотуудтай. Германд ойролцоогоор 13 орчим сая хүүхэд амьдардаг ба

20 000 орчим шилтгээн байдаг. Ихэнх нь олон зуун жилийн настай. Энэ бол Ньюсванштайн гэдэг алдартай барилга юм.

Германд хоёр ариун сүм байдаг. Нэг нь Фрайбэргт, нөгөөх нь энэ хүүгийн байгаа Франкфуртад байдаг. Хаяган дээр нь *"Tempel der Kirche Jesu Christi der Heiligen der Letzten Tage"* (Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ариун сүм) гэсэн байна.

Давсалж дарсан байцаа, зайдас, *Spätzle* (гоймон) зэрэг нь Германы түгээмэл хоол хүнс юм.

Охид, хөвгүүд Хүүхдийн хэсэгтээ оролцох дуртай.

Герман улс Христийн мэндэлсний баярын худалдаагаараа алдартай. Гэр бүлүүд нь үзэсгэлэнт сайхан гэрлүүдийг харж, амтат сайхан амттан идэх дуртай!

Энэ бол герман хэл дээрх *Хүүхдүүдэд зориулсан гарын авлага* юм. Германд хүүхдүүд сурч, хөгжихдөө үүнийг ашиглаж байна. Харин та нар амьдарч байгаа газартаа гарын авлагаа хэрхэн ашиглаж байна вэ?

Хүүхэд бүр бага сургуулийнхаа анхны өдөр цүнх (үүргэвч), үзэг харандааны сав болон чихэр, бэлгээр дүүрэн "цаасан чихрүүд" (*Schultüte* буюу *Zuckertüte*) авдаг.

Зарим герман найзтай минь танилцана уу!

Миний Мормоны Номын хамгийн дуртай түүх бол Христ хүмүүс дээр очиж, заадаг хэсэг юм. Би Христийн бусдыг шүүхгүй байх зарлигийг дагахыг хүсэж байна. Би Аврагчийн сургаалыг унших тусам Түүний хайр, амар амгаланг илүү их мэдэрдэг.

Лэлиа А., 10 настай, Герман, Франкон

Хэрэв би зарлигуудыг дагавал Бурхан руу удирдах зам дээр баттай, аюулгүй үлдэнэ гэдгээ мэднэ. Би Ариун Сүнсийг мэдрэх үедээ зөв зүйл хийснээ үргэлж мэдэж авч чадна.

Калеб А., 12 настай, Герман, Франкон

Та Германд төрсөн үү? Бидэнд захидал бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна.

ЗУРГИЙГ КЭЙТИ МАКДИ; ГЕРМАНЫ ФРАНКФУРТ АРИУН СҮМИЙН НЭРНИЙ ӨМНӨ ЗОГСОХ БҮЙ ХҮҮГИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ФЕРНАНДА РУДЛОФФ, НИЙТ ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ ADOBESTOCK БОЛОН GETTY IMAGES-ЭЭС АВАВ.

Далайн морь шиг сэлсэн нь

Дэвид Диксон
Сүмийн сэтгүүлүүд
(Бодит түүхээс сэдэвлэв)

“Ариун Сүнс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно” (2 Нифай 32:5).

Робин усан бассейн руу ширтэж байв. Тэр хэр хол усанд сэлэхээ бодохгүй байхыг хичээж байлаа. Хамгийн чухал зүйл бол тэмдгийг авах явдал юм. *Seepferdchen* (далайн морь) гэдэг тэмдэг нь Герман дахь хүн бүрд түүнийг ганцаараа сэлж чаддагийг нь харуулах байв.

Би үүнийг хийж чадна! гэж Робин бодов. Тэр гүнзгий амьсгаа аваад, үсрэн оров.

Ус энд тэндгүй цацарлаа!

Ийм халуун өдөр хүйтэн ус маш сайхан байв.

Дараачийнхаа нэг метрт л анхаарал төвлөрүүл гэж аав нь түүнд хэлсэн байв. *Бүх 25 метрийн талаар нэг дор бодож болохгүй.*

Робин толгойгоо доош болгов. Тэр гар, хөлөө хэдэн сарын турш дасгал хийснийхээ дагуу хөдөлгөж, хэдэн секунд болоод л амьсгалахаар дээш цухуйж байв.

Жийгээд, сэлүүрд. Жийгээд, сэлүүрд.

Гэнэт сэлэлтийн багш шүглээ үлээв. Робин гайхсан харцаар харав.

“Чи маш сайн байлаа” гэж багш нь хэлэв.

Тэр чадсан байв!

Робин инээгээд, энэ баяраа тэмдэглэх гэж усан доор хэдэн удаа эргэв. Тэр далайн морь болсон!

Робин гэртээ хариад, аавыгаа олохоор яарав.

Аав аа, хар даа!

Робины аав алхаа доош тавив. Аав нь *seepferdchen* тэмдгийг хармагцаа нүүр дүүрэн инээмсэглэжээ.

“Чиний анхны оролдлого байсан уу?” Аав нь Робиныг тэврэн аваад, “Чи яаж тэмдэглэмээр байна?” гэв.

Робин хэсэг бодсоноо, “Тантай цуг усан бассейнд очихыг хамгийн

их хүсэж байна. Би танд юу чаддагаа харуулмаар байна” гэлээ.

Аав нь улам их инээв. “Одоо тэгвэл *тэр чинь* чи бид хоёрын хоёулангийнх нь хувьд тэмдэглэлт зүйл болно. Цаг гармагц хоёулаа явъя.”

Робин агаарт нударгаараа хий цохив. Тэрбээр усныхаа хувцсан дээр энгэрийн тэмдгээ зүүгээд, аавтайгаа сэлэхээр явна гэхээс тэсэж ядан байв.

Хэдэн өдөр өнгөрлөө. Робин бассейны талаар асуусаар байсан боловч ямар нэгэн ажил гарч ирсээр байв. Аав нь байнга л завгүй байгаа юм шиг байлаа.

Нэг өглөө Робин орныхоо дэргэд залбирахаар өвдөг сөгдөн суув. Залбирлынхаа төгсгөлд тэр нэг зүйл нэмж хэлэв.

“Аав бид хоёрыг бассейн руу хамт явахад зориулж, түүнд цаг гаргаж өгөөч. Есүс Христийн нэрээр, амен.”

Робин нүдээ нээгээд, аавыгаа хаалга тогшиж байгааг сонсов.

“Бассейн руу явцгаая. Би чамайг яаж хийхийг чинь хармаар байна!”

Робин газар хүрэхгүй баярлав. “Аав аа! Та итгэхгүй дээ. Би дөнгөж сая биднийг хамтдаа явахад зориулан танд цаг гаргаж өгөөч гэж *залбирсан.”*

Аав нь гараа энгэртээ зөрүүлээд, хаалга налан зогсов. “Тийм үү, сонирхолтой л юм байна. Чамайг бассейн рүү аваачих хэрэгтэй гэж Ариун Сүнс намуухан, тов тодорхой хэлэхийг *би* дөнгөж сая сонссон. Тэгвэл бид үнэхээр явах хэрэгтэй.”

Тэд цагийг гайхалтай өнгөрөөв. Робин аавдаа 25 метрийн зайд зогсохгүйгээр яаж сэлж чаддагаа үзүүллээ. Аав нь маш сэтгэл хангалуун байв. Робин ч бас аавынхаа усан доорх эргэлтэд сэтгэл нь догдолжээ. Аав нь нэг дор тав эргэж чадаж байв.

“Тэнгэрлэг Эцэг өнөөдөр танд цаг зав гаргаж өгсөнд би баяртай байна” гэж Робин хэлэв.

“Үнэндээ би л өөрийгөө хэт завгүй байлгаад байсан байна лээ. Ариун Сүнс нэг нэгэндээ цаг *гаргах* хэрэгтэйг надад сануулсан гэж би бодож байна. Тийм үү? Би хамгийн сайнаараа байх болно гэж амлаж байна.”

Робин инээмсэглэв. “Би ч гэсэн.”

Аавын нүдэнд инээмсэглэл тодров. “Өөр нэг зүйл байна. Би хэзээ ч ус үсэргэж тоглоход хожигдож байгаагүй гэж чамд хэлж байсан бил үү? “

Робин дахиад инээмсэглэв. “Өдөр дуусах арай болоогүй байв!” ●

ЗУРГИЙГ МАРК В.РОБИНСОН

Энэ үйл явдал Германд болсон юм. Германы талаар Н6–Н7 хуудаснаас унш.

Загварыг дуусга

Энд бид бусдыг сайн мэдээний талаар суралцахад урих дөрвөн арга зам байна. Мөр болгон дээр загварыг гүйцээхийн тулд хоосон зайд зураг зурна.

Хүүхдийн хэсэгт үг хэлж байхдаа нэг найзыгаа ирж сонсоход уриарай.

Найздаа Хүүхдийн хэсгийн дуртай дуугаа заагаад, хамтдаа дуулаарай.

Найз **сэтгүүлийн хувийг хэн нэгэнд өгөөрэй.**

Бурхан, Есүс Христ хоёр тэдэнд хэчнээн их хайртай болохыг хэн нэгэнд хэлээрэй.



ЗУРГИЙГ ТОМАС ЧАЙЛЬД

Үзүүл мөн тайлбарла

Би бага байхдаа арьсны өвчтэй байсан юм. Би өдөр бүр Тэнгэрлэг Эцэгт намайг эдгээгээч гэж залбирдаг байв. Би тэвчээртэй байж сурсан бөгөөд 5 жилийн дараа эдгэрсэн. Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсдог гэдгийг би мэднэ.

Жуёонг К., 12 настай, Өмнөд Солонгос, Геонгги



Найзын маань эмэгтэй дүү нохойноос айдаг. Заримдаа нохойг бидэн рүү дөхөж ирэх үед би түүнийг айлгахгүйн тулд тэднийг холдуулдаг.

Хайрум Ф., 7 настай, Мозамбик, Мапуту

Би гэрийн тэжээмэл хатгадаг шавж тэжээх дуртай. Гэтэл тэдний нэг нь хүндээр өвдсөн байв. Би түүнийг эдгэрээсэй гэж залбирсан. Маргааш нь түүний тор руу харахад бие нь сайжирсан байв. Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонссон гэдгийг би мэднэ.

Тахнэ С., 8 настай, Шинэ Зеланд, Вэллингтон

Намайг 7-той байхад аав маань цус харваж, эмнэлэг явсан. Найм хүрэхэд тэр эмнэлэгт байсаар л байв. Би баптисм хүртэж, гишүүнээр батлуулахын тулд аавыгаа эмнэлгээс гартал хүлээхээр шийдсэн юм. Энэ миний амьдралын хамгийн сайхан өдрүүдийн нэг байсан.

Виллиам М., 9 настай, Австрали, Квийнслэнд

Мигүил Т., 7 настай, Мексик, Нуэво Леон



"Дэлхий даяарх хүүхдүүд," Алексиа В., 10 настай, Коста Рика, Хэрэдиа



Намайг сургуульдаа явахад, зарим сурагч аймшгийн түүх ярих дуртай байдаг байв. Тэд надад нэг түүх ярьж өгч, тэр түүхээс болж би орой болгон маш их айдаг болж эхэлсэн юм. Нэгэн орой би Тэнгэрлэг Эцэгт хандан үүнийг бодохгүй байхад минь туслаач гэж залбирахаар шийдсэн бөгөөд Тэр намайг орой бүр унтахад минь тусалдаг байсан. Би тэр үед Түүнд хэзээ ч, хаана ч залбирч чадна гэдгээ ойлгосон.

Энэрэл Т., 11 настай, Монгол, Улаанбаатар

ДЭВСГЭР ЗУРГИЙГ GETTY IMAGES

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би биш!

Би хэн бэ?

Энд гэрийнхэн болон найз нөхөдтэйгөө тоглож болох тоглоомыг оруулав. Та Алмагийн номоос хэдэн хүнийг ялган таньж чадах вэ?

1. Зүүн талын “Би биш” товчнуудыг болон H15 хуудсан дээрх картуудыг хайчил. Баруун талын зургуудыг хайчилсны хэрэггүй.
2. Тоглож эхлэхийн өмнө H15 хуудасны картуудаас нэгийг сугалж ав. Хэнд ч ямар карт авснаа үзүүлж болохгүй! Бүлгийнхэн тань үүнийг таах гэж оролдоно.
3. Нууц картыг олж мэдэхийн тулд бүлгийнхэн H13 хуудсан дээрх зургуудыг харна. Дараа нь тэд картан дээрх хүмүүс ямархуу харагддаг мөн юу юу хийдэг байсан тухай тийм, үгүй гэж хариулах асуултуудыг ээлжлэн тавина.
4. Бүлгийнхэн нууц хүний хэн байж болох жагсаалтыг богиносгох зүйлийг мэдсэнийхээ дараа “Би биш” товчнуудыг ашиглан, таарахгүй зургууд дээр тавина. Жишээ нь, хэрэв тэднийг “энэ хүн бор үстэй юу?” гэж асуухад карттай хүн үгүй гэж хариулбал тэд бор үстэй хүн бүр дээр “Би биш” гэсэн товчийг тавина.
5. Нууц эрхмийн хэн болохыг мэдсэний дараа бүлгийнхэндээ картан дээрх түүхийг уншиж өг. Дараа нь товчнуудыг холдуулаад, өөр хэн нэгнээр шинэ карт сугалуулан дахин тоглоорой.

Зөвлөмж: Эхлэхээсээ өмнө хүн бүрд түүхийг сануулах үүднээс H15 хуудсыг бүгдийг нь уншиж өгч болно!

Залуу Алма

Аммон



Антай-нифай-лихайчууд

Хатан хаан

Хаан Лемонай

Абиш

Аарон

Корихор

Амаликая

Ахмад Моронай

Шивэгчин

Залуу дайчид

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭФФ ХАРВИЙ

Ахлагч Гари Б.Сабин
Далын

Хэнийг ч орхиогүй

"Бүгд эв найртай, энэрэнгүй байцгаа" (1 Петр 3:8).

Бидний хүү Жастин хүнд өвчтэй өссөн юм. Заримдаа тэр маш их ядардаг байв. Хүү маань хэчнээн хичээгээд ч бусдын адил хийж чаддаггүй байв. Бусдаас өөр байх ямар байдгийг тэр мэддэг байсан.

Нэг өдөр Жастин найзуудтайгаа хамт тоглоом тоглохоор явав. Тэд бөмбөгөө агаарт тогтоохын тулд гараараа цохих шаардлагатай байлаа. Тоглохоор ирсэн охидын нэг нь гараа хугалсан байж.

"За, бидний тоглохыг хараад байж байгаарай гэж тэр охинд хэлэх нь тэдэнд амар байж болох байсан.

Гэвч Жастин "Надад нэг гайхалтай санаа төрлөө. Бүгдээрээ нэг гараараа тоглоцгооё" гэв. Хүн бүр, гипс зүүсэн охин хүртэл нэг гараараа тоглов. Тэгэхэд тэд хэнийг ч орхиогүй юм.

Жастин бол миний баатар. Тэр үргэлж бусдыг ажиглаж, *Тэдэнд ямар байгаа бол?* гэж санаа тавьдаг байсан. Жастин амьдралынхаа ихэнх хугацаанд өвчтэй байсан ч бусдад тусалж, Есүс Христийг дагадаг байсан тул аз жаргалтай байдаг байсан.

Бид бүгд сорилт бэрхшээлтэй тулгардаг ч бидэнд баяр хөөртэй байх олон шалтгаан бий. Чадах бүхнээ хий. Бурханд итгэ. Өөртөө бус бусдад анхаарлаа хандуулснаар хамгийн агуу аз жаргал ирдэг юм. ●

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БАРБАРА БОНГИНИ



Абиш

Олон жилийн өмнө аавыгаа үзэгдэл үзэх үед би Бурханд хөрвүүлэгдсэн юм. Би Ламоний хаанд үйлчилж байхдаа Бурханы хүчийн талаар суралцахад нь олон хүнд тусалсан.

Хаан Ламоний

Би сайн мэдээний талаар мэдэж авахдаа үзэгдэл харсан. Би Есүсийг харсан! Би эцэгтээ гэрчлэлээ хуваалцаж, номлогчдод шоронгоос чөлөөлөгдөхөд тусалсан.

Корихор

Би хүмүүст Есүсийг бодит биш гэдэгт итгүүлэх гэж хичээсэн бөгөөд Бурхан байдаг гэсэн нотолгоог шаардсан. Би гэнэт ярьж ч, сонсож ч чадахаа больсон.

Аммон

Би Мозаягийн хөвгүүдийн нэг. Би номлолдоо Ламоний хааны хонин сүргийг хамгаалсан. Би Ламоний хаан, хатан хоёрт сайн мэдээний талаар заасан.

Антай-Нифай-Лихайчууд

Бид өмнө нь байлдах дуртай ламанчууд байсан, гэхдээ бид Бурханыг дагахаар шийдсэн. Тиймээс бид байлдааны зэвсгээ булж, дахиж хэзээ ч тулалдахгүй гэж амласан.

Залуу Алма

Намайг бошиглогч аавын минь нэрээр нэрлэсэн. Би найзуудтайгаа муу сонголт хийдэг байсан. Гэвч дараа нь бид наманчилж, номлогчид болцгоосон юм.

Би хэн бэ?—Картыг сугал

Эдгээр картыг H12–H13 хуудсан дээрх тоглоомыг тоглохдоо ашиглаарай.

Хатан

Бусад хүн нөхрийг маань үхсэн гэж бодож байх үед би түүнийг хамгаалсан. Бурханы талаар олж мэдсэний дараа миний зарц Абиш надад босоод, бусдад заахад минь тусалсан.

Ахмад Моронай

Би нифайчуудын армийн ахмад байсан ч хүмүүсийг гэмтээхийг хүсдэггүй байсан. Би хүмүүст хамгаалбал зохих хамгийн чухал зүйлийг нь сануулахын тулд эрх чөлөөний туг хийсэн.

Залуу дайчид

Бид итгэлийн талаар эхчүүдээсээ сурсан. Бидэнд гэр бүлээ хамгаалах шаардлага гарвал бидэнд Бурхан туслах болно гэдэгт итгэдэг байсан. Их Эзэн үнэхээр тусалсан юм.

Аарон

Би Мозаягийн хөвгүүдийн нэг. Би номлолдоо Ламоний хааны аав, ээжид заасан. Дараа нь тэд өөрсдийн нутаг дэвсгэрт номлогчдыг хамгаалах хууль гаргасан.

Амаликая

Би хаан болохыг маш их хүсэж байлаа! Би ламанчуудийн ахмадыг хордуулж, түүний армийг эзлэн авсан. Би хүмүүсийг хооронд нь тулалдуулж, бие биенээ гэмтээх ёстой гэдэгт итгүүлэхийг оролдсон.

Шивэгчин

Нэг хүн намайг зодох үед би энэ талаар хэн нэгэнд хэлж, тусламж хүсэх зорилгтой байсан. Би ард түмнээ хамгаалахын тулд ахмад Моронайтай хамтарч ажилласан.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭФФ ХАРВИЙ

Элигийн ТУСЛАМЖИЙН гар

Рэбэкка Райс Бөркин
(Бодит түүхээс сэдэвлэв)

“There is plenty indeed for my two hands to do” (Children’s Songbook, *272*).

Бямба гаргийн өглөө байсан ба Эли бөмбөг барихаар хаалган дээр хагас бөхийн зогссон байв. Тэр бөмбөгийг торонд оруулахгүйн тулд үсэрсэн боловч энэ бүхэн амаргүй байлаа. яг тэмцээн дуусахын алдад бөмбөг түүний гарын хажуугаар гарч, нөгөө багт оноо очив! Элигийн баг хожигджээ. Тэр маш ихээр гуниглав.

Эли маргааш нь сүм дээр ирээд, Хүүхдийн хэсэг рүүгээ урвайсан хэвээр удаан гэгч алхаж байлаа.

Эли найз Кэйтийгээ ангийнхаа гадна байхыг олж харав. Кэйтийн ээж охиныхоо ягаан тэргэнцрийг анги руу түрээд явж байлаа. Ээж нь анги руугаа явахаас өмнө Кэйтийг тэврэн харагдав.

“Сайн уу, Кэйт” гэж Эли хэлэв.

Кэйт хариулах юм уу буцаагаад даллаж чадаагүй ч үргэлж Элигийн нүд рүү хардаг байсан тул тэр өөрийг нь сонсож байгааг мэддэг байв.

Кэйт Элиг мэндлэхэд инээмсэглэдэг ч өнөөдөр тэгсэнгүй. *Кэйт гунигтай байгаа юм болов уу?* гэж Эли бодов. *Би ийм мэдрэмжийг сайн мэднэ.* Эли нөгөө багт хожлын оноо авахад саад болж чадаагүйдээ одоо ч гэсэн гуниглсаар байлаа.

Янг эгчийг хичээлээ эхлэхэд Эли Хуан, Макэлл хоёрын дэргэд суув. Тэгтэл Кэйт ёолов. Заримдаа Кэйтийн бие өвдөж байгаа үед суухад ч хэцүү байдаг байсан.

“Кэйт, чи өнөөдөр өвдөө юу?” гэж Янг эгч асуув.

Кэйт уйлж эхлэх нь тэр.

“Хүүхдийн хэсгийн дуу тусалж магад” гэж Янг эгч хэлэв.

Ангийн хүүхдүүд дуулж эхэллээ. Кэйт дуу хөгжимд дуртай байв. Тэр ихэвчлэн баяр хөөртэй дуу гарган, хамт дуулдаг байлаа. Гэвч өнөөдөр Кэйт зөвхөн уйлаад л байв.

Бид Кэйтийн сэтгэлийг засахын тулд юу хийж болох вэ?” гэж Эли гайхан бодов.

Гэтэл нэгэн санаа орж ирэх нь тэр. “Би мэдлээ!” гэж Эли Янг эгчид хэлэв. “Би Кэйтийг тэргэнцэртэй нь жаахан түрье.”

Кэйтийн ээж охиноо аргадах хэрэгтэй үед тэргэнцрийг нь зөөлөн түлхэж байхыг Эли өмнө нь харж байжээ. Тэр Кэйт дээр яаран очиж, түүний тэргэнцрийг нааш цааш аажуухан хөдөлгөж эхлэв.

Кэйт уйлахаа болив.

“Би одоо түрэх үү?” гэж Хуан асуув.

“Би ч гэсэн” гэж Макэлл хэлэв.

Янг эгчийг хичээл заах үед Эли, найзуудтайгаа хамт Кэйтийн тэргэнцрийг ээлжлэн түрж байлаа. Кэйт инээмсэглэв. Өрөө бүхэлдээ илүү гэрэлтэй болсон мэт санагдана.

Хичээл дуусахад хүн бүр инээмсэглэж байв.

“Кэйтэд туслахдаа би баяртай байдаг” гэж Эли хэлэв.

“Би баяртай байна.” “Тэнгэрлэг Эцэг ч гэсэн үүнд баярлаж байгаа. Тэр Кэйтэд хайртай бөгөөд түүний сэтгэл санааг дээрдээсэй гэж хүсдэг. Заримдаа бид

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МЭЛИССА МЭНВИЛЛ

Түүний туслахууд болох хэрэгтэй" гэж Янг эгч хэллээ.

Эли Кэйт рүү харав. "Чи инээх болгондоо надад бас тусалдаг шүү" гэж Эли түүнд хэлэв.

Кэйт инээмсэглэв.

Ели сүмээс гэртээ харихдаа зуны нарлаг өдрийн хөл бөмбөгийн талбай шиг дотроо халуун дулааныг мэдэрч байв. *Би бүх хөл бөмбөгийг барьж чадахгүй байж болно Гэвч хүмүүст туслахдаа гараа үргэлж ашиглаж чадах юм байна гэж тэр бодов.* ●

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

"Чин сэтгэлийн энэрэл, үйлчлэлээрээ дамжуулан бид үйлчилж байгаа хүмүүстэйгээ найз нөхөд болж чадна."

Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард, Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, "Finding Joy through Loving Service," *Liahona,* 2011 оны 5-р сар, 48.

Есүс хүн бүрд хайртай!

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АНТОНИ ВАНАРСДЭЙЛ

Миний хоол хийх зорилго

Фернанда Ж., 10 настай, Бразил, Парана

Би хоол хийхдээ илүү сайн болмоор байсан. Тиймээс би *Хүүхдийн гарын авлагаа* аваад, аавтайгаа хамт хоол хийх зорилго тавив. Аавыг хоол хийх тоолонд би түүнийг ажиглаж, хоол хийх ямар гоё болохыг хардаг байсан. Би түүнтэй адил хоол хийж сурахыг хүссэн юм.

Аав бид хоёр хоолонд хэрэглэх зүйлсээ худалдаж авахаар дэлгүүр явав. Дараа нь аав надад гурилаар хэрхэн сайхан бялуу хийж болохыг алхам алхмаар зааж өгсөн. Дараа нь аав бас бусад зүйлийг хэрхэн хийхийг надад зааж сургасан.

Энэ зорилгынхоо дагуу ажилласан нь надад аавтайгаа илүү ойр дотно болоход тусалсан юм. Би аавтайгаа хамт цагаа өнгөрүүлэх дуртай. Тэр бол гайхалтай багш. Хоол хийж байхдаа гар утсандаа анхаарч, анхаарлаа сарниулж болохгүй гэж аав надад заасан юм.

Би хоол хийх дуртай болохоор хоол хийх тухай бодох төдийд л баяр баясгаланг мэдэрдэг! Энэ зорилго нь надад зөвхөн дуртай зүйлээ хийгээд зогсохгүй сүнслэг байдлаараа өсөхөд тусалдаг. Би өөрийн зорилгуудыг сонгох болсондоо баяртай байна. Тэнгэрлэг Эцэг намайг авьяас чадвараа хөгжүүлээсэй гэж хүсдэг тул энэ зорилгод маань туслахыг хүсдэг. Энэ нь намайг аз жаргалтай болгодог гэдгийг Тэр мэддэг учраас надад туслахыг хүсдэг. ●

Хүүхдүүдийн гарын авлага тань Есүст илүү ойртох зорилго тавихад туслах болно.

Эцэг эх юм уу хүндэлж биширдэг өөр хүнээс шинэ зүйл зааж өгөхийг хүс.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЖОНАС РЭБИКИ

Абиш сайн мэдээг хуваалцсан

Абиш гэдэг эмэгтэй хааны төлөө ажилладаг байв. Тэр Бурханд итгэдэг байсан. Эргэн тойрных нь ихэнх хүн Бурханд итгэдэггүй байв. Нэгэн өдөр тэр Аммон гэдэг номлогчийг хаан, хатан хоёрт Бурхан, Есүс Христ хоёрын тухай зааж байгааг харжээ.

Хаан, хатан хоёр сайн мэдээний талаар мэдээд, ихэд баярлав! Тэд газарт унаж, хөдөлгөөнгүй болсон байв. Абиш тэднийг Бурханы хүчийг мэдэрч байгааг мэдэж байлаа.

Абиш хүн бүрийг Бурханы тухай мэдэж аваасай гэж хүсэж байв. Тиймээс тэр байшингаас байшин руу гүйж, хүмүүст юу болсныг ирж, хар хэмээн хэлж байв.



Олон хүн цугларсны дараа Абиш хатанд босож зогсоход нь тусалжээ. Тэгэхэд хатан хаанд босож зогсоход нь туслав. Тэд хүмүүст сайн мэдээний тухай зааж эхэлсэн.

ЗУРГИЙГ АПРИЛ СТОТТ

Би ч гэсэн Абиштай адилхан байж чадна. Би Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай мэдэж авахаднь бусдад тусалж чадна. ●

Энэ түүхийн талаар Алма 18–19-өөс уншина уу.

Абиш Бурханд итгэдэг байсан

ЗУРГИЙГ АПРИЛ СТОТТ

Чи Бурханы тухай мэдэж авахад нь хүмүүст хэрхэн туслах вэ?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ

Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Энэ сард бид Залуу Алма, Абиш, Мозаягийн хөвгүүд гэх мэт номлогчдын талаар уншина. Та Мормоны Номон дээрх эрэгтэй, эмэгтэйчүүдийн талаар ярихдаа H12–13 хуудсан дээрх тоглоомыг юм уу H20 хуудасны түүхийг ашиглаж болно. Тэд бүгд сайн мэдээг өөр өөр арга замаар хуваалцсан. Гэр бүл тань сайн мэдээг хэрхэн хуваалцаж болох вэ? Энэ сард туршиж үзэх нэг номлогчийн зорилгоо бич. H10-аас таалагдсан санаагаа хуулсан ч болно.

Үргэлжлүүлэн хуваалцаарай!
Найз

ХҮҮХДИЙНХЭЭ БҮТЭЭЛ ЭСВЭЛ ТУРШЛАГЫГ *ЛИАХОНА* СЭТГҮҮЛ РУУ ХЭРХЭН ИЛГЭЭХ ВЭ?
Та liahona.ChurchofJesusChrist.org вэбсайт руу ороод, “Submit an Article or Feedback” дээр дарна уу. Эсвэл үүнийгээ хүүхдийнхээ нэр, нас, оршин суугаа хот болон “Би, [нэрээ бич], Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд хүүхдийнхээ илгээж буй зүйлийг Сүмийн сэтгүүл, вэбсайтуудад болон хэвлэл мэдээллийн бусад тавцан мөн Сүмийн тайлан, хэвлэх материал, дүрс бичлэг, хэвлэл, сургалтын материалууд дээр ашиглахыг зөвшөөрч байна” гэсэн зөвшөөрлийн маягтын хамт liahona@ChurchofJesusChrist.org хаягаар бидэнд илгээнэ үү. Бид таныг сонсохыг тэсэн ядан хүлээж байна.

Дотор нь нуусан Лиахонаг олоорой!

***НАЙЗ* СЭТГҮҮЛИЙН ХАВТСАН ДЭЭР**
Зургийг Диллин Марш

ГАРЧИГ

H2 Тэргүүн Зөвлөлөөс: Гэрчлэл ба Мормоны Ном
H4 Кэллигийн залбирал
H6 Сайн байна уу? Германаас мэндчилж байна!
H8 Далайн морь шиг сэлсэн нь
H10 Зугаатай ажил: Загварыг дуусга
H11 Үзүүл мөн тайлбарла
H12 Би хэн бэ?
H14 Найзаас найзад: Хэнийг ч орхиогүй
H15 Би хэн бэ?—Картыг сугал
H16 Элигийн тусламжийн гар
H18 Ухаалаг санаа
H19 Миний хоол хийх зорилго
H20 Судрын түүхүүд: Абиш сайн мэдээг хуваалцсан
H23 Будах хуудас: Абиш Бурханд итгэдэг байсан

© 2020 BY INTELLECTUAL RESERVE, INC. БҮХ ЭРХ ХАМГААЛАГДСАН

MONGOLIAN
4 02167 21363 5